

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл

2013 он, Цуврал 6 (46)

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ

/ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Монголын арбитрын практикт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж хэвшүүлэх асуудалд 7

ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор И.Идэш

Эвлэрүүлэн зуучлалыг оновчтой явуулахад анхаарах асуудлууд 19

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч П.Золзаяа

ЭРХ ЗҮЙ, СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Аж ахуйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх боломж, давуу тал ба анхаарах асуудал: шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулах нь 24

ХЗҮХ-ийн дэд захирал Хууль зүйн ухааны доктор Б.Амарсанаа

Хөдөлмөрийн маргаантай хэргийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт 31

МУИС-ийн ХЭС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн гишүүн С.Болормаа

Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны онцлог 37

Хууль зүйн чндэсний хүрээлэнгийн бодлогын судлаач С.Батбаяр

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ, АСУУДАЛ

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Монгол улсад хөгжүүлэхэд Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн гүйцэтгэх үүрэг: үйл ажиллагаа, чиг хандлага 42

Монгол улсын Дээд шүүхийн шүүгч, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн дарга Д.Тунгалаг

Зам тээврийн осолтой холбоотой маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх нь 53
ЖАЙКА-гийн “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”-ийн хуулийн зөвлөх Б.Оюу

Эвлэрлийн гэрээ түүнд тавигдах шаардлага 57
Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн гишүүн, Монгол-Өмгөөлөгч хууль зүйн фирмийн захирал Э.Сүхбаатар

ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

Гадаад орнуудын туршлага ба эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь 61
МУИС-ийн ХЭС-ийн багш, Хууль зүйн ухааны доктор(LL.D), дэд профессор Д.Ганзабаатар

Япон улс дахь эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр бус байх тухай онолын маргаан 66
ЖАЙКА-ийн мэргэжилтэн (J.D.) Ока Хидео

СУДАЛГААНЫ ТОЙМ

Цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалт, Бодлогын судалгааны товч тайлан 69
ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төв

Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн тухай товч танилцуулга 90
Монгол улсын Дээд шүүх, ЖАЙКА болон Монголын өмгөөлчдийн холбооны хамтарсан “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”

Энэ дугаарыг ЖАЙКА олон улсын байгууллагын “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран гаргав.

CONTENT

BEFORE CREATING A LAW

(UNDERLINING ARTICLE, INTERVIEW)

Issues of Using Mediation in the Mongolian Arbitral Practice

(I.Idesh, Doctor, Head of Legal Research Center of National Legal Institute)

7

Issues of Effective Use of Mediation

(P.Zolzaya, Judge of Appellate Court for Civil Cases)

19

LEGAL THOUGHTS: REFLECTION

Opportunity, Advantages and Issues of Resolving Business Disputes through Mediation: Comparison of Court Proceedings and Mediation

(B.Amarsanaa, Doctor, Vice-Director of National Legal Institute)

24

Legal Regulation of Labor Dispute Resolution through Mediation

(S.Bolormaa, Senior Lecturer, Doctoral Candidate of School of Law of National University of Mongolia and Member of Mediation Committee)

31

Specific Nature of Family Dispute Resolution through Mediation

(S.Batbayar, Policy Researcher of National Legal Institute)

37

IMPLEMENTATION OF LAW, EFFICIENCY, PROBLEMS

The Mediation Committee's Responsibility for Developing Mediation in Mongolia: Functions and Scope of Activities

(D.Tungalag, Judge of the Supreme Court of Mongolia, Chair of Mediation Committee)

42

Resolving Disputes of Traffic Accidents through Mediation

(B.Oyu, Legal Advisor to the Project of JICA "Strengthening Mediation System in Mongolia")

53

Mediation Agreement and Its Legal Requirements

(Z.Sukhbaatar, Member of Mediation Committee, Director of Mongol-Umguulugch Law Firm)

57

INTERNATIONAL PRACTICE

Foreign Practices and Evaluation of Mediation Consequences

(D.Gangabaatar, Doctor and Associate Professor of School of Law of National University of Mongolia)

61

Theoretical Disputes over Invalidness of Mediation in Japan

(Oka Hideo, Juris Doctor, Specialist at JICA)

66

RESEARCH OVERVIEW:**The Protection of Children on Internet Online**

Summary of Research Paper of National Legal Institute

(Legal Research Center of National Legal Institute)

69

Short Introduction to the Project “Strengthening Mediation System in Mongolia”

(“Strengthening Mediation System in Mongolia” Project, co-managed by the Supreme Court of Mongolia, JICA and Mongolian Bar Association)

90

This special issue is published within the cooperation framework of the
National Legal Institute of Mongolia and project
“Strengthening Mediation Systems in Mongolia” of JICA.
Publication of the issue was financed by the project.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ж.Амарсанаа	Үндсэн хуулийн цэцийн дарга
Б.Амарсанаа	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэд захирал
А.Бакей	УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
Б.Баярсайхан	Хууль зүйн доктор
Д.Баярсайхан	Хууль зүйн доктор
Ж.Баярцэцэг	ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
Б.Билэгт	ЦЕГ-ын дарга
Ж.Бямбадорж	Хүний эрхийн үндэсний комиссын дарга
Д.Ганбат	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга
Б.Гүнбилэг	Хууль зүйн доктор
Д.Дорлигжав	Улсын Ерөнхий Прокурор
Н.Жанцан	Хууль зүйн доктор
Ц.Зориг	Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
В.Оюумаа	Хууль зүйн доктор
Ч.Өнөрбаяр	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх
Д.Солонго	МУИС-ийн ХЭС-ийн захирал
Ш.Түвдэндорж	УИХ-ын Хууль зүйн бодлогын байнгын хорооны дарга
Х.Тэмүүжин	Хууль зүйн сайд
Б.Тэмүүлэн	Хууль зүйн доктор
П.Цагаан	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
Ч.Энхбаатар	Хууль зүйн шинжлэх ухааны доктор
А.Эрдэнэцогт	Хууль зүйн доктор

Ерөнхий эрхлэгч

Х.Номингэрэл

Эрх.1эгч

И.Идэш

Хариуцлагатай нарийн бичгийн дарга

Д.Нямбаяр

Хэв.1э.ийн эхийг

Б.Цэрэнлхам

Улсын бүртгэлийн дугаар:279

ISSN:2226-9185

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 6 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар - 46,

Чингэлтэй дүүрэг, Их Эзэн Чингисийн талбай-7

Утас: +(976)-11-315735

Факс: 315735

Вэб хуудас: www.legalinstitute.mn

Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	<i>Chairman, Constitutional Court of Mongolia</i>
B.Amarsanaa	<i>Vice Director of the National Legal Institute</i>
A.Bakei	<i>Chairman, Standing Committee on State Structure of State Great Hural of Mongolia</i>
B.Bayarsaikhan	<i>Ph.D</i>
D.Bayarsaikhan	<i>Ph.D</i>
J.Bayartsetseg	<i>State Secretary, Ministry of Justice of Mongolia</i>
B.Bilegt	<i>Chief, General Police Department of Mongolia</i>
J.Byambadorj	<i>Chief Commissioner, National Human Rights Commission of Mongolia</i>
D.Ganbat	<i>Chairman, the Sub Committee on Human Rights of State Great Hural of Mongolia</i>
B.Gunbileg	<i>Ph.D</i>
D.Dorligjav	<i>General Prosecutor of Mongolia</i>
N.Jantsan	<i>Ph.D</i>
Ts.Zorig	<i>Chief Justice, Supreme Court of Mongolia</i>
V.Oyumaa	<i>Ph.D</i>
Ch.Unurbayar	<i>Legal Advisor to the President of Mongolia</i>
D.Solongo	<i>Dean, School of Law, National University of Mongolia</i>
Sh.Tuvdendorj	<i>Chairman, Standing Committee on Legal Policy of State Great Hural of Mongolia</i>
Kh.Temuujin	<i>Minister of Justice</i>
B.Temuulen	<i>Ph.D</i>
P.Tsagaan	<i>Head, the Office of the President</i>
Ch.Enkhbaatar	<i>Sc.D</i>
A.Erdenetsogt	<i>Ph.D</i>

Editor-in-Chief

Kh.Nomingerel

Executive Editor-in-Chief

I.Idesh

Acting Assistant Editor

Nayambayar

Designed by

B.Tserenlkham

State Registration Number:279
ISSN: 2226-9185
Published by the National Legal
Institute. Six issues in a Year.

Address: Ulaanbaatar-46, Chingeltei District,
Great Chinggis Khaan Square -7
Phone: +(976)-11-315735
Fax: 315735
Website: www.legalinstitute.mn
E-mail: Lawjournal@legalinstitute.mn

МОНГОЛЫН АРБИТРЫН ПРАКТИКТ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫГ ХЭРЭГЛЭЖ ХЭВШҮҮЛЭХ АСУУДАЛД



ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны
төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны
доктор И.Идэш

Түлхүүрүг: иргэний эрх зүйн маргаан, шүүх, арбитрын практик, маргаан шийдвэрлэх альтернатив арга, хөндлөнгийн гуравдагч этгээд, зуучлал, эвлэрүүлэн зуучлал

1. Удиртгал

2003 оны 5-р сарын 9-ны өдөр Улсын Их Хурлаас Арбитрын тухай хууль батлагдсанаар Гадаад худалдааны арбитр нь Монголын Үндэсний Арбитр болж өөрчлөн байгуулагдаж, гадаад, дотоодын бизнесийн маргааныг арбитр, зуучлалын аргаар шийдвэрлэх, арбитрыг сурталчлах, олон нийтэд таниулах, сургалт судалгаа хийх зэрэг үйл ажиллагаа явуулж эхэлжээ.¹ Монголын Үндэсний Арбитр

үйл ажиллагаагаа улсын хэмжээнд явуулах үүднээс салбар арбитруудаа 21 аймагт байгуулснаас гадна арбитрын хууль тогтоомжийн актанд нэмэлт өөрчлөлт оруулах, зохигчдод тодорхой үйлчилгээ үзүүлэх, иргэний эрх зүйн маргааныг арбитрын аргаар шийдвэрлэх шинэ механизмыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирлээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд МҮХАҮТ -ын дэргэдэх байнгын арбитр болон арбитрын зарим байгууллагууд тогтмол үйл ажиллагаа явуулах болсон боловч арбитрт хандах иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэхгүй, шүүхийн ачаалал буурахгүй байсаар л байна. Тухайлбал, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Үндэсний Арбитраар¹ 2011 онд 41 хэрэг, 2012 онд 45 хэрэг, 2013 оны эхний 9 сарын байдлаар 25 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.²

Арбитрт хандах иргэн, хуулийн этгээдийн тоо ийнхүү нэмэгдэхгүй байгаа явдал нь зарим талаар Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитр (МОУҮА) зуучлалын ажиллагаа явуулахгүй байгаа, арбитраар шийдвэрлэсэн хэргийн дөнгөж 3 хувийг гадаадын хуулийн этгээд болон хувь хүмүүс оролдсон олон улсын хувийн эрх зүйн маргаан эзэлж байгаа, түүнчлэн байнгын бус болон түр арбитрын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж хөгжүүлэх

¹ Монголын арбитрын хууль тогтоомжийн хөгжил, 2003 оны Арбитрын тухай хуульд орсон эрх зүйн шинэ зохицуулалт, Гадаад худалдааны арбитрын талаар энэхүү өгүүлэлд дэлгэрүүлж авч үзээгүй учир энэ талаар И. Идэш. Новый закон Монголии об арбитраже 2003 года: Юридические аспекты сопоставления арбитражных решений в судах. Эрдэнэт- хөгжил. Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, судалгааны сэтгүүл. 2005 № 2(9) нийтлэлээс тодруулж үзнэ үү.

² 2012 оны 12 дугаар сараас Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитр гэж нэрлэгдэх болсон.

³ Ч.Гүнжагва. Монгол улсын арбитрын эрх зүйн өнөөгийн байдал. "Монгол улсын арбитрын эрх зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт олон улсын семинарт тавьсан илтгэл. 2013 оны 9 дүгээр сарын 27, МҮХАҮТ -ын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитр, Улаанбаатар

шаардлагатай байгаа зэрэг арбитрын эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлаас улбаатай нь маргашгүй¹. Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд юуны өмнө МОУҮА-аар шийдвэрлэх олон улсын хувийн эрх зүйн маргааны тоог нэмэгдүүлэх, маргааныг зуучлал болон бусад аргаар шийдвэрлэх эрх зүйн орчинг сайжруулах, маргаан шийдвэрлэх альтернатив арга (alternative dispute resolution or "ADR") -ыг арбитрын практикт хэрэглэж хэвшүүлэх, 2003 оны Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Яагаад гэвэл олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикт нийт маргааны 16 хувийг маргаан шийдвэрлэх альтернатив аргаар, харин 44 хувийг арбитр болон альтернатив бусад арга (international arbitration + ADR) -ыг хослуулан хэрэглэсний үндсэн дээр шийдвэрлэж байна. Мөн Лондонгийн Queen Mary University их сургуулийн хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан компани, үйлдвэрийн газруудын удирдах ажилтнуудын 73 хувь нь арбитрыг маргаан шийдвэрлэх бусад аргатай хослуулан хэрэглэснээр иргэний болон худалдааны эрх зүйн маргааныг шуурхай, бага зардлаар шийдвэрлэх бололцоотой гэж хариулсан² нь МОУҮА болон арбитрын бусад байгууллагуудын үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах, ялангуяа арбитрын практикт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж, хэвшүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Дээрхээс үзэхэд манай улсын хувьд гадаад орнуудын шүүх, арбитрын практикт өргөн хэрэглэж байгаа маргаан шийдвэрлэх альтернатив арга, тэдгээрийн хууль зүйн үр дагаврыг арбитрын эрх

зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ялангуяа, эвлэрүүлэн зуучлал болон бусад аргыг Монголын арбитрын өнөөгийн практикт хэрэглэж хэвшүүлэх үүднээс олон талаас нь судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг харгалзан гадаад орнуудын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик, олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикт хэрэглэж хэвшсэн маргаан шийдвэрлэх арга, тэдгээрийн төрлүүд, Монгол улсад зуучлалын журмаар маргаан шийдвэрлэж байгаа өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчин гэсэн үндсэн гурван асуудлыг тодруулан авч үзье.

2. Гадаад орнуудын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик

Гадаадын хуульч эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгаанаас үзэхэд АНУ болон бусад улсын түүхэнд уутуул иргэд, шилжин суугчдын хооронд үүссэн дайн, мөргөлдөөн, газар эзэмшилтэй холбоотой маргааныг гуравдагч этгээд буюу зуучлагч (mediator) - ийн оролцоотойгоор бүр XVII зуунаас өмнө шийдвэрлэж байжээ. АНУ -ын муж улсуудын худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжин хөгжихийн хэрээр XIX зууны сүүлчээр маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх практик далайн тээвэр, худалдаа, аж үйлдвэрийн салбарт өргөн дэлгэрчээ. XX зууны эхнээс маргааныг хөндлөнгийн гуравдагч этгээдийн оролцоотойгоор шийдвэрлэх эрх зүйн механизм улам боловсронгуй болон хөгжсөнөөр зуучлалын ажиллагааг зохицуулсан эрх зүйн актууд АНУ -ын зарим муж улсуудад батлагдсан байна.

Аажмаар шүүхийн практикт маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх хандлага давамгайлах болсны улмаас 1950-иад оны дунд үеэс АНУ, Их Британи, Австри зэрэг орнуудад маргааныг хөндлөнгийн этгээдийн оролцоотойгоор шийдвэрлэх тогтолцоог хуульчлан мөрдүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг

¹ I. Idesh. Mongolia's Arbitration Law: Some Challenging Issues of Legal Regulation of Arbitration. Presentation. The 8 th ALIN Expert Forum. Current Legal Issues in Asian Countries. 2013.12. KLRI. Asian Legal Information Network. Seoul. Korea. P.25

² Jan Paulsson, Nigel Rawding, Lucy Reed. The Freshfields Guide to Arbitration Clauses in International Contracts. Third Edition. Wolters Kluwer. 2011 Kluwer Law International. P. 12

хэрэгжүүлсэн нь хуульч эрдэмтэн, судлаачдын анхаарлын төвд байх болж, одоо ч байсаар байна.

Ийнхүү 1960-аад оноос АНУ болон Их Британи улсын туршлагаар Европын орнуудад маргаан шийдвэрлэх альтернатив аргыг шүүхийн болон арбитрын практикт өргөн хэрэглэж эхэлсэн¹ бөгөөд одоо гадаад орнуудад эвлэрүүлэн зуучлалын хууль тогтоомж үүсч хөгжсөн түүхэн нөхцөл байдлыг товчоолон авч үзье.

2.1 Гадаад орнуудад эвлэрүүлэн зуучлалын хууль тогтоомж үүсч хөгжсөн түүхэн нөхцөл байдал

Энэхүү өгүүллийн 2-р хэсгийн эхэнд дурдсанчлан, XIX зууны сүүлчээс эхлэн АНУ -д маргааныг зуучлагчийн оролцоотой шийдвэрлэх практик далайн тээвэр, үнэт цаас, хөвөн болон торгоны салбарт өргөн дэлгэрснээр барахгүй тэр ч байтугай ажил олгогч эзэд болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын хооронд үүссэн хөдөлмөрийн харилцааны маргааныг шийдвэрлүүлэхээр эвлэрүүлэн зуучлах комиссын гишүүд (commissioners of conciliation) -ийг томилж байх эрхийг Конгресс 1913 онд АНУ -ын Хөдөлмөрийн яамны төрийн нарийн бичгийн дарга (secretary of labor) -д олгож байжээ.² Хөдөлмөрийн харилцааны маргаан шийдвэрлэх эрх зүйн механизм аажмаар боловсронгуй болсон учраас 1930- 1940 онуудад АНУ-д хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх чиг үүрэгтэй Холбооны Зуучлал, эвлэрүүлэн зуучлалын агентлаг (Federal Mediation and Conciliation Services) байгуулж, маргаан шийдвэрлэдэг мэргэжлийн хүмүүс (professional dispute settlers: negotiators, mediators, arbitrators) бий болсон нь маргааныг шүүхийн бус

замаар шийдвэрлэх ажиллагааг хуульчлах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Яваандаа АНУ болон бусад аж үйлдвэржсэн орнуудад хөндлөнгийн этгээдийн оролцоотойгоор шийдвэрлэх маргааны хүрээ улам бүр өргөжин маргаан шийдвэрлэх байгууллагуудын гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, шийдвэрлэх арга зүй боловсронгуй болсноор хөдөлмөр, газар эзэмшил, байрны түрээс, гэр бүлийн харилцаанаас үүссэн иргэний эрх зүйн маргааныг зуучлагчийн тусламжтайгаар шийдвэрлэх практик өргөн дэлгэрээд байсан боловч 1970-аад онуудад шүүхийн ачаалал хэт нэмэгдсэний улмаас ялангуяа, иргэний-эрх зүйн маргааныг шийдвэрлэх уян хатан механизмыг бий болгох шаардлага зүй ёсоор тулгарчээ. Энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс Харвардын их сургуулийн профессор Фрэнк Сандер маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх тогтолцоог бий болгох саналыг 1976 онд хуралдсан Бага хурал (Pound Conference) -ын үеэр дэвшүүлснээр маргаан шийдвэрлэх альтернатив тогтолцоо АНУ -д анх үүсч бусад орнуудад дэлгэрэх эхлэл тавигдсан байна.¹

Улмаар АНУ -д Харвардын их сургуулийн профессор Франк Сандерийн санал болгосон загвараар шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх хөтөлбөрийг 1976 оноос Америкийн Арбитрын Ассоциацийн идэвхтэй оролцоотойгоор хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгснөөр барахгүй маргаан шийдвэрлэх альтернатив аргыг хөгжүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн актын төсөл боловсруулахад чухал алхам болжээ.² АНУ -ын бүх муж улсад хэрэгжүүлсэн энэ хөтөлбөрийн хүрээнд Техас, Флорида зэрэг муж улсуудад

¹ Лебсдев.Н.Ю. Медиация как способ разрешения конфликтов в уголовном производстве: назревшая необходимость или дань моде?. Закон и право. 2013 №11. Издательство "Юнити -Дана", Москва. С.94

² Linda R.Singer. Settling Disputes. Conflict Resolution in Business, Families, and the Legal System. Westview Press. Boulder, San Francisco, & London. P.6

¹ Menkel-Meadow, Love, Schneider. Mediation. Practice, Policy, and Ethics. Aspen Publishers, Inc. New York. 2006. P.99

² Linda R.Singer. Дээр дурдсан бүтээл. P. 165

шүүгч иргэний эрх зүйн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэхээс өмнө зуучлалын аргаар шийдвэрлүүлэхээр шаардах эрхтэйг хуульчилсан эрх зүйн акт батлагджээ. Ялангуяа, 1983 онд нэмэлт өөрчлөлт орсон Иргэний байцаан шийтгэх ажиллагааны холбооны дүрэм (Federal Rules of Civil Procedure) - д "... шүүгч маргаан шийдвэрлэх альтернатив арга (ADR process) хэрэглэхийг шаардаж болно." гэж зааснаар Америкийн шүүхийн практикт иргэний эрх зүйн маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх хандлага илт давамгайлах болсон байна.¹

Гэвч удалгүй маргаан шийдвэрлэх альтернатив аргыг арбитрын практикт илүү өргөн хэрэглэх болсон² бөгөөд одоо гадаад орнуудад иргэний эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалын аргаар хэрхэн шийдвэрлэж байгаа талаар авч үзье.

2.2 Гадаад орнуудын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны практик

АНУ-ын болон бусад орны туршлагаас үзэхэд иргэний эрх зүйн маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх явцад ялангуяа, зуучлалын ажиллагаанд тэтгэвэрт гарсан шүүгч, арбитрч болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулж байгаа нь юуны өмнө маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх ажиллагааны онцлог, арга зүйтэй холбоотой аж. Жишээ нь 1990 оны Иргэний шүүх эрх мэдлийн тогтолцооны шинэчлэлийн тухай хууль (Civil Justice Reform Act) - ийг хэрэгжүүлэх үүднээс АНУ -ын муж улсуудад шүүхийн практикт анх төлөвшин хөгжсөн зуучлал болон бусад аргыг иргэний эрх зүйн маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээс өмнө хэрэглэж байхаар хуульчилжээ.

¹⁰ Menkel-Meadow, Love, Schneider. Дээр дурдсан бүтээл. Р.390

¹¹ Олон улсын ариалгааны арбитр. МҮХАҮТ -ын дэргэдэх МҮА, Улаанбаатар, 2008, 53-р хуудас эр дурдсан бүтээл. Р.390

Ер нь АНУ -ын муж улсуудад маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх ажиллагаа, механизмыг хуульчилсан эрх зүйн актуудаас гадна Маргаан шийдвэрлэх үндэсний институт (National Institute for Dispute Resolution), Америкийн Арбитрын Ассоциаци, Америкийн Барын Холбоо, Маргаан Шийдвэрлэх Ассоциаци (Association for Conflict Resolution) зэрэг мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын боловсруулж мөрдүүлсэн Зуучлалын нэгдмэл хууль (Uniform Mediation Act), Зуучлагчдын үйл ажиллагааны загвар стандарт (Model Standards of Conduct for Mediators) зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд зуучлагчид тавигдах шаардлага (тухайлбал, тухайн салбар эрх зүйн мэдлэг, дадлага, туршлага, хараат бус байх чадвар г.м), зуучлагч, гуравдагч этгээдийн эрх, үүрэг, сонирхлын зөрчил, зуучлалын ажиллагааны үе шат, зуучлалын ажиллагааг дуусгавар болгох үндэслэл, эвлэрлийн гэрээ зэрэг асуудлыг зохицуулсан байна.¹

АНУ-ын туршлагаар² 1990 -ээд оноос эхлэн Канад, Англи, Герман, Австрали, Шинэ Зеланд, Скандинавын болон Зүүн Европын орнуудад зуучлал (mediation)-ыг шүүх болон арбитрын практикт нэвтрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд гадаад орнуудад маргаан шийдвэрлэх альтернатив аргаар шийдвэрлэсэн хэргийн тоо жилээс жилд нэмэгдэж, эдгээр аргыг олон улсын худалдаа, интернетийн сүлжээний үйлчилгээ зэрэг эрчимтэй хөгжиж буй

¹² Эдгээр асуудлын талаар тухайлбал, Model Rule of Professional Conduct for the Lawyer as Third -Party Neutral, CPR- Georgetown Commission on Ethics and Standards in ADR (2004), ADA Mediation Guidelines, CPR International Institute for Conflict Prevention and Resolution Mediation Procedure, Model Rules of Professional Conduct (2004) (Selected Rules and Comments), American Bar Association зэрэг эрх зүйн баримт бичгээс тодруулж үзнэ үү. Menkel-Meadow, Love, Schneider. Дээр дурдсан бүтээл. 599-659-р хуудас

¹³ АНУ -ын муж улсуудын зуучлал болон эвлэрүүлэн зуучлалын хууль тогтоомж, шүүх, арбитрын практикт төлөвшин хөгжсөн маргаан шийдвэрлэх альтернатив арга, тэдгээрийн онцлог шинжийн талаар энэхүү өгүүлэлд дэлгэрүүлж авч үзээгүй тул энэ талаар Menkel-Meadow, Love, Schneider. Дээр дурдсан бүтээл. Linda R. Singer. Дээр дурдсан бүтээлээс тус тус тодруулж үзнэ үү.

бусад салбарт өргөн хэрэглэх боллоо.

Өнөө үед АНУ -д Маргаан шийдвэрлэх олон улсын институт (International Institute for Conflict Prevention and Resolution, "CPR"), Маргаан шийдвэрлэх олон улсын төв (International Centre for Dispute Resolution, "ICDR"), Бразилд Бразил-Канадын худалдааны танхимын арбитр, зуучлалын төв (Arbitration and Mediation Center of the Brazil- Canada Chamber of Commerce, "CCBC"), Их Британид Маргааныг үр дүнтэй шийдвэрлэх төв (Centre for Effective Dispute Resolution, "CEDR"), Арбитрчдын мэргэшлийн институт (Chartered Institute of Arbitrators, "CIArb"), БНХАУ -д Хятадын олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комисс (China International Economic and Trade Arbitration Commission, "CIETAC") зэрэг байгууллагууд олон улсын хувийн эрх зүйн болон бизнесийн маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх механизмыг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааны ажил хийж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам боловсруулж байна.

Ингэхлээр гадаад орнуудад олон улсын хувийн эрх зүйн болон бизнесийн маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх эрх зүйн орчин сайжирч байгаа төдийгүй олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикт зуучлалын аргаар шийдвэрлэсэн хэргийн тоо байнга нэмэгдэх хандлага гарч байна. Энэ нь арилжааны арбитрын байгууллагууд зуучлал болон маргаан шийдвэрлэх бусад аргыг зохицуулсан дүрэм, журмаа шинэчилсэн, тэдгээрийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах аргачлал, арга зүй улам боловсронгуй болсонтой холбоотой.

3. Олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикт хэрэглэж хэвшсэн маргаан шийдвэрлэх арга, тэдгээрийн төрлүүд

Олон улсын хуулийн фирм, хуульч эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгаанаас

үзэхэд 2000-2010 онуудад дэлхийн улс, орнуудад иргэний болон худалдааны эрх зүйн маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх хандлага илт давамгайлах болсон учраас ЮНСИТРАЛ, Парисын Арбитрын олон улсын шүүх, (International Court of Arbitration, ICC), Олон улсын арбитрын Лондонгийн шүүх, (London Court of International Arbitration, LCIA), Америкийн Арбитрын Ассоциаци, (American Arbitration Association, AAA), Стокгольмын арбитрын институт, (Arbitration Institute of the Stockholm Chamber of Commerce, SCC), Хятадын эдийн засаг олон улсын худалдааны төв, (the Chinese International Economic and Trade Center, CIETAC), Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв, (ICSID) зэрэг олон улсын арилжааны арбитрын байгууллагууд маргааныг альтернатив аргаар шийдвэрлэх журмаа хянан үзэж шинэчлэн батлаад байна.¹

Дээр дурдсан олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикт гол төлөв хэлэлцээ хийх (negotiation), зуучлах (mediation), эвлэрүүлэн зуучлах (conciliation), арбитрын эвлэрүүлэх ажиллагаа явуулах (non-binding arbitration), шинжээчийн дүгнэлт гаргуулах (expert opinion), хөндлөнгийн этгээдийн үнэлгээ, дүгнэлт гаргуулах (early neutral evaluation), хялбарчилсан шүүн таслах ажиллагаа явуулах (adjudication) зэрэг маргаан шийдвэрлэх альтернатив аргыг хэрэглэж хэвшүүлжээ.² Эдгээр аргыг тухайн

¹ Олон улсын арилжааны арбитрын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн чиг хандлага, байнгын арбитрын байгууллагуудын хүрээнд хийсэн сүүлийн үеийн зохион байгуулалтын болон бусад шинэчлэлийн талаар энэхүү өгүүлэлд дэлгэрүүлж авч үзээгүй тул энэ талаар Jan Paulsson, Nigel Rawding, Lucy Reed, Дээр дурдсан бүтээлээс тодруулж үзнэ үү.

² АНУ-ын эрх зүйн эдгээр ухагдахуун, нэр томъёог бусад улс, орнууд болон олон улсын арилжааны арбитрын байгууллагууд англи хэлнээс орчуулан дотоодын хууль тогтоомж болон маргаан шийдвэрлэх дүрэм, журамдаа уламжлан авахдаа тухайн нэр томъёо, АНУ-д эвлэрүүлэн зуучлалын хууль тогтоомж үүсч хөгжсөн түүхэн нөхцөл байдлыг судлан үзсэний дээр хэрэглэдэг. Ийм учраас Монголын хуульч эрдэмтэн, судлаачид "Alternative Dispute Resolution", "mini-trial" зэрэг нэр томъёог өөр өөрөөр

маргааны онцлогт тохируулан хэрэглэхээс гадна гэрээний талууд харилцан буулт хийх замаар тодорхой тохиролцоонд хүрснээр өөрсдийн тогтоосон ажил хэргийн харилцаагаа цаашид үргэлжлүүлэх боломжтой байдаг. Чухам үүнд л маргаан шийдвэрлэх альтернатив аргуудын нийтлэг шинж орших бөгөөд талууд тодорхой тохиролцоонд хүрч чадах эсэх нь юуны өмнө тэднээс хараат бус хөндлөнгийн гуравдагч талын ур чадвар, гүйцэтгэх үүргээс ихээхэн хамаарна. Одоо эдгээр аргыг хэрэглэснээс ямар үр дүн гардаг, хөндлөнгийн гуравдагч этгээдийн тухайн тохиолдол бүрт гүйцэтгэх үүргийн талаар цухас авч үзье.

Олон улсын арилжааны арбитрайн байгууллагуудын практикт хэлэлцээ хийх аргыг ихэвчлэн маргааныг арбитрайн байгууллагад шилжүүлэхээс өмнө тухайн олон улсын худалдааны контрактын талуудын хооронд үүссэн маргаантай техникийн болон бусад асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэж байна. Худалдааны контракт, гэрээний талуудын эрх бүхий төлөөлөгчид шууд хэлэлцээ хийсний үр дүнд олон жил хамтран ажилласан түншүүдийн гэрээт эрх зүйн харилцаа цаашид хэвээр үргэлжилдэг. Энэ тохиолдолд хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх, уулзалт зохион байгуулах зэрэг үйлчилгээг арбитрайн байгууллага талуудад үзүүлэх боломжтой. Зуучлал (mediation) - ын хувьд талуудын сонгож авсан гуравдагч хөндлөнгийн этгээд зуучлагчийн хувиар талуудыг өөр хоорондоо хэлэлцээ хийх замаар маргаанаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх учиртай. Зуучлагч маргалдагч тал тус бүртэй тусад нь эсвэл хамтад нь уулзах эсэх асуудлыг тухайн маргалдагч талууд шийдвэрлэдэг онцлогтой. Ихэнх тохиолдолд зуучлагч (mediator) зөвлөмж, шийдвэр гаргах ёсгүй учраас зуучлагчийн үйл ажиллагаа тэр болгон үр дүнтэй байдаггүй байна.

Харин эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хувьд эвлэрүүлэн зуучлагч (conciliator) нь талуудын хийх хэлэлцээрийн явцад идэвхтэй үүрэг гүйцэтгэж, тэдэнд зөвлөмж өгч, маргаантай асуудлыг шийдвэрлэх хувилбарыг ч санал болгох боломжтой.¹ Талуудын баримталж байгаа байр суурийг тодруулах үүднээс эвлэрүүлэн зуучлагч маргалдагч тал тус бүртэй тусад нь уулзах боломжтой ч эвлэрүүлэн зуучлагчийн хувьд талуудыг тохиролцоонд хүрэхийг тулган шаардах, маргаантай асуудлыг шийдвэрлэх өөрийн хувилбарыг хүлээн авах шаардлага талуудад тавих зэрэг үйлдэл хийх ёсгүй.

Олон улсын арилжааны арбитрайн байгууллагуудын практикт өргөн дэлгэрсэн өөр нэг арга бол талуудын гүйцэтгэх удирдлагын хамтарсан хурал (mini-trial/executive tribunal)². Энэ аргыг сонгосон тохиолдолд талуудын эрх бүхий төлөөлөгчид хэргийн нөхцөл байдлыг тусгайлан байгуулсан бүрэлдэхүүн (panel)-д танилцуулах бөгөөд ийнхүү байгуулсан бүрэлдэхүүнд юуны өмнө маргалдагч тал бүрийн гүйцэтгэх дээд албан тушаалтан ордог байна. Харин бүрэлдэхүүнийг хөндлөнгийн гуравдагч этгээд (neutral chairman) даргална. Бүрэлдэхүүн хуралдааны хэлбэрээр ажиллаж талуудын байр суурийн сул болон давуу талыг олж тогтоосноор зарим тохиолдолд заавал биелэгдэх хүчин чадалгүй шийдвэр (non-binding decision) гаргадаг. Энэ аргыг ихэвчлэн том үнийн дүнтэй урт хугацаат гэрээний талууд хэрэглэх хандлага давамгайлж байгаа бөгөөд ихэнх тохиолдолд талууд асуудлаа шийдвэрлэж эвийн хэлцэл байгуулах ач холбогдолтой.

¹ "Mediation" ба "conciliation" гэсэн нэр томъёог ерөнхийдөө нилээн ойролцоо утгаар хэрэглэж хэвшсэн. "Mediation" гэсэн нэр томъёог академич Ж.Амарсанаа зуучлал, харин "conciliation" гэсэн нэр томъёог эвлэрэл, зуучлалын ажиллагаа гэж тус тус орчуулжээ. Үүнээс үзэхэд "эвлэрүүлэн зуучлал" гэсэн нэр томъёог "conciliation" гэж орчуулах нь илүү зохистой санагдана. Ж.Амарсанаа, Англи-Орос-Герман-Монгол олон улсын эрх зүйн толь, Улаанбаатар 2004, х.500-501. х. 186-187

² Манай зарим судлаачид энэ нэр томъёог "бичил шүүх хурал" гэж орчуулсан байх бөгөөд энэ нь гадаад орнуудын шүүх, арбитрайн практикт "mini-trial" гэсэн нэр томъёог өөр өөр утгаар хэрэглэж байгаатай холбоотой.

Олон улсын арилжааны арбитраын байгууллагуудын практикт дээр дурдсан аргууд (mediation, conciliation, mini-trial) - аас гадна арбитраын эвлэрүүлэх ажиллагаа (non-binding arbitration), шинжээчийн дүгнэлт (expert opinion), хөндлөнгийн этгээдийн үнэлгээ, дүгнэлт (early neutral evaluation), зуучлал, арбитраын хосолсон арга (mediation - arbitration), хялбарчилсан шүүн таслах ажиллагаа (adjudication) зэрэг аргыг хэрэглэж хэвшээд байна.

Арбитраын эвлэрүүлэх ажиллагааны явцад талуудын томилсон арбитрач тэдний ирүүлсэн тодорхой материал, нотлох баримтыг судлан үзсэний үндсэн дээр шийдвэр гаргаж болох бөгөөд ийнхүү гаргасан арбитрачийн шийдвэрийг талууд зарим тохиолдолд хүлээн зөвшөөрдөг байна. Гэхдээ, арбитрачийн шийдвэрийг талууд заавал биелүүлэх ёсгүй байдагт энэ төрлийн эвлэрүүлэх ажиллагааны онцлог шинж оршино. Шинжээчийн дүгнэлт, хөндлөнгийн этгээдийн үнэлгээ, дүгнэлтийг тухайн маргааны техникийн болон хууль зүйн асуудлаар гаргуулах нь элбэг бөгөөд эдгээр дүгнэлтийг хүлээн авах эсэх асуудлыг маргалдагч талууд шийдвэрлэнэ.

Зуучлал, арбитраын хосолсон аргын онцлог шинж нь зуучлагчийн үйл ажиллагаа үр дүнд хүрэхгүй нь тодорхой болох тохиолдолд зуучлагч яваандаа арбитрачийн үүрэг гүйцэтгэх эсвэл үүргээ өөр арбитрачид шилжүүлэхэд оршино. Англи болон Хамтын нөхөрлөлийн гишүүн - орнуудад зуучлагчаас өөр этгээд арбитрачийн үүрэг гүйцэтгэх учиртай байхад Хятад зэрэг зарим улсад зуучлагч байсан этгээд цаашид арбитрачийн хувиар маргаан шийдвэрлэх ажиллагаанд үргэлжлүүлэн оролцох боломжтой.

Хялбарчилсан шүүн таслах ажиллагааны үед талууд маргаанд холбогдох материал, нотлох баримтыг шүүгч (adjudicator) - д шилжүүлэх бөгөөд шүүгч хуралдааныг удирдан явуулж шийдвэр

гаргана. Уг ажиллагааг ихэвчлэн нэг сарын хугацаанд явуулдаг онцлогтойгоос гадна шүүгч шийдвэр гаргах учиртай. Гарсан шийдвэрийг талууд биелүүлэх шаардлагатай боловч аль нэг тал өөрийн байр сууриа баталгаажуулах зорилгоор маргаан шийдвэрлэх өөр аргыг хэрэглэх боломж байдаг. Маргаан шийдвэрлэх альтернатив энэ аргыг ялангуяа, барилгын салбарт өргөн хэрэглэдэг бөгөөд энэ нь том үнийн дүнтэй төслийг саадгүй, бага зардлаар хэрэгжүүлэхтэй холбогдсон хэрэгцээнээс урган гардаг байна.

Дээрхээс үзэхэд, олон улсын арилжааны арбитраын байгууллагуудын практикт маргааныг арбитраын ажиллагаа эхлэхээс өмнө шийдвэрлэдэг тогтолцоог бий болгон мөрдцүүлж байгаа нь юуны өмнө илүүх, арбитраын байгууллагын ачааллыг багасгах, түүнчлэн маргааныг бага зардлаар шуурхай шийдвэрлэх зорилготой холбоотой байна. Үүний улмаас гадаад орнуудын илүүх, арбитраын практикт хэрэглэж хэвшсэн маргаан шийдвэрлэх альтернатив аргыг Монголын арбитраын байгууллагуудын үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх үүднээс Монголын арбитраын практикт өргөн хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

4. Монгол улсад зуучлалын журмаар маргаан шийдвэрлэж байгаа өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчин

Эдүгээ манай улсад МҮХАҮТ -ын дэргэдэх МОУҮА болон арбитраын бусад байгууллагууд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа боловч арбитра хандах иргэн, хуулийн этгээдийн тоо жилийн жилд бараг нэг хэмжээндээ байсаар л байна. Жишээ нь МҮХАҮТ -ын дэргэдэх арбитраар 2007-2009 онуудад 75 маргаан, 2010 -2013 онуудад 146 маргаан шийдвэрлэсэн бөгөөд өөрөөр хэлбэл жилд дунджаар 36 маргаан шийдвэрлэж байна. Гэтэл шүүхээр зөвхөн 2009 онд 35822 хэрэг шийдвэрлэсэнээс

үзэхэд шүүхээр шийдвэрлэгдэж байгаа иргэний хэрэг арбитрын байгууллагаар шийдэгдэж байгаа хэргээс даруй хэд дахин их байна.¹

Шүүхээр шийдвэрлэгдэх иргэний хэргийн тоо ийнхүү буурахгүй байсан учраас Улсндээдшүүх, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран 2010 оноос “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл” -ийг хэрэгжүүлж эхэлснээр шүүхэд хандах иргэдийн тоо цөөрөх хандлага ажиглагдсан байна. Энэ шалтгаанаар Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг Улсын Их Хурал 2012 оны 5 дугаар сард баталсан. 2013 оноос дагаж мөрдөж эхэлсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх эрх зүйн үндсийг хуульчилсан. Энэ хуульд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, үндсэн зарчим, эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал, эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл, түүний бүрэн эрх, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч талууд, тэдгээрийн эрх, үүрэг, эвлэрүүлэн зуучлагчийн эрх зүйн байдал, түүнийг татгалзан гаргах журам, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хутацаа, нөхцөл, эвлэрлийн гэрээ, түүний гүйцэтгэлийг хангах, эвлэрүүлэн зуучлал дуусгавар болох, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж, зардал, хөлс зэрэг олон асуудлыг тусган бэхжүүлжээ.

Ийнхүү манай улсад маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх эрх зүйн орчин зарим талаар сайжирсан боловч арбитраар шийдвэрлэсэн хэргийн тоо нэмэгдэхгүй байгаа нь МҮХАҮ-ын дэргэдэх арбитраар 2013 оны эхний 9

¹ “Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл, бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам” судалгааны тайлан. Судалгааны тайлангийн эмхтгэл (2010-2011). II. ХЗҮХ, Улаанбаатар, 2012, х.534

сарын сарын байдлаар дөнгөж 25 хэрэг шийдвэрлэснээс тодорхой байна. Гэтэл гадаад орнуудад иргэний эрх зүйн нийт маргааны 44 хувийг арбитр болон маргаан шийдвэрлэх альтернатив аргыг хослуулан хэрэглэж шийдвэрлэсэн байгаа нь эвлэрүүлэн зуучлал болон бусад аргыг Монголын арбитрын өнөөгийн практикт хэрэглэж хэвшүүлэх шаардлагатай харуулж байна. Ингэхлээр юуны өмнө Монголын арбитрын өнөөгийн практикийн тулгамдсан асуудлыг авч үзье.

4.1 Монголын арбитрын өнөөгийн практик, тулгамдсан асуудал

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсантай холбогдуулан ЖАЙКА-гийн санхүүжилтээр “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”-ийн II шат 2013 оны 4 дүгээр сараас үргэлжлэн хэрэгжиж байгаа бөгөөд төслийн эцсийн зорилго нь Монгол улс дахь шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сайжруулахад оршино. Энэ төсөл хэрэгжиж эхэлсэнээр шүүхүүд дээр эвлэрүүлэн зуучлах хэсэг байгуулагдсанаас гадна МҮХҮАТ болон төрийн бус бусад байгууллагууд мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотойгоор эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохион байгуулах боллоо. Үүнээс гадна МҮХҮАТ -ын дэргэдэх арбитр эвлэрүүлэн зуучлагчийг дэргэдээ ажиллуулж, эвлэрүүлэн зуучлагчийн оролцох хэлбэрийг арбитр журмаараа тогтоож болохоор хуульчлагдсан тул эвлэрүүлэн зуучлал болон бусад аргыг Монголын арбитрын өнөөгийн практикт хэрэглэж хэвшүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна.¹ Энэ шалтгаанаар МҮХАҮТ-ийн Арбитрын зуучлалын ажиллагааны журам, Монголын үндэсний арбитраас түр арбитрт дэмжлэг үзүүлэх дүрмийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, гадаадын арилжааны арбитрын байгууллагуудын маргаан шийдвэрлэх альтернатив аргыг зохицуулсан дүрэм, журмыг харгалзан үзсэний үндсэн дээр

¹ Монгол улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3-р зүйлийн 6 дахь хэсэг. www.legalinfo.mn

шинэчлэн боловсруулах, МҮХАҮТ-ын арбитраар шийдвэрлэх олон улсын хувийн эрх зүйн маргааны тоог нэмэгдүүлэх, байгаль орчны болон эрдэс баялгийн эрх зүйн маргаан шийдвэрлэх дүрэм боловсруулах, маргааныг зуучлал болон бусад аргаар шийдвэрлэх эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.

Хэдийгээр МҮХАҮТ-ийн Зөвлөл Арбитрын зуучлалын ажиллагааны журмыг 2003 оноос батлан мөрдүүлж байгаа боловч уг журамд¹ 2003 оны Арбитрын тухай хууль хэрэгжиж эхлэх үед “Эрдэнэт үйлдвэр” ХХК зэрэг уул уурхай, дэд бүтцийн салбарын аж ахуйн нэгжүүдийн гадаад худалдааны практикт аль хэдийнээс хэрэглэж байсан хэлэлцээ хийх, экспертийн дүгнэлт гаргуулах, зуучлалын ажиллагаа явуулах зэрэг маргаан шийдвэрлэх аргыг тусган бэхжүүлээгүй байна.² Түүнчлэн, арбитр яг ямар үйл ажиллагаа явуулдаг талаар олон нийт тэр болгон мэдэггүй, арбитрын талаар мэдээлэл өгдөг газрууд бараг байдаггүй, арбитраг гол төлөв гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хандаж байгаа зэрэг шалтгаанаар³ МОУҮА болон бусад арбитрын байгууллагын практикт маргааныг зуучлалын журмаар шийдвэрлэсэн тохиолдол гараагүйг ХЗҮХ-ийн хийсэн судалгаанаас харуулж байна. Энэ нь Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм, Арбитрын зуучлалын ажиллагааны журамд зуучлал (negotiation, mini-trial, mediation, conciliation) болон бусад аргыг хэрэглэхэд МОУҮА-ийн зүгээс ямар

ямар үйлчилгээ үзүүлэх талаар тусган бэхжүүлээгүйтэй холбоотой¹ юм.

Гэтэл МОУҮА-тай харьцуулахад олон улсын арилжааны арбитрын байгууллагууд нь арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмээс гадна маргааныг зуучлалын журмаар шийдвэрлэх журам батлан мөрдүүлснээр маргааныг арбитраг шилжүүлэхээс өмнө бага зардлаар шуурхай шийдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлээд байна. Ялангуяа, 2002 онд ЮНСИТРАЛ - аас Олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлалын загвар хууль (Model Law on International Commercial Conciliation) - ийг боловсруулснаар Бельги, Хорват, Швейцарь, Франц, АНУ зэрэг гадаадын 30 гаруй орон арилжааны арбитрын үндэсний хууль тогтоомжоо шинэчлээд байна².

Ингэхлээр маргаан шийдвэрлэх альтернатив аргыг Монголын арбитрын практикт хэрэглэж хэвшүүлэх, МҮХАҮТ-ийн Арбитрын зуучлалын ажиллагааны журмыг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нийцүүлэн боловсруулах шаардлага зүй ёсоор гарч байна. Одоо арбитрын эрх зүйн зохицуулалтын эдгээр тулгамдсан асуудлын дотроос эвлэрүүлэн зуучлалыг Монголын арбитрын өнөөгийн практикт хэрэглэж, хэвшүүлэх асуудлыг тодруулан авч үзье.

4.2 Монголын арбитрын практикт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж, хэвшүүлэх асуудал

Энэхүү өгүүллийн 4.1 -р хэсэгт дурдсанчлан гадаадын зарим орнууд

²⁰ Арбитрын зуучлалын ажиллагааны журамд зуучлалын ажиллагаа явуулах, зуучлагчид тавигдах шаардлага, зуучлагчийг арбитраас томилох, зуучлагч томилох хугацаа, зуучлалын ажиллагааны зардал, зуучлалын ажиллагааг дуусгавар болгох, нууц хадгалах, эвлэрлийн гэрээг биелүүлэх зэрэг асуудлыг тусган бэхжүүлжээ. www.mongolchamber.mn

²¹ И.Идэш. Орхон аймгийн арбитрын үйл ажиллагаа: Аймгийн арбитрын практикт маргаан шийдвэрлэх альтернатив аргыг нэвтрүүлэх асуудал. МҮХАҮТ -ын дэргэдэх МҮА. Үндэсний арбитр сэтгүүл, Улаанбаатар, 2005, № 01(06), 16 -р хуудас

²² Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам” судалгааны тайлан. Дээр дурдсан бүтээл. 535 -р хуудас.

²³ Маргаан шийдвэрлэх альтернатив арга, зуучлалын журмаар маргаан шийдвэрлэх ажиллагааны асуудлыг Монгол улсын Арбитрын тухай хуулиар зохицуулаагүй учир эдгээр асуудлыг Арбитрын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэх боломжтой билээ. Гэхдээ, энэ талаар энэхүү өгүүлэлд дэлгэрүүлж авч үзээгүй болно.

²⁴ Үндэсний хууль тогтоомжийн актаа боловсруулахдаа ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн зарчим, зүйл, заалтыг уламжлан авсан дэлхийн улс, орнуудын жагсаалтыг www.uncitral.org/uncitral/en/uncitral-texts/arbitration-зас тодруулж үзнэ үү.

арбитрын төрөлжсөн хуулиндаа эвлэрүүлэн зуучлалын асуудлыг бэхжүүлэн тусгах, эвлэрүүлэн зуучлалын төрөлжсөн хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөрийнхөө хүрээнд байнгын арбитраын дэргэд эвлэрүүлэн зуучлалын төв байгуулах, эвлэрүүлэн ажиллагааны арга зүйг арбитраын хэрэг шийдвэрлэх дүрэм, журамдаа тусгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр маргаан шийдвэрлэх альтернатив аргыг олон улсын арилжааны арбитраын байгууллагуудын практикт аль хэдийнээ хэрэглэж хэвшжээ. Тухайлбал, АНУ -ын Зуучлалын нэгдмэл хууль (Uniform Mediation Act) -ийн XI хэсэг (Section 11. International Commercial Mediation) - т олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлалын асуудлыг зохицуулсан¹. Энэтхэг улсад Арбитраын болон эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (Indian Arbitration and Conciliation Act), бусад хууль тогтоомжийн хүрээнд байнгын арбитраын байгууллага эвлэрүүлэн зуучлалын журам боловсруулж мөрдүүлээд байна². Харин ОХУ-д Зуучлагчийн оролцоотойгоор маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (Закон от 27 июля 2010г. №193-ФЗ "Об альтернативной процедуре урегулирования споров с участием посредника (процедуре медиации) -ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2011 оноос зарим бүсийн худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэд эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулан ажилууж байна.³

¹ Энэ хуульд олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлалын хувьд ЮНСИТРАЛ-ийн загвар хуулийн зүйл, заалтыг хэрэглэхээр заасан байна. ЮНСИТРАЛ-ын загвар хуульд эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг эхлүүлэх, эвлэрүүлэн зуучлагчдыг томилох, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэлбэр, мэдээллийг задруулах, эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг, эвлэрийн гэрээ зэрэг асуудлыг тусган бэхжүүлжээ. Энэ хуулийн эх бичвэрийг www.uncitral.org/en-index.htm web site -аас үзнэ үү.

² Энэтхэгийн Арбитр болон эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Олон улсын арбитраын Лондонгийн шүүх (LCIA) -ийн салбар болох India LCIA -гийн талаар Jan Paulsson, Nigel Rawding, Lucy Reed. Дээр дурдсан бүтээл. Х.72 -аас тодруулж үзнэ үү.

³ Справка о практике применения Федерального закона "Об альтернативной процедуре урегулирования споров с участием посредника (процедуре медиации). С.2. www.suprcourt.ru/obosnovanie.doc

Ийнхүү тухайн харьяалсан улсынхаа дотоодын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн хэм хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр олон улсын арилжааны арбитраын байгууллагууд зуучлалын ажиллагааны журам мөрдүүлэх, маргаан шийдвэрлэх альтернатив аргыг тусган бэхжүүлсэн дүрэм, журмаа шинэчлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд гадаад орнууд дахь олон улсын хувийн эрх зүйн болон иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэх эрх зүйн орчин улам боловсронгуй болсоор байна. Жишээ нь 2001 оноос мөрдөгдөж байгаа Парисын ОУХТ-ийн Маргааныг эвийн журмаар шийдвэрлэх дүрэм (amicable dispute resolution rules, ICC ADR Rules) - д маргааныг эвийн журмаар шийдвэрлэх хүсэлт гаргах журам, дүрмийн үйлчлэх хүрээ, хөндлөнгийн этгээд (neutral) томилох, эвлэрүүлэн ажиллагааны зардал, ажиллагаа явуулах хэлбэр, эвлэрүүлэн ажиллагааг дуусгавар болгох үндэслэл зэрэг асуудлыг зохицуулжээ.

Парисын ОУХТ -ын Маргааныг эвийн журмаар шийдвэрлэх дүрэмд зааснаар маргалдагч талууд болон хөндлөнгийн этгээд маргааныг ямар аргаар шийдвэрлэх, эвлэрүүлэн ажиллагааны арга зүй зэрэг асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэхээр заажээ. Ингэж маргаан шийдвэрлэх тодорхой аргыг талууд сонгоогүй тохиолдолд зуучлал (mediation) -ын аргыг хэрэглэхээр журамласнаар¹ олон улсын худалдааны контракт, гэрээ, хэлцлээс үүссэн маргааныг Арбитраын олон улсын шүүх (International Court of Arbitration) - эд шилжүүлэхээс өмнө шийдвэрлэх арбитраын эрх зүйн нэмэлт механизмыг бий болгосон байна. Гэтэл БНСУ-д 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж байгаа Зуучлалын дүрэм (KCAB Mediation Rules)-ийг зөвхөн Солонгосын хувь хүмүүс, хуулийн этгээдүүд оролцсон маргааныг зуучлалын аргаар

¹ ADR Rules of the International Chamber of Commerce. Arbitration and ADR Rules. ICC Publication 850 E. ISBN 978-92-842-0113-6

шийдвэрлэхэд мөрдөхөөр баталжээ¹.

Дээрхээс үзэхэд гадаад орнуудын арбитрын практикт маргааныг эвийн журмаар шийдвэрлэж байгаа туршлагыг нухацтай судлан үзэж МОУҮА -ын практикт хэрэглэж хэвшүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд МҮХАҮТ, МОУБҮА болон салбар арбитуудын зүгээс иргэний эрх зүйн маргааныг зуучлалын журмаар шийдвэрлэж байгаа механизм, аргыг боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэхийн тулд юуны өмнө МҮХАҮТ -ийн Арбитрын зуучлалын ажиллагааны журам болон бусад холбогдох дүрэм, журмыг Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, нийцүүлэн хянан үзсэний үндсэн дээр хэлэлцээ хийх, зуучлалын ажиллагаа явуулах, экспертиз хийх зэрэг аргыг хэрэглэж хэвшүүлэхэд чиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны аргачлал, шинэ журам боловсруулж батлах, түүнчлэн арбитрын практикт хэрэглэж хэвшүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Арбитрын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны шинэ журам боловсруулахдаа гадаад орнуудын хууль тогтоомж, арилжааны арбитрын практик, зуучлалын журам, түүнчлэн ЮНСИТРАЛ - ын Олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлалын загвар хууль болон олон улсын эрх зүйн холбогдох баримт бичгийг сайтар судлах шаардлагатай байна.

5. Дүгнэлт

Гадаад орнуудын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик, олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикт хэрэглэж хэвшсэн маргаан шийдвэрлэх альтернатив арга, түүнчлэн Монголын арбитрын өнөөгийн практикийг судлан үзсэний үндсэн дээр дараах дүгнэлт хийж байна.

Үүнд:

1. Гадаад орнуудын эвлэрүүлэн зуучлалын хууль тогтоомжийн хөгжилд АНУ, Их Британи зэрэг орнуудын шүүх, арбитрын практик, хууль зүйн номлол, олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практик, түүнчлэн олон улсын эрх зүйн хэм хэмжээ шийдвэрлэх нөлөө үзүүлсэн бөгөөд цаашид ч өргөжихөд маргашгүй.
2. Гадаад орнуудын байнгын арбитрын байгууллагууд арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмээс гадна хэлэлцээ хийх, зуучлал болон маргаан шийдвэрлэх альтернатив бусад аргыг тусган бэхжүүлсэн дүрэм, журмыг батлан мөрдүүлснээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь болоод байна.
3. Монгол улсад Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсантай холбогдуулан МОУҮА -аар шийдвэрлэх олон улсын хувийн эрх зүйн маргааны тоог нэмэгдүүлэх, арбитрын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, маргааныг зуучлал болон бусад журмаар шийдвэрлэх эрх зүйн орчинг сайжруулах, түүнчлэн эвлэрүүлэн зуучлал болон альтернатив бусад аргыг Монголын арбитрын өнөөгийн практикт хэрэглэж хэвшүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.
4. МҮХАҮТ болон бусад байгууллагын хувьд олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикийг судлан үзсэний үндсэн дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам боловсруулж мөрдүүлэх, уг журамд юуны өмнө маргаан шийдвэрлэх

²⁹ 2012 Annual Report KCAB. P.14. www.kcab.or.kr.

альтернатив аргыг хэрэглэсний үр дүнд хүрсэн тохиролцоо, эвлэрлийн хэлэлцээрийн хууль зүйн хүчин чадал зэрэг асуудлыг тусгах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

5. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журамд хэлэлцээ хийх, экспертийн дүгнэлт гаргуулах, хөндлөнгийн үнэлгээ хийх, зуучлалын ажиллагаа явуулах зэрэг маргаан шийдвэрлэх аргуудыг тусган бэхжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарим нэр томъёог нэг мөр цэгцэлж хэрэглэх үүднээс нэн түрүүнд гадаад орнуудын эвлэрүүлэн зуучлалын хууль тогтоомж, олон улсын арилжааны арбитрын байгууллагуудын практикт хэрэглэж хэвшсэн маргаан шийдвэрлэх альтернатив аргыг олон талаас нь нарийвчлан судалж, холбогдох аргачлал, заавар боловсруулах хэрэгтэй болж байна.

Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр манай улсад гадаад орнуудын шүүх, арбитрын практикт өргөн хэрэглэж байгаа маргаан шийдвэрлэх альтернатив аргыг МОУҮА болон түүний салбар арбитуудын практикт хэрэглэх эрх зүйн орчин сайжраад зогсохгүй улмаар иргэний эрх зүйн маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх механизм шинэ агуулгаар баяжин цаашид боловсронгуй болон хөгжих чухал ач холбогдолтой юм.

Summary

This article deals with the legal aspects of alternative dispute resolution in the context of the present Mongolian arbitral practice. The recent development of conciliation legislation and challenging issues of the present Mongolian arbitral practice are also discussed in this article. The recent development of conciliation legislation of Mongolia and practice of international arbitral institutions show that the existing Arbitration Law and arbitration rules of the Mongolian International and National Arbitration Court (MINAC) and other institutions do not regulate many issues of alternative dispute resolution such as mini-trial, expert opinion, international commercial conciliation and settlement techniques. Consequently, MINAC and other arbitral institutions still need to improve the legal environment of commercial conciliation and make necessary amendments and modifications to their existing mediation rules and other relevant regulations.

---o0o---

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫГ ОНОВЧТОЙ ЯВУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД



*Иргэний хэргийн давж заалдах шатны
шүүгч П.Золзаяа*

Шүүхийн бус аргаар маргааныг шийдвэрлэх аргуудын нэг нь эвлэрүүлэн зуучлал юм. Монгол улсад өнөөгийн байдлаар маргааныг зөвхөн шүүхээр шийдвэрлүүлэх гэдэг үзэл санаа нэлээд баттай тогтсон байна. Зөвхөн шүүхийн шийдвэрээр л бодит зөв дүгнэлт гардаг юм биш. Маргалдагч талууд өөрсдөө бодит үнэнийг мэдэх учир эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр нүүр тулан ярилцаж зөв шийдвэрийг гаргах шүүхийн бус энэ аргыг орхигдуулж болохгүй юм.

Одоо тэр ч байтугай манай найз нөхөд, хадам, хамт ажиллагсад, намын нөхөд намайг доромжиллоо, миний нэр төр гутаагдлаа гэх мэт асуудлаар шүүхэд хандах явдал гарч байна.

Мэдээж амьдрал дээр хүмүүсийн хооронд үүсдэг бүх маргаан шүүхийн харьяаллынх буюу эрх зүйн маргаан биш байдаг тул шүүхэд хамаарахгүй маргааныг

хүмүүс өөр хоорондын харилцаагаар зохицуулж, тухайн хүний нийгэм дэх байр суурь нь тодорхойлогдож явдаг.

Зан суртахуун үргэлж хуулиас түрүүлж тогтдог болохоор хууль хэзээ ч зан суртахууныг гүйцдэггүй. Тэгэхээр хууль бүх зүйлийг зохицуулж чадахгүй, зохицуулаа гэхэд нийгмийн өөрчлөлт шаардлагад яв цав бүрэн нийцэх нь эргэлзээтэй.

Эрх зүйн онолын үүднээс зөвхөн хуульд захирагдах, хуульд зааснаар маргааныг шийдвэрлэх позитивизмийн үзэл санаа нь эрх зүйн түүхэн хөгжлийн явцад дангаар ноёрхож чадаагүй. Үүнээс гадна маргааныг ёс зүйтэй, туршлагатай, олонд нэр хүндтэй хүн шийдвэрлэж болно гэсэн чөлөөт үзэл баримтлал амьдралын шаардлагаар бий болсон байна. Энэ үзэл санааны үргэлжлэл нь эвлэрүүлэн зуучлал, арбитр зэрэг шүүхийн бус арга юм.

Дэлхийн улс орнууд шүүхийн болон шүүхийн бус аргын аль алыг хослуулан хэрэглэж, шийдвэрлэх арга замыг улам боловсронгуй болгохын төлөө туршлагаа солилцож, хамтран ажиллаж байгаа билээ.

Манай улсад маргааныг шийдвэрлэх дээрх аргууд аль аль нь хэрэглэгдэж ирсэн. ИХШХШТухай хуульд маргааныг шүүх шийдвэрлэж шийдвэр гаргахаас гадна талууд өөрсдөө маргаанаа шийдвэрлэсэн бол хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг. Анхан шатны шүүх жил дунджаар 11000-12000 иргэний хэрэг шийдвэрлэсний 30 гаруй хувь буюу 3000-4000 иргэний хэргийн талууд өөрсдөө маргаанаа шийдвэрлэсэн байна. Ялангуяа

хөдөө орон нутгийн шүүхүүдэд талууд маргаанаа өөрсдөө шийдвэрлэсэн тоон үзүүлэлт илүү давамгайлсан байна¹.

Энэ тоон мэдээнээс үзэхэд хүмүүс маргалдсан хэдий ч хамгийн боломжтой шийдэлд хүрч маргаанаа шийдвэрлэсэн гэж үзэж болно.

Нөгөө талаар дээрх хэмжээний хэрэг шүүхэд хандахгүйгээр шууд эвлэрүүлэн зуучлагчид хандсан бол:

1. Маргалдаж байгаа талууд хугацаа хэмнэнэ. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх хугацаа иргэний хэрэг үүсгэснээс хойш 60 хоног, шүүгчдийн зөвлөгөөнөөр сунгасан бол 30 хоног нэмэгдээд 90 хоногт шийдвэрлэгддэг². Харин эвлэрүүлэн зуучлагчид хандсан тохиолдолд 30 хоног, талууд идэвхтэй оролцсон бол үүнээс ч богино хугацаанд, хэрэв ажиллагааг сунгасан бол 60 хоногийн дотор шийдвэрлэгдэнэ.³ Эвлэрүүлэн зуучлалын процедур хялбар, нотлох баримтаар хязгаарлагддаггүй, талуудын харилцан яриа, тохиролцоог чухалчилдаг.

2. Эвлэрүүлэн зуучлагчид хандсан тохиолдолд хураамж бага учраас зардал хэмнэнэ.

3. Маргалдагч талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэргэд нүүр тулан уулзаж, маргааны талаар ярилцаж санал бодлоо хэлэх боломж шүүх дээр байснаас илүү чөлөөтэй, нээлттэй учраас зөв шийдэл гаргах илүү давуу талтай. Шүүгч эвлэрүүлэн зуучлагчийн адил дэмжиж зуучлах ажиллагааг явуулдаггүй учраас талууд хоорондоо уулзаж ярилцах нь хязгаарлагдмал байдаг.

4. Талууд маргаанаа шийдвэрлэж эвлэрлийн гэрээ байгуулсан бол шүүгч баталгаажуулж шийдвэр гаргах учир

гэрээний үүрэг заавал биелэгдэнэ. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаар эвлэрлийн гэрээ гэдэгт талууд харилцан буулт хийж шийдэлд хүрэх, харилцан ярилцсаныг дүнд тайлбар гаргагч шаардлагыг хүлээн зөвшөөрөх, шаардлагыг биелүүлэх, эсвэл өргөдөл гаргагч өргөдлөөсөө татгалзах шийдэлд хүрэх аль аль нь эвлэрэл болохыг хуульчилж өгсөн.

5. Шүүхийн ачаалал багасна. Шүүгч ээдрээ маргаантай хэргээ унших, судлах, эрх зүйн актаа боловсруулах, хуулиа судлах зэрэг ажиллагаанд үргэлж цаг заваар дутагддаг тул энэ хэмжээний хэрэг эвлэрүүлэн зуучлагчаар дамжих юм бол шүүн таслах ажлын чанар ч дээшлэх юм.

6. Талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрэлд хүрч чадаагүй ч маргааны талаар хоорондоо ярилцсан, санал солилцсон байгаа учраас маргаагүй үйл баримт, маргасан үйл баримт нь тодорхой зааглагдаж шүүх дээр маргах хэмжээ хязгаар нь тодорхой болж, талууд ч ач холбогдол бүхий байдлын хэмжээ хязгаарын хүрээнд мэтгэлцэж цаг хэмнэнэ.

Эвлэрүүлэн зуучлалын эдгээр давуу талыг иргэд ухамсарлах, сэтгэлгээний өөрчлөлт хийхэд тодорхой хэмжээний ажлыг зохистой явуулах нь чухал байна. Сурталчилгаа, сургалт зэрэг ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч Жайка, шүүх, өмгөөлөгчдийн оролцоотойгоор явуулж байгаа боловч өргөн хүрээнд хамааралтай цогц бодлогын хэмжээнд явуулах шаардлагатай. Жишээ нь их, дээд, дунд сургуулийн хичээлийн программд шүүхийн бус аргаар маргааныг шийдвэрлэх арга зам, эрх зүйн сургалтыг оруулах, маргаан байгаа эсэхээс хамаарахгүйгээр нийгмийн олон санал зөрөлдөөнтэй асуудлаар хүмүүс харилцан ойлголцох, ярилцах олон төрлийн ажлыг салбар бүрт санаачилж, төрөөс болон төрийн бус байгууллагуудын зүгээс дэмжих, эвлэрүүлэн зуучлалын

³⁰ Иргэний хэргийн бүтэн жилийн мэдээ, УБ., 2013 он

³¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 71-р зүйл., Монгол улсын хууль., 2002 он

³² Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 20-р зүйл., Монгол улсын хууль., 2013 он

талаар эрх зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөгч нар маргааныг аль болох эвийн журмаар шийдвэрлэхэд дэмжих зэрэг ажлууд байж болох юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой зохион байгуулалтын асуудлыг мөнгөнд баригдахгүйгээр анхнаасаа хуулийн дагуу зөв явуулах нь чухал байна. Одоогоор шүүхийн дэргэдэх орон тооны эвлэрүүлэн зуучлагчийн тоо орон нутагт 1 байгаа нь угаасаа эвлэрүүлэн зуучлалыг хэвийн явуулах боломжгүйд хүргэсэн, мөн захиргааны ажилтны орон тоог батлаагүйгээс ажил ихтэй байгаа шүүхийн нарийн бичгийн даргыг оролцуулах, эсвэл эвлэрүүлэн зуучлагч өөрөө ажиллагааг биечлэн хийх зэргээр үндсэн ажлаа явуулахад нь саад учирч байгаа явдлыг даруй шийдвэрлэх хэрэгтэй харагдана. Түүнчлэн талуудтай ярилцах уулзалтын өрөө хүртээмжтэй биш, цаашид өргөдөл ихсэх хандлагатай байгаа тохиолдолд уулзалтыг зохион байгуулахад өрөө сулрахыг хүлээх, зуучлалын ажиллагаа сунжрах, улам чирэгдэлтэй болоход хүргэх тул анхаарах нь зөв байна.

Эвлэрүүлэн зуучлалыг оновчтой бөгөөд амжилттай явуулах дараагийн гол зүйл бол эвлэрүүлэн зуучлагчийн өөрийнх нь үйл ажиллагаа юм. Эвлэрүүлэн зуучлагч нэг талаас сэтгэл зүйч, нөгөө талаар маргааны санал зөрөлдөөнтэй асуудлыг шийдвэрлэхэд туршлагатай хүний хувьд, мөн эрх зүйн үүднээс дэмжиж тусалж чадах хэмжээнд байх шаардлагатай байдаг. Эвлэрүүлэн зуучлагч нь иргэний маргааныг шийдвэрлэхэд үүрэг гүйцэтгэхүйц мэргэжлийн мэдлэг эзэмшсэн, эсвэл нийгмийн амьдралын баялаг мэдлэг туршлагатай, хүн чанар, ухамсар өндөртэй ямар ч мэргэжлийн хүн байж болно.

Эвлэрүүлэн зуучлагч маргааныг албадан шийдвэрлэхийг зорьж буй мэт сэтгэгдлийг талуудад төрүүлж болохгүй бөгөөд талуудыг шахаж албадаж болохгүй.

Өөрөөр хэлбэл мөрдөн байцаалтанд байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлэх ёсгүй. Эхний алхам нь талуудад итгэл төрүүлэх, талуудын яриаг сонсож чадах нь чухал байдаг байна. Зүгээр сонсоод толгой дохиод суух биш адилхан санаа бодол ойлголттой байгаагаа цөөн үгээр илэрхийлэх, хэлснийг нь товч давтах, дэмжих, асуулт тавих зэргээр оролцвол ярьж байгаа тал өөрийг нь сонсож байгааг мэдэрч итгэл төрдөг байна.

Эвлэрүүлэн зуучлагч аль ч талыг шүүмжлэхгүй, заахгүй, үнэлэлт хийхгүй, магтахгүй, сэтгэлийн хөдөлгөөнд автагдах учиргүй. Маргалдагч талуудын өмнө төвийг сахиж, сайтар сонсож буйгаа мэдрүүлэх нь эхний ээлжинд чухал байна. Итгэлцлийг бий болгож чадвал зуучлагч нь талуудаас олон мэдээллийг олж авна, улмаар олсон мэдээлэлдээ дүгнэлт хийж маргааны гол зүйлийг олж, дэмжлэг үзүүлэх ажиллагаагаа идэвхтэй болгох юм.

Эвлэрүүлэн зуучлал нь мөн чанартаа маргалдагч талын хараат бус шийдвэр гаргахтай хамааралтай процедур бөгөөд ялангуяа гэр бүлийн хэрэгт, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дууссан дараа ч хоорондын хамаарал харилцаа нь цаашид үргэлжлэх тул эвлэрүүлэн зуучлалын үед нөгөө талтайгаа ярилцахаас зайлсхийх байдал нь бодит маргааны шийдэл болдоггүйг анхаарах хэрэгтэй.

Эвлэрүүлэн зуучлагч маргалдагч талыг сайтар нягтлан шалгаж, шаардлагатай бол сэтгэл зүйн зохицуулалт болон аюулыг зайлуулах арга хэмжээ авч харилцан ярилцахад зориулсан орчин, хувь хүн өөрийгөө удирдах үндсийг бүрдүүлэх нь чухал.

Үндсэндээ, эвлэрүүлэн зуучлал нь маргалдагч талууд ярилцаж санал нэгдсэнээр шийдлийг эрж олдог хэдий ч, боломжийн зөв зүйтэй шийдэл гаргахад эвлэрүүлэн зуучлагчийн зүгээс санал тавих тохиолдол ч байдаг. Үүнийг манай хуулиар тодорхой хэмжээнд зохицуулж өгсөн.

Японд маргалдагч талууд зөвшөөрсөн хэдий ч, санал нэгдэхгүй үед шүүх шүүхийн тогтоолоор зөв зохистой шийдвэрийн шийдэл дэвшүүлэх үе байдаг байна. Маргалдагч талуудын тохиролцсон зүйлүүдийг протоколд тэмдэглэнэ. Эвлэрүүлэн зуучлалын протокол нь шүүхийн шийдвэртэй адил хүчин төгөлдөр байх бөгөөд тохиролцсоныг хэрэгжүүлээгүй тохиолдолд протоколыг үндэслэн албадан хэрэгжүүлдэг байна.

Харин манайд талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрсэн бол эвлэрлийг шүүгч баталгаажуулж шийдвэрийн нэгэн адил захирамж гаргахаар хуульчилсан нь эвлэрүүлэн зуучлалыг дэмжсэн, биелэгдэх боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн эвлэрүүлэн зуучлалд талуудыг дуудах, ирүүлэх ажиллагааг шүүхийн ажилтан гүйцэтгэхийг хуулиар заасан нь энэ ажиллагааг зохистой явуулахыг дэмжсэнтэй холбоотой.

Манай хуулиар одоогоор зохицуулаагүй ч эвлэрүүлэн зуучлагчид дараах эрх мэдэл байдаг байна. Эвлэрүүлэн зуучлагч нь маргалдагч талаас нөхцөл байдлыг сонсонгоо, түүний уялдаа-холбоог цэгцлэн, хууль зүйн үүднээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд дөхөм үзүүлэхүйц шийдлийг бодолцон санал болгохдоо мөн шаардлагатай нотлох материалыг нэмж бүрдүүлэн, шийдвэрлэх шийдлийг санал болгохыг лавладаг тохиолдол байдаг байна.

Маргааны бодит байдлыг нарийн тогтоохын тулд, эвлэрүүлэн зуучлагч нь албан тушаалын эрх хэмжээнд "Бодит байдлын судалгаа" хийж болно. "Бодит байдлын судалгаа" гэдэг нь тусгай арга, түүнчлэн албадлагын хүч хэрэглэх арга ашиглалгүй, материал цуглуулахыг хэлнэ. Холбогдох хүмүүсээс нөхцөл байдлыг байдлыг сонсож, маргааны объект болж байгаа үл хөдлөх хөрөнгө, бусад зүйлийн нөхцөл байдлыг ялган салгаж, мэргэжлийн хүний саналыг сонсож болно. Уг хүнээс

нөхцөл байдлыг сонсож мэдэх нь тун чухал. Бас эвлэрүүлэн зуучлагч нь албан тушаалын эрх эсвэл өргөдлийн дагуу нотолгоог шалгаж болно. Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд нотлох баримт бүрдүүлэх, үнэлж цэгнэх ажиллагаа ирээдүйд зүй ёсоор тавигдах болно. Баримтыг талууд нүдээр үзсэнээр тодорхой тайлбар гаргаж, харилцан яриа улам өрнөж, асуудал тодорхой болох сайн талтай байдаг байна.

Тиймээс эвлэрүүлэн зуучлагч хоёр талын саналыг зохицуулах үүргээр зогсохгүй, нөхцөл байдлыг сонссон үр дүн болон нотлох материалаас маргаантай холбоотой бодит байдлыг магадлан тогтоосноор, түүндээ үндэслэн оновчтой шийдвэрийн төсөл боловсруулж, байдлаас шалтгаалан зохистой хугацаанд шийдлийг маргалдагч талуудад дэлгэн үзүүлж, итгүүлэх зохицуулалтыг идэвхтэй явуулах үүрэг шаардлагатай болж ирж байгааг урьдчилан мэдэж, энэ хандлага руу зуучлалын ажиллагаа чиглэхийг мэдэж байх ёстой болов уу.

Эвлэрүүлэн зуучлагч нь дан ганц маргалдагч талуудын тохиролцоонд найдалгүй, тэдгээрийн эвлэрлийн санал ёс зүйд нийцэн, бодит байдалтай уялдсан эсэхийг дүгнэж, тохиролцоонд нөлөөлж зөвтгөж хэлэх эрхтэй байх ёстой. Манай хуулиар шүүгч эвлэрлийн гэрээг баталгаажуулахдаа гэрээ хуульд нийцсэн эсэх, гуравдагч этгээдийн эрх хөндөгдсөн эсэхийг хянах эрхтэй байгаа нь ач холбогдолтой болсон байна.

Цаашид эвлэрүүлэн зуучлалын хэрэгт нийгэм, эдийн засгийн нарийн төвөгтэй, олон янзын маргаан олшрох ба ард түмний хууль эрхийн боловсрол өндөр болохын зэрэгцээ маргааны агуулга нарийн төвөгтэй, хэцүү бэрх болох нь дамжиггүй тул эвлэрүүлэн зуучлалын ирээдүйн чиг хандлагыг мэдэх нь зөв юм.

Мөн хуульч хүний тоо нэмэгдсэний нөлөөгөөр өмгөөлөгч оролцох хэргийн тоо

өсөх тул эвлэрүүлэн зуучлалд өмгөөлөгч шүүхийн бус аргыг ашиглахыг зорих нь ач холбогдолтой болно.

Дээрх байдалд дүгнэлт хийхэд мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагчдын тоог нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлагчийн чадварыг бэхжүүлэх, эвлэрүүлэн зуучлагч нарт тогтмол сургалт явуулж байх шаардлагатай байна.

Түүнчлэн одоогоор хуульд шууд заагаагүй ч эвлэрүүлэн зуучлал явуулах хэлбэр улам хялбар, чирэгдэл багатай болж байгааг мэдэх нь чухал бөгөөд манайд хэрэгжүүлэх ч нөхцөл бололцоо бий. Жишээ нь:

Маргалдагч тал нь алс амьдардаг, биечлэн ирэх боломжгүй зэрэг шалтгааны улмаас шүүхэд өөрийн биеэр ирэх нь хүндрэлтэй байх тохиолдолд, эвлэрүүлэн зуучлагч өргөдлийг хүргүүлэх, тайлбар авах, түүний эвлэрлийн саналыг урьдчилан бичгээр хүлээн авч, харин нөгөө тал нь товлосон хугацаанд эвлэрүүлэн зуучлагч дээр биеэр ирж тухайн саналыг хүлээн авсан үед талуудыг харилцан тохиролцсон гэж үздэг байна.

Мөн утасны хурлын систем болон теле-хурлын системээс хамаарах эвлэрүүлэн зуучлах ажиллагаа байдаг байна. Энэ ажиллагаанд гэрлэлт цуцлах хэргүүдийг хамааруулдаггүй, бусад маргаанд хэрэглэх боломжтой юм байна. Маргалдагч 2 тал хоёулаа шүүхэд биеэр очилгүй, талууд болон шүүхийг утасны хурлын системд холбон эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно.

Эдгээр арга сүүлийн үед зарим эрх зүйн маргааны эвлэрүүлэн зуучлалд өргөн ашиглагдаж байгаа юм байна.

Эвлэрүүлэн зуучлал хэрэгжиж эхэлж байгаа энэ үед шүүхийн бус энэ аргын зарчмын асуудал болон ирээдүйн хандлага хөгжлийн талаар мэдэж сонссон зүйлээ та бүхэнд хэрэг болох болов уу гэдэг үүднээс хүргүүлээ.

---o0o---

АЖ АХУЙН МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГААР ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ, ДАВУУ ТАЛ БА АНХААРАХ АСУУДАЛ: ШҮҮХИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ



*Хууль зүйн чндэсний хүрээлэнгийн дэд захирал, Хууль зүйн ухааны доктор
Б. Амарсанаа*

Энэ богино өгүүлээр аж ахуйн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж болох эсэх, аж ахуйн маргаан нь бусад иргэний эрх зүйн маргаанаас хэрхэн ялгарах, шүүхээр маргаан шийдвэрлэхээс эвлэрүүлэн зуучлал нь ямар давуу талтай, энэ төрлийн маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэхэд юуг анхаарах талаар авч үзсэн болно. Ийнхүү мэдлэгийг таниулах байдлаар энэ өгүүлийг бичих болсон нь эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа шинэ тутам байгаа, мэдлэг, мэдээллийн шинжтэй зүйлс төдийлөн элбэг биш байгаатай холбоотой юм. Энэ өгүүлийн хүрээнд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаас гадна, шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг хамтад нь авч үзсэн болно.

Аж ахуйн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх боломж

Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол Улсын хуулийн 3-р зүйлийн 3.1-д

“Иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ”, 3.2-т “...бусад харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэж болно” гэж заажээ. Энэ нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хоорондын маргаан зэрэг аж ахуйн маргааныг хуулиар шийдвэрлэж болохыг заасан мэт ойлгогдож болох боловч хөдөлмөр, гэр бүлийн харилцааг иргэний эрх зүйн маргаанаас ялгаж томьёолсон нь тодорхой эргэлзээ төрүүлж буй юм. Гэхдээ энэ өгүүлийн хүрээнд аж ахуйн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж болно гэж үзлээ.

Үүнээс гадна аж ахуйн маргааныг шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын замаар шийдвэрлэх явдал гадаадын зарим улсад бага байна.¹ Үүнийг тайлбарлах хэд хэдэн шалтгаан байхыг үгүйсгэхгүй юм. Тухайлбал, гадаад улсууд дахь бизнесийн байгууллага нь ихэнхдээ маргаанаа шийдвэрлэх тогтсон өөр механизмтай болсноос эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх шаардлагагүй байгаа байдал, мөн өөрийн гэрээт хуульч, хуулийн фирмийн тусламжтайгаар маргаанаа илүү мэргэшсэн хүрээнд шийдвэрлэх санхүүгийн боломжтой байдагтай холбоотой байж болох юм. Мөн эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхгүй байх нэг гол шалтгаан нь хуулийн этгээдийн нууцтай холбоотой

¹ Тухайлбал, Япон улсын хувьд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгддэг, түүнд хандаг аж ахуйн маргаан төдийлөн их биш юм. Японы ЖАЙКА олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтын гарын авлага Textbook for the country focused training course in Mediation trainers' training, 2014.01.13-24, Токио, Япон улс.

асуудлыг гуравдагч этгээд болох шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид дэлгэх сонирхолгүй байх асуудал юм.

Гэвч Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалыг бизнесийн маргаанд хэрэглэх боломжийг бий болгож байгаа тодорхой шалтгаан бий гэж үзэж болно. Манай улсын бизнесийн байгууллагын хувьд ихэнх компани нь нэг этгээд, эсхүл найз нөхөд, гэр бүлийн хүрээнд байгуулагдсан байдаг¹, маргааны үнийн дүн төдийлөн өндөр биш,² хоорондын үл ойлголцол, “хардалт”-аас ихэнхдээ үүсдэг зэрэг шинж бүхий маргаан зонхилдог. Маргаанаа шийдвэрлэхийн тулд хуульч эсхүл маргаанд дэм болох мэргэжлийн этгээдийг байнга хөлслөн ажиллуулах заншил аж ахуйн практикт тогтоогүй, ийнхүү ажиллуулах санхүүгийн боломж тааруу, харин өөрсдөө албан бус хүрээнд шийдвэрлэхийг оролдож байгаа байдал зэрэг нь харьцангуй зардал багатай хувилбар болох шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаар аж ахуйн маргааныг шийдвэрлэх орон зайг бий болгож байгаа юм.

Аж ахуйн маргаан ба бусад төрлийн иргэний эрх зүйн маргааны ялгаа

Энэ хүрээнд аж ахуйн маргаан болон иргэний эрх зүйн бусад маргааныг ялган авч үзэх юм. Ингэхдээ аж ахуйн маргаан нь бизнесийн байнгын үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нэг тал эсхүл аль тал нь болдог харилцааг бусад төрлийн иргэний эрх зүйн харилцаанаас ялгаж ойлгосон болно.³ Ингэж авч үзэх боломжтой талаар социологийн судалгаа ч хийгдсэн байдаг.⁴ Энэ судалгаагаар бизнесмен нь

шийдвэр гаргахдаа жирийн иргэдээс өөр үнэлэмжээр асуудалд ханддаг, энэ нь маргааныг шийдвэрлэхэд ч хамааралтай тухай дурджээ.

Аж ахуйн маргаан нь бусад иргэний эрх зүйн маргаанаас дараах шинжээр ялгардаг гэж үзэж болно.

- Аж ахуйн маргааны хувьд маргаан шийдэгдсэний дараа ч маргалдагч талууд аж ахуйн харилцаагаа цааш үргэлжлүүлэх магадлал маш өндөр байдаг. Энэ нь бизнесийн тодорхой нэг салбарт тоглогч цөөн байдаг улсын хувьд илүү хамааралтай. Жишээ нь програмын компани өөр нэг байгууллагад www.legalinfo.mn-г шинээр бичээд энэ программаа урт хугацаанд, найдвартай ажиллуулах засвар үйлчилгээ хийх агуулгатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Эдгээрийн хооронд маргаан гарвал гэрээгээ цуцлах, эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх боломжит хувилбарууд бий. Энэ тохиолдолд гэрээгээ цуцлах нь программын захиалга өгсөн компанийн хувьд ашиггүй бөгөөд учир нь өөр компани засвар, үйлчилгээ хийх нь үндсэндээ боломжгүй байдаг.

- Хурдан хугацаанд шийдэхгүй бол зөвхөн маргалдаж байгаа аж ахуйн үйл ажиллагаа болох маргааны зүйл нь ач холбогдолгүй, зарим тохиолдолд талуудын аль алинд нь хохиролтой болох магадлал бусад маргааны төрлөөс илүүтэй байдаг. Жишээлбэл, аж ахуйн үндсэн үйл ажиллагаанд анхаарахаас илүүтэй маргаанд анхаарлаа төвлөрүүлдэг учир зээлийн эргэн төлөлт хүндрэх өндөр магадлал бий болдог.

- Аж ахуйн үйл ажиллагаа нь нэг удаагийн, эсхүл байнгын бөгөөд давтамжтай бус шинжтэй ашиг олж байгаа иргэний эрх зүйн харилцаанаас агуулга, бусдад үзүүлэх нөлөөллийн хувьд ялгаатай байдаг.

- Бизнесийн маргаан нь харьцангуй нарийн нийлмэл, олон зүйл холилдсон байх нь элбэг. Нэг нь ялагдах, нөгөө

¹⁴ Монгол Улсын Компанийн засаглалын үндэсний тайлан 2013, Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын үндэсний зөвлөл, 2013.

¹⁵ Үнийн дүн болон мэргэжлийн этгээд хөлстэйгээр зуучлах магадлал хоёр нь шууд хамааралтай.

¹⁶ Жишээлбэл, ХБНГУ-д худалдаачны бүртгэл гэж байдаг. Энэ нь аж ахуйг тогтмол эрхэлж байгаа этгээд гэдэг агуулгыг зарим талаар илэрхийлдэг байна.

⁴ Macaulay, Stewart. "Non-contractual relations in business: A preliminary study." *American sociological review* 28.1 (1963): 55-67.

ялах гэдэг байдлаас илүү аль аль талын хувьд зөв, буруу байдал “холилдсон” байх бололцоотой. Жишээлбэл, хэд хэдэн удаа зээл авсан, зарим мөнгөн төлбөрийг буцаан төлж байсан тохиолдолд зээлээ буцаан төлсөн гэдэг нь тодорхойгүй, хэдийд зээлсэн мөнгөө буцаан төлсөн нь ойлгомжгүй байх боломжтой байдаг нь түүний нарийн нийлмэл, эмх цэгцгүй байдлыг илэрхийлэх юм.

Аж ахуйн маргааныг эвлэрүүлэн зуучлалын замаар шийдвэрлэх давуу тал

1. Аж ахуйн маргааны онцлог, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны онцлогтой холбоотой давуу тал

Орчин үед шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх механизмын олон төрөл, хэлбэрийг аж ахуйн маргаанд өргөнөөр хэрэглэж байгаа билээ.¹ Тухайлбал, арбитрын журмаар хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааг аж ахуй эрхлэгчид шүүхийн журмаар маргаанаа шийдвэрлүүлэхээс илүүтэйгээр сонгох хандлагатай болсон.

Аж ахуйн үйл ажиллагааны онцлог нь түүний олон талтай, нарийн нийлмэл байх шинж юм. Иймээс ийм төрлийн маргааныг шийдвэрлэхэд зарим тохиолдолд хууль тогтоомж тодорхой хариулт өгөхгүй байх нь цөөнгүй. Өөрөөр хэлбэл, маргалдагч хоёр тал болох аж ахуйн харилцаанд оролцсон талуудын

маргалдаж байгаа асуудлыг бүхэлд нь авч үзэх боломж зарим тохиолдолд хууль тогтоомжийн уян хатан бус шинжтэй холбоотойгоор хязгаарлагдмал байдалд орох нь бий.

Дээрх нь эвлэрүүлэн зуучлалын үед хууль тогтоомжийг заавал мөрдлөг болгох уу, тодорхой эрх зүйн хэм хэмжээг заавал үндэс болгох уу, эсхүл хуулийг хэмжүүр болголгүйгээр маргааныг шийдвэрлэж болох уу гэдэг эвлэрүүлэн зуучлалыг хийх арга техниктэй холбоотой үндсэн маргаантай холбогдож ирдэг. Энэ талаар нэлээдгүй судалгааны ажил, онолын маргаан өрнөсөн.¹ Дээр дурдсан аж ахуйн үйл ажиллагааны нарийн нийлмэл, олон тал шинжийг харгалзан үзвэл хуулийг заавал хэрэглэхгүйгээр маргааныг шийдвэрлэх нь аж ахуйн маргаанд бусад төрлийн маргаанаас илүүтэй зохимжтой байж болох онцлог харагдаж байгаа юм. Гэхдээ нөгөө талаас хуулийг ямар хэмжээнд хэрэглэх нь эвлэрүүлэн зуучлагчийн арга барилаас хамааралтай байдаг гэдэг дүгнэлтийг ч хийсэн байх нь бий.²

Мөн эвлэрүүлэн зуучлал нь эрх зүйн хэм хэмжээг тулгах байдлаар биш харин маргалдагч талуудыг дундын үнэт зүйлээ олоход туслах замаар тэдгээрийн харилцааг дахин шинэ байдлаар томьёолох боломжтой.³ Энэ нь бизнесээ цааш үргэлжлүүлэн явуулах бизнесийн шаардлагатай яв цав нийцэж буй юм.

Цаг хугацааны хүчин зүйл нь аж ахуйн маргааныг шийдвэрлэхэд маш чухал хүчин зүйл байдаг. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа урт хугацаанд явагддагаас маргалдагч тал нь бизнесийн үйл ажиллагаагаа цааш үргэлжлүүлэн

¹ Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх аргыг компаниуд ихээхэн хэрэглэх болсон талаар Stipanowich, Thomas and Lamare, J. Ryan, Living with 'ADR': Evolving Perceptions and Use of Mediation, Arbitration and Conflict Management in Fortune 1,000 Corporations (February 19, 2013). Harvard Negotiation Law Review, Forthcoming; Pepperdine University Legal Studies Research Paper No. 2013/16. Available at SSRN: <http://ssrn.com/abstract=2221471> or <http://dx.doi.org/10.2139/ssrn.2221471>. Эвлэрүүлэн зуучлал аж ахуйн маргаанд улам бүр хэрэглэгдэх болсон талаар Nolan-Haley, Jacqueline M., Mediation: The 'New Arbitration'. Harvard Negotiation Law Review, Forthcoming; Fordham Law Legal Studies Research Paper No. 1713928. Available at SSRN: <http://ssrn.com/abstract=1713928>.

¹ Jacqueline M. Nolan-Haley, Court Mediation and the Search for Justice Through Law, 74 Wash. U. L. Q. 47-102 (1996). Available at: <http://digitalcommons.law.wustl.edu/lawreview/vol74/iss1/3>

² Jacqueline M. Nolan-Haley, Court Mediation and the Search for Justice Through Law, 74 Wash. U. L. Q. 50 (1996).

³ Lon L. Fuller, Mediation-Its Forms and Functions, 44 S. CAL. L. REV. 305, 325 (1971).

явуулах бодит шаардлага алга болсон тохиолдолд маргаанаа эцсээ хүртэл үргэлжлүүлэх zero sum¹ гэгддэг байдалд хүргэдэг. Өөрөөр хэлбэл цаг хугацааны хувьд ашиггүй болбол талууд маргаанаа эцэст нь хүртэл үргэлжлүүлэх шийдэлд хүрдэг бол эвлэрүүлэн зуучлалыг амжилттай явуулсан тохиолдолд маргааныг илүү богино хугацаанд шийдвэрлэх боломжтой, non-zero sum байдалд маргаанаа шийдэж болдог.

Эвлэрүүлэн зуучлалаар аж ахуйн маргааныг шийдвэрлэх давуу тал нь одоогийн практикт түгээмэл байгаа асуудалтай холбогддог. Тухайлбал, практикт бизнесийн байгууллага гэрээгээ хэт ерөнхий байдлаар, хуулийн зүйл заалтыг үндсэнд нь хуулсан, өөрсдийн хүсэл зоригийг төдийлөн багтаагаагүй байдлаар байгуулсан байдаг нь түгээмэл хандлага байна.² Энэ тохиолдолд шүүх хуралдааны замаар талууд мэтгэлцэх байдлаар шийдэхээс илүүтэй харилцан ярилцах байдлаар шийдвэр гаргадаг эвлэрүүлэн зуучлалын арга нь илүү зохимжтой юм. Учир нь мэтгэлцэхээс илүүтэй харилцан ярилцах, фактыг тогтоох хандлагыг илүүтэй агуулдагт эвлэрүүлэн зуучлалын давуу тал оршиж байгаа юм.

2. Зардлын холбогдолтой давуу тал

Дээрхээс гадна эвлэрүүлэн зуучлал нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас зардлын хувьд илт давуу байдлыг бий болгодог. Тухайлбал, шийдвэр гаргуулахтай холбогдсон зардал, менежер шүүхэд бэлтгэх зардал, нөгөө талын тайлбарт хариу өгөх зардал, алдагдсан боломжийн зардал, бизнесийн харилцааны зардал, бусад зардал зэргийг энд дурдаж болно. Эдгээрийг товч тайлбарлая.

Шийдвэр гаргуулахтай холбогдсон зардал гэдэг нь шүүхэд маргааныг хэлэлцүүлэхэд нотлох баримт болохыг хүлээн зөвшөөрөх тусгайлсан журам үйлчилдгээс шүүгч шийдвэр гаргахын тулд бичгээр нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, нотлох баримтыг бусад этгээдээс гаргуулах, шинжээчийн мэдүүлэг авах тохиолдол байдаг. Энэ нь бүгд зардал шаарддаг. Дараагийн нэг зардал нь компанийн менежерүүд нь шүүх хуралд хэрхэн оролцох, ямар мэдүүлэг өгөх вэ, ямар нотлох баримтыг гаргах вэ зэргээр маш олон цагийг шүүх ажиллагаанд зориулдаг, ингэж сайтар бэлтгэхгүй бол эрх зүйн үр дагаварт хүргэдэг учраас үүнд маш их зардал гаргадаг байна.

Нэгэнт маргаан нь хоёр болон түүнээс олон оролцогчтой учраас нөгөө тал нь заавал нотлох баримт, хариу тайлбар гаргадаг. Үүнтэй танилцах, хариу тайлбар өгөх зэргээр зөвхөн өөрийн талаас гарах үйл ажиллагаатай холбоотой бус, нөгөө талаас хамааралтайгаар гарах зардал ч бий. Өөрөөр хэлбэл, маргааны нөгөө тал нь нэг талаасаа гарах зардлыг өсгөх байдалд хүргэх боломжтой байдаг. Алдагдсан боломжийн зардал гэдэг нь компанийн удирдлага болох менежер нь бизнесийн үйл ажиллагаандаа анхаарч ашиг олохын төлөө цагаа зарцуулах ёстой байдаг бол нэгэнт энэ цагаас тодорхой хэмжээтэйг өөр зүйлд зарцуулах учир хэвийн үед олох ёстой байсан ашгаа шүүхийн урт процессын туршид алддаг гэж үздэг. Бизнес нь бизнесээ хийснээр ашиг олдоогоос биш шүүхэд нэхэмжлэл гаргаснаар, эсхүл хариу тайлбар гаргаснаар ашиг олдоггүй билээ.

Бизнесийн харилцааны зардал гэдэг нь шүүхэд тухайн бизнесийн байгууллага маргаан бүхий байдалд байгаатай нь холбогдож гарч ирдэг. Тодруулбал, уул уурхайн компани тодорхой тусгай зөвшөөрлийн тухайд шүүхдэлцэж байгаа нь өөр тусгай зөвшөөрөлтэй нь холбогдуулан аж ахуйн харилцаанд оролцох гэж байгаа хөрөнгө оруулагчдыг үргээх, стратегийн

⁴² Энэ талаар Ken Binmore, *Playing for real: a text on game theory*, (2007) 1 ба 7 бүлэг үзнэ үү.

⁴³ Б. Амарсанаа "Гэрээний маргаан ба эвлэрүүлэн зуучлагчид тулгамдах асуудал" Эвлэрүүлэн зуучлагчийн давтан сургалт Шүүхийн ерөнхий зөвлөл, Жайкагийн "Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах" төсөл, Монгол-Япон төв (2013.10.09).

түншлэлээс зайлсхийх үндэслэл ч болох нь бий. Энэ нь шүүхийн процесс нийтэд нээлттэй байдагтай хамааралтай юм. Дээрхээс гадна аж ахуйн маргааны шийдэл нь тодорхой байсан ч нөгөө тал нь зориудаар ажиллагааг хүндрэлтэй, төвөгтэй болгох аргыг сонгох явдал элбэг байдаг. Энэ нь бодит практикт зардлыг өсгөдөг сул талтай.

Харин эвлэрүүлэн зуучлалд талууд өөрсдөө маргааныг шийдвэрлэдэг, санаачилга тэдний гарт байдаг учраас харьцангуй зардал багатайгаар шийдвэрлэх бүрэн боломжтой байдаг нь аж ахуйн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх эдийн засгийн хөшүүрэг болох боломжтой юм. Эрх зүйн асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн хүчин зүйл чухал нөлөөтэй байдаг гэдэг нь өнөөдөр тодорхой болоод байгаа билээ.¹

Аж ахуйн маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх арга, тактик, анхаарах асуудал

Эвлэрүүлэн зуучлагч, маргааны тал, тэдгээрийн өмгөөлөгч нь энэ төрлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахдаа эвлэрүүлэн зуучлалын нийтлэг яригддаг арга, тактикаас гадна дор дурдсан зүйлсийг анхаарах нь зүйтэй болов уу.²

1. Өмнө дурдсанаар эвлэрүүлэн зуучлалыг аж ахуйн маргаанд хэрэглэх боломж нь түүний богино цаг хугацаанд

шийдэлд хүрдэгтэй холбоотой болох нь харагдсан. Иймээс ийм төрлийн маргааныг хэдэн удаагийн уулзалтаар, ямар цаг хугацаанд шийдвэрлэх нь зүйтэй болох нь чухал болдог. Бодит практикийг харахад эвлэрүүлэн зуучлалаар шийдэгдэж байгаа маргаан 2-4 удаагийн уулзалтаар шийдвэрлэгддэг гэсэн тоо байдаг.¹ Хэрэв ийм хугацаанд асуудлыг шийдвэрлэж чадвал ихэнх аж ахуйн шинжтэй маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдэх нь шүүхийн журмаар шийдэхээс илт давуу талтай болох нь ойлгомжтой. Богино хугацаанд шийдэхийн тулд авах арга хэмжээ нь нэг удаагийн уулзалтыг ойролцоогоор 1 цаг орчим үргэлжлүүлэх хязгаар тогтоож мөрдөх нь талуудыг цэгцтэй байх, сэтгэл хөдлөлийн шинжтэй боловч маргаан шийдвэрлэхэд төдийлөн ач холбогдолгүй зүйлсийг хамруулан ярих явдлаас сэргийлж, улмаар цаг хэмнэх юм.

2. Аж ахуйн маргаан нь олон талтай, нарийн нийлмэл байдгаас талуудын яриаг сонссоны дараа эвлэрүүлэн зуучлалыг үнэлэх хэлбэрээр явуулах уу, эсхүл дэмжлэг үзүүлэх хэлбэрээр явуулах уу гэдэг аргаа сонгох нь зүйтэй байдаг.² Гэхдээ тодорхой үйл явдал болсон эсэх тухай фактын маргааныг шийдвэрлэх нь илүү тохиромжтой байдаг учир бизнесийн маргааны хувьд үнэлэх хэлбэрээр эвлэрүүлэн зуучлалыг явуулах нь илүү тохиромжтой байж болох юм. Учир нь аж ахуйн маргаанд сэтгэл зүйн хүчин зүйл бага байдаг, талууд нь нөхцөл байдлыг илүү ухамсарласан байдаг тул тэдгээрийн хувьд нэгдсэн нэг ойлголтыг эвлэрүүлэн зуучлагч бий болгох замаар үнэлэх шалгуурыг бий болгох нь илүү үр дүнтэй байх талтай. Үнэлэх хэлбэрийн тухайд үнэлгээний тодорхой цензурыг гаргаж хүлээн зөвшөөрүүлэх, эвлэрүүлэн

¹ Richard A. Posner, *Economic Analysis of Law*, (2007). Richard A. Posner, "Economic Approach to Legal Procedure and Judicial Administration, An," 2 *Journal of Legal Studies* 399 (1973).

² Эвлэрүүлэн зуучлалаар маргаан шийдвэрлэх аргын талаар Л. Өлзийхүү Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад маргаан шийдвэрлэх аргууд, Эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан гарын авлага, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл (2014) т. 149-157. Маргааны төрөлтэй холбогдуулан эвлэрүүлэн зуучлал явуулах арга ажиллагааны онцлогийн талаар С. Болормаа Хөдөлмөрийн маргаантай хэргийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, Б. Оюу Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах нь, Эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан гарын авлага, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл (2014) т. 133-148, 158-161.

³ Японы Коуцужико фүнсэсэйри сэнга, Жигио но гайсё 2013, (2013.09), т. 11.

⁴ Сугавара Икүо, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны сэтгэл судлал, Японы Жайка олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтын гарын авлага, Textbook for the country focused training course in Mediation trainers' training, 2014.01.13-24, Токио, Япон улс.

зуучлагчид итгэх итгэлийг бий болгох шаардлагатай байдаг бол дэмжлэг үзүүлэх хэлбэрийн тухайд аль болох эхлээд сонсож, дараа нь маргааны эх үүсвэрийг тодорхой болгох нь зүйтэй, ингээд харилцан тохиролцоход саад болох хүчин зүйлийг арилгах тактикийг барьдаг байна. Зарим тохиолдолд дээрх хоёр хэлбэрийн аль алийг нь хэрэглэж болох юм.

3. Аж ахуйн маргаанд өмгөөлөгч оролцох магадлал өндөр юм. Иймд эвлэрүүлэн зуучлагч болон талууд нь өмгөөлөгчийг оролцуулахдаа харилцан тохиролцсоны үндсэн эрх зүйн туслалцаа авах нь зүйтэй юм. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд ч энэ талаар заасан байдаг.⁴⁸ Учир нь талууд харилцан ярилцсаны үндсэн дээр өөрсдөө маргааны шийдэлд хүрдэг учраас нэг оролцогч өмгөөлөгчтэй байх нь эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, тэнцвэртэй бус байдлыг бий болгох сул талтай.

4. Эвлэрүүлэн зуучлал нь эрх зүйн маргаанаас илүүтэй болсон үйл явдал, факттай холбоотой маргааныг шийдвэрлэхэд илүү зохимжтой байх нь бий. Маргалдагч талууд нь фактын хувьд үл ойлголцсон, зөрүүтэй мэдээлэлтэй байх магадлалтайг байнга санаж үүнийг тодруулж байх нь зүйтэй байдаг. Эрх зүйн маргааныг төдийлөн авч үзэхгүйгээр тухайн маргааныг шийдвэрлэх орон зай байдгийг анхаарах нь зүйтэй. Эдгээрийн жишээг авч үзвэл, фактын маргаан нь иргэн А, Б нар гэрээ байгуулсны үндсэн дээр тодорхой зүйл авч өгөлцсөн эсэх тухай байдаг бол эрх зүйн маргаан нь А, Б нар нь Компанийн тухай хуульд заасан гэрээ байгуулсан эсэх талаар байдаг.

5. Эвлэрүүлэн зуучлалыг явуулахдаа талуудыг нэг дор хамтад нь, эсхүл тус тусад нь уулзалт хийх арга байдаг. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 24 зүйлийн 24.2-т талуудтай хамтад нь уулзахаар зарчмын

хувьд шийдвэрлэсэн бөгөөд шаардлагатай тохиолдолд ганцаарчлан уулзах боломжийг хуулиар бий болгожээ. Хамтад нь уулзах аргын хувьд эвлэрүүлэн зуучлагч нь талуудын хэлж байгаа мэдээллийг дайгч, дамжуулагч болдоггүй, талууд шууд нөгөө талын хүсэл зоригийг сонсох боломжтой байдаг. Энэ нь манай хуулийн давуу тал хэмээн үзэх нь бий бөгөөд зарим улсад одоогоор тус тусад нь уулзах хандлага голлосон байдалтай байна.⁴⁹ Харин тус тусад нь уулзах аргын хувьд учир байдлыг аль нэг талаас тухайлан асуух боломжийг агуулдаг сайн талтай бөгөөд энэ нь хуульд заасан “шаардлагатай тохиолдол” гэдгийг тайлбарлах нэг үндэслэл болж болох юм. Өөрөөр хэлбэл, аль аргыг хэрэглэхээ талуудын байдалд үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй юм.

6. Эвлэрүүлэн зуучлалын хувьд шийдвэр гаргах хувилбаруудыг талуудад санал болгох эрхтэй эсэх асуудал байдаг. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 зүйлийн 14.1.5-д эвлэрүүлэн зуучлагч нь ийм эрхтэй байхаар заасан байдаг боловч хуультай илт зөрчилдсөн байдлаар эвлэрлийн хувилбарыг гаргаж болохгүй юм. Ялангуяа аж ахуйн маргааны нарийн нийлмэл, төвөгтэй байдалтай холбоотойгоор талуудыг сайтар сонссоны үндсэн дээр хувилбарыг санал болгох нь зүйтэй.

7. Эвлэрүүлэн зуучлагч нь материаллаг эрх зүйн хангалттай мэдлэгтэй байх хэрэгтэй байдаг. Тухайлбал, компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд гарах маргааны хувьд Компанийн тухай хуулиас гадна тэдгээрийн хооронд байгуулсан гэрээ, ялангуяа компанийн дүрмийн заалтыг нарийвчлан шинжлэх, түүний ач холбогдлыг зайлшгүй ялган ойлгох шаардлагатай. Мөн эвлэрүүлэн зуучлалын бус шүүхийн журмаар шийдэгдвэл санаачилгыг талууд биш гуравдагч этгээд болох шүүгч дангаар шийдэх боломжтой болохыг талуудад тайлбар нь зүйтэй.

⁴⁸ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012) 12 зүйл 12.4.

⁴⁹ Жишээлбэл, Япон улсад одоогоор тус тусад нь уулзах аргыг голчлон хэрэглэж байна.

Нэгтгэн үзвэл

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг аж ахуйн маргаанд хэрэглэж болох нь харагдаж байна. Аж ахуйн маргаан гэдгийг энэ өгүүлэлд авч үзсэн байнгын, давтамжтайгаар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг “мэргэжлийн оролцогч” маргааны аль нэг тал болдог гэдэг утгаар ойлгох нь зүйтэй юм. Эвлэрүүлэн зуучлалд хандах боломжтой аж ахуйн маргаан нь бага хэмжээний үнийн дүнтэй маргаан байж болохоос гадна зардлын хүчин зүйлийг тооцвол аж ахуйн томоохон байгууллагуудын хоорондын маргаанд ч хэрэглэгдэх боломжтой байна.

Дээр дурдсаныг нэгтгэн авч үзвэл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай явагдахад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй байна.

1. Аж ахуйн маргааны талууд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хандах магадлал нь эвлэрүүлэн зуучлагчийн аж ахуйн үйл ажиллагааг ойлгох байдал, ур чадвар, нууцлалыг хэрхэн хангах, эвлэрүүлэн зуучлалын хүрээнд яригдсан зүйлс нь цааш маргаан үргэлжлэх үед хэрхэн эерэгээр болон сөргөөр нөлөөлөх, энэ байдлыг эвлэрүүлэн зуучлагч хэрхэн удирдах, хяналтдаа байлгахаас хамаарахаар байна. Өөрөөр хэлбэл, Эвлэрүүлэн зуучлал явуулах арга, тактик нь маш чухал хүчин зүйл юм.

2. Мөн эвлэрүүлэн зуучлал өргөнөөр хэрэглэгдэх, улмаар шүүхийн ачааллыг бууруулах боломж нь энэ өгүүлэлд дурдагдсан эрх зүйн хүчин зүйлээс гадна маргалдагч талуудыг шүүхэд хандахаас бага зардлаар маргаан шийдвэрлэх боломжийг олгодог давуу талтайг анхаарч, эвлэрүүлэн зуучлагч, шүүх зэрэг этгээд нь эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог Монгол Улсад төлөвшүүлэх арга хэмжээг авахдаа тооцох нь зүйтэй байна.

---o0o---

ХӨДӨЛМӨРИЙН МАРГААНТАЙ ХЭРГИЙГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГААР ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



МУИС-ийн ХЭС-ийн Иргэний эрх зүйн
тэнхимийн ахлах багш, докторант,
Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн
 гишүүн С.Болормаа

Удиртгал

ADR буюу Alternative Dispute Resolution, орос хэлэнд Альтернативное решение спора¹ гэдэг нь хэлэлцээ, эвлэрүүлэн зуучлал, арбитр, шүүх дэх эвлэрэл гэх зэрэг утгыг агуулж буй шүүхийн бус аргаар хэрэг маргааныг шийдвэрлэх аргуудыг илэрхийлсэн өргөн ойлголт юм.

Улсын Их Хурлаас 2012 оны 05-р сарын 22-ны өдөр батлагдсан Монгол Улсын “Эвлэрүүлэн зуучлалын тухай” хуулиар иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээр хуульчилсан.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүсэж буй маргааныг хөдөлмөрийн хамтын болон ганцаарчилсан маргаан хэмээн

ангилах ба **хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан** гэж хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлын хүрээнд **хөдөлмөрийн гэрээний** талуудын хооронд үүссэн саналын зөрүүг хэлдэг. Үүнээс үзэхэд хуульд зааснаар эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх маргаан нь зөвхөн хөдөлмөрийн гэрээний талуудын хооронд буюу ажилтан-ажил олгогчийн хооронд үүссэн байдгаараа онцлогтой.

Хөдөлмөрийн харилцааны явцад хөдөлмөрийн гэрээний талуудын хооронд хөдөлмөрлөх эрх ашиг нь зөрчигдсөнтэй холбоотой тухайлбал: ажилтны цалин хөлсийг бууруулах, сахилгын шийтгэл ногдуулах, өөр ажил албан тушаалд үндэслэлгүйгээр шилжүүлэх, ажлаас халах, илүү цагийн хөлсийг олгохгүй байх, ээлжийн амралтын олговрыг буруу тооцож олгох, үндэслэлгүйгээр суутгал хийх гэх мэт олон асуудлаар санал зөрөлдөөн буюу маргаан үүсдэг.

Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан чухам ямар үндэслэлээр үүсэж байгаагаас нь хамааруулан хуульд зааснаар Хөдөлмөрийн маргаан таслах комисс, шүүх тус тус өөрийн эрх хэмжээний хүрээнд хянан шийдвэрлэх ба шүүхэд харьяалуулан шийдвэрлэхээс бусад маргаан нь урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар Хөдөлмөрийн маргаан таслах комиссоор шийдвэрлүүлдэг.

Тухайн хэрэг маргааныг зөвхөн шүүх шийдвэрлэхээр хуульд заасан бол уг маргаан шүүхийн тусгай харьяалалд хамаардаг.¹

¹⁰ Юридический энциклопедический словарь., Москва. 2003. Стр 18,351

¹¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ.2008 оны 64 дэх тал

Жишээ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2-т зааснаар ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдлыг шүүх шийдвэрлэхээр хуульд заажээ.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30-р зүйлд зааснаар Шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаар хуульчилсан ба тиймээс зөвхөн шүүхээр хянан шийдвэрлэх **хөдөлмөрийн ганцаарчилсан маргаанд** эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж болох бөгөөд уг хуулийн зохицуулалт хамаарч үйлчилдгээрээ онцлогтой.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаар эвлэрүүлэн зуучлалаар хянан шийдвэрлэх хөдөлмөрийн ганцаарчилсан маргаанд дараах маргаанууд хамаарна. Үүнд:

1. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг давж заалдсан гомдол;
2. ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдол;
3. ажилтнаас хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байхдаа аж ахуйн нэгж, байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн нэхэмжлэл;
4. хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үед эрүүл мэнд нь хохирсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажилтны нэхэмжлэл;
5. ажлаас буруу халсан буюу буруу шилжүүлсэн үеийн олговортой холбоотой асуудлаар гарсан маргаан;

6. иргэн хоорондын хөдөлмөрийн гэрээтэй холбогдон гарсан маргаан;
7. сахилгын шийтгэл буруу ногдуулсан тухай ажилтны гомдол;
8. хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хууль тогтоомж болон хамтын гэрээнд зааснаас дордуулсан тухай ажилтны нэхэмжлэл;
9. хөдөлмөрийн дотоод журам хөдөлмөрийн харилцааг зохицуулахаар өөрийн онцлогт тохируулан тогтоосон байгууллагын бусад тушаал, шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй тухай ажилтны нэхэмжлэл;
10. хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө болон хөдөлмөрөө нэгтгэн ажиллагчдын хоорондын хөдөлмөрийн маргаан;
11. хууль тогтоомжоор шүүхэд харьяалуулсан бусад маргаан.

Хөдөлмөрийн маргаантай хэргийг эвлэрүүлэн зуучлалын ажиллагаагаар шийдвэрлэхдээ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиудыг дагаж мөрдөнө.

Ажилтан хөдөлмөрийн харилцааны явцад эрх ашгаа зөрчигдсөн гэж үзвэл ажил олгогчийн оршин суугаа харьяаллын шүүхэд нэхэмжлэлээ гаргах ба шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу тухайн асуудлыг хянан хэлэлцэнэ.

Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг Хөдөлмөрийн маргаан таслах комисс болон шүүхээр тус тус харьяалан шийдвэрлэдэг талаар өмнө дурдсан ба эдгээрээс зөвхөн Хөдөлмөрийн тухай хуулийн 128-р зүйлд заасан Шүүх хянан шийдвэрлэх хөдөлмөрийн ганцаарчилсан маргаанд

эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэдгээрээ онцлогтой. Эвлэрүүлэн зуучлалыг шүүхэд иргэний хэрэг **үүсгэснээс хойш** хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх тул хөдөлмөрийн маргаан таслах комиссоор ганцаарчилсан маргааныг хянан шийдвэрлэх үед хуульд заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрэглэгдэхгүй.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хөдөлмөрийн маргааны **талуудад** ажилтан -ажил олгогч хамаардаг бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны **оролцогчдод** :

1. талуудын хууль ёсны төлөөлөгч;
2. асран хамгаалагч;
3. харгалзан дэмжигч;
4. эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд болон бусад этгээд хамаардаг.

Хөдөлмөрийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талуудын сайн дурын үндсэн дээр, оролцогчдын нууцыг хадгалан , уг ажиллагаанд оролцогч талуудын тэгш эрхийг хангах зарчимд үндэслэн явагдана.

Эвлэрүүлэх ажиллагаа явуулсан туршлагаас судалж үзэхэд уг ажиллагаа нь сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийн сөрөг байдлуудыг арилгах эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ зөвхөн маргалдагч талуудаар хязгаарлагдахгүй, мөн нийгэмд ашигтай, ач тустай үйлдэл юм¹.

Хөдөлмөрийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмаар шийдвэрлэх үйл ажиллагааг авч үзвэл:

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэх.

- Талууд шүүх дэх эвлэрүүлэн

зуучлагч, төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчид хандсан;

- Шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс зохигчид өөрсдөө эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээр тохиролцсон;
- эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрснөөр тус тус эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхэлнэ.

Иргэний хэрэг үүсгэснээс хойш гэдэгт Шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хэрэг үүсгэх захирамж гаргах ба тиймээс захирамж гарснаас хойших хугацааг ойлгодог.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талуудын аль нэг нь уг ажиллагааг зөвшөөрснөөр хийгддэг тул хэрэв аль нэг тал зөвшөөрөөгүй бол тухайн ажиллагаа эхлэх боломжгүй юм.

Талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлүүлэх хүсэлтээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид, эсхүл төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчид гаргана.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талууд оролцуулахыг зөвшөөрснөөс бусад этгээдийн хувьд хаалттай явагдана.

Эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтэй этгээд эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргана.

Эвлэрүүлэн зуучлагчийг сонгох. Талууд нэг ажиллагаанд нэг эсхүл хэд хэдэн эвлэрүүлэн зуучлагчийг сонгож

¹² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь зохигчдыг эвлэрүүлэх шүүгчийн ажиллагааны тухай Монгол улсын дээд шүүхийн 2010 оны 06 сарын 02-ны 02 дугаар зөвлөмж

болох бөгөөд талууд хэрвээ хэд хэдэн эвлэрүүлэн зуучлагч сонгосон бол зуучлагчид дотроосоо ахлагчийг сонгоно.

Талуудад мэдэгдэх. Эвлэрүүлэн зуучлагч нь өргөдөл хүлээн авсан тухай болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах товыг талуудад мэдэгдэнэ.

Уулзалт хийх. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулан хийх бөгөөд талуудад эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дэг журам, талуудын эрх үүргийг танилцуулж, талуудын шаардлага тайлбарыг сонсож, цаашдын чиглэлийг тодорхойлно. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудыг хамтран оролцуулах зарчмын дагуу явуулах бөгөөд зөвхөн шаардлагатай тохиолдолд л талуудтай ганцаарчлан уулзалт хийнэ. Эвлэрүүлэн зуучлагч нь уг ажиллагааныхаа талаар тэмдэглэлийг цаг тухайд нь хөтлөх бөгөөд тэмдэглэлд зуучлагч болон талууд гарын үсэг зурна.

Эвлэрлийн гэрээ байгуулах. Талуудыг эвлэрүүлэх ажиллагааны гол зорилго нь талуудын хооронд үүссэн маргааныг шүүхийн бус замаар эвлэрлийн аргаар шийдвэрлэж, талуудын хүсэл зоригийн илэрхийллийг тусгасан эвлэрлийн гэрээг байгуулах явдал байдаг. Эвлэрлийн гэрээг талуудын тохиролцооны агуулгыг талууд өөрсдөө тусган гэрээний төслөө боловсруулах, тэдний хүсэлтээр эвлэрүүлэн зуучлагч нэгтгэн тусгасан эвлэрлийн гэрээний төслийг боловсруулах замаар хийнэ.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд хийгдсэн эвлэрлийн гэрээ нь Иргэний хуулийн гэрээний нэг төрөл болохын хувьд гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй байх ба эвлэрлийн гэрээгээр талууд болон зохигчид нь:

- **Эвлэрэх.,** Нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд талууд эвлэрч болох бөгөөд үүнийгээ гэрээндээ тусгаж өгнө. Эвлэрэх нь талуудын

буюу нэхэмжлэгч хариуцагч 2 талын хүсэл зоригийн илэрхийлэл байдаг бөгөөд өөрөөр хэлбэл нэхэмжлэгч, хариуцагч хоёрын хүсэл зоригийн илэрхийлэл давхцсан байх ёстой. Түүнээс бус хариуцагчийн хүсэл зоригийн илэрхийллийг нэхэмжлэгч тал хүлээн зөвшөөрөөгүй бол эвлэрсэнд тооцохгүй.

- **Шаардлагыг хүлээн зөвшөөрөх.,** Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд л **шаардлагыг хүлээн зөвшөөрсөн** гэж үзэх ба харин хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагаас хариуцагч заримыг нь хүлээн зөвшөөрч, заримыг нь хүлээн зөвшөөрөөгүй бол шаардлагыг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүй. Тухайлбал: “А” нь уул уурхайн “Б” ХХКомпанид холбогдуулан ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх олговрыг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан ба хариуцагч компаниас нэхэмжлэгч “А”-г зөвхөн өмнө эрхэлж байсан ажил албан тушаалд эгүүлэн авч, харин түүнд ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх олговрыг олгохгүй байх талаар нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрчээ. Тэгвэл энэ тохиолдолд хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүй, харин нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх ба тиймээс нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн хэмээн эвлэрлийн гэрээ байгуулагдахгүй.

- **Биелүүлэх.,** Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх талаар талууд

тохиролцож гэрээндээ тусгаж болно. Энэ тохиолдолд өмнө тайлбарласантай адил хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн биелүүлэх тохиолдолд энэ нь эвлэрлийн гэрээгээр хэрэгжих ба хэрвээ уг шинжийг агуулж чадаагүй бол энэ агуулгаар эвлэрлийн гэрээ байгуулах боломжгүй.

- **Шаардлага болон нэхэмжлэлээсээ татгалзах.** Нэхэмжлэгч нь шүүхэд нэхэмжлэл гаргаснаасаа хойш нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзаж болох бөгөөд энэ талаар гэрээндээ тусгаж болно. Гэхдээ нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн бүх шаардлагаасаа татгалзсан тохиолдолд л энэ талаар гэрээндээ тусгах бөгөөд харин зарим шаардлагаасаа татгалзаад зарим шаардлагаасаа татгалзаагүй бол эвлэрсэнд тооцохгүй, маргааныг шүүхээр шийдвэрлэх үндэслэл болно.

Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд хийгдсэн эвлэрлийн гэрээний гүйцэтгэл нь зуучлагчийн эрх зүйн байдлаас хамаарч дараах онцлог шинжтэй. Үүнд:

1. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч нь биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасан "Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ

хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй" заасны дагуу шүүхэд хандах эрхтэй байдаг.

Шүүхээр эрхээ хамгаалуулахаар мэдүүлэх эрх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон журмаар хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нь хэргийн ба шүүхийн харьяалал нэхэмжлэл, гомдлын агуулга, хэлбэр болон нотлох баримт бүрдүүлэх зэрэг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохих журмыг баримтлах шаардлагатай¹.

2. Анхан шатны шүүх дэх орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана. Өөрөөр хэлбэл тухайн маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн тухай захирамж гаргана. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж нь шүүхийн шийдвэрт тавигдах бүхий л шаардлага нэг адил хамаарах бөгөөд тухайлбал удиртгал, тодорхойлох, үндэслэх, захирамжлах хэсгээс бүрдэнэ.

Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болох. Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг эвлэрүүлэн зуучлалын оролцоотойгоор шийдвэрлэх ажиллагаа нь талуудын хүсэлт болон эвлэрүүлэн зуучлагчийн санаачилгаар дараах үндэслэлээр дуусгавар болно.

¹ Монгол Улсын Дээд Шүүх "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар" УБ. 2008 он 27 дах тал

- Аль нэг тал эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцоогүй.,

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талуудын оролцоотойгоор хийгддэгээрээ онцлогтой бөгөөд тиймээс ч аль нэг тал уг ажиллагаанд оролцохгүй бол тухайн ажиллагаа дуусгавар болно.

- Уулзалт, ярилцлага удаа дараа хангалттай үр дүнд хүрээгүй, цаашид үр дүнд хүрэхгүй нь ойлгомжтой болсон буюу эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон.,

Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон боловч талууд санал зөрөлдөөнтэй хэвээр буюу эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон, уг ажиллагаа хангалттай үр дүнд хүрээгүй тохиолдолд уг ажиллагаа дуусгавар болно.

- Талууд эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлэх талаар идэвх санаачилгагүй хандсан.,

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа нь маргаанаа шүүхийн бус аргаар шийдвэрлүүлэх талуудын идэвхтэй байдлыг шаарддаг бөгөөд хэрвээ талууд уг ажиллагаанд идэвх санаачилгагүй, хайнга хандан уг ажиллагаа үр дүнд хүрэхээргүй байвал дуусгавар болно.

- Талууд эвлэрүүлэн зуучлалыг дуусгавар болгох хүсэлт гаргасан.,

Уг ажиллагаа нь талуудын хүсэлтээр хийгддэгээрээ онцлогтой бөгөөд тиймээс талууд хүсэлт гаргах нь дуусгавар болгох үндэслэл болдог.

- Эвлэрүүлэн зуучлалын хугацаа дууссан, цаашид сунгагдах боломжгүй болсон.,

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг нэг удаа сунгаж болдог. Гэхдээ иргэний хэрэг үүсгэснээс хойш явагдах эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг шүүгч тогтооно.

- Эвлэрүүлэн зуучлагчийг талууд татгалзсанаар уг ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талууд дангаар, эсхүл харилцан тохиролцсоноор эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргаж болдог. Гэхдээ шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргасан тохиолдолд энэ талаар шүүхэд мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Дээрх байдлаар хөдөлмөрийн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх нь шүүхийн ачааллыг бууруулах, маргаанд оролцогч талуудын цаг зав, хөрөнгө мөнгийг хэмнэх хамгийн гол нь хэн аль нь сэтгэл ханамжтай үлдэх онцлогтой бөгөөд давуу талтай юм.

---o0o---

ГЭР БҮЛИЙН МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
бодлогын судлаач С.Батбаяр

НЭГ. ОРШИЛ

Орчин үед иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний болон гэр бүлийн эрх зүйн маргаантай талуудыг шүүхийн журмаар эвлэрүүлэх ажиллагааг улам бүр боловсронгуй болгосноор нь шүүхээр заавал шийдвэрлэх шаардлагагүй, эрх зүйн гэхээс илүү харилцааны шинжтэй маргаантай хэргийг шүүх хянан шийдвэрлэхгүй байх, шүүн таслах ажиллагааны ачааллыг багасгах боломжийг бүрдүүлж, улмаар шүүхийн зардал, ажиллагаа хэмнэгдэх ач холбогдолтойгоос гадна маргалдагч талуудыг цаг зав алдах, хөрөнгийн илүү зардал гаргах, сэтгэл зүйн хувьд хохирох зэрэг хор уршгаас урьдчилан сэргийлэх үндэс бий болно. Нөгөө талаар аливаа маргааныг хүчээр, албадлагаар шийдвэрлэх нь уг маргааныг дуусгавар болгохоос илүү далд байдалд оруулдаг төдийгүй, эцэс төгсгөлгүй үргэлжлэх муу талтай байдаг нь судалгаагаар тогтоогдсон тул талуудыг аль болох эвлэрүүлэх ажиллагаа хийх нь шүүгчийн эн тэргүүний үүрэг байх учиртай¹.

¹ Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж 2010 оны 06 дугаар сарын 02-ны өдөр №2, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь зохигчдыг эвлэрүүлэх шүүгчийн ажиллагааны тухай"

Монгол Улсад шүүхээр шийдвэрлэгдэж буй иргэний хэргийн тоо жил ирэх бүр байнгын өсөлттэй гарч байна. Тухайлбал 2012 онд нийт 27792 иргэний хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2013 оны байдлаар 35314 иргэний хэрэг буюу нийт өмнөх оныхтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дээрх нийт иргэний хэрэг дотроос гэр бүлийн эрх зүйн маргаан 2012 онд 3878 байсан бол 2013 онд 4276 буюу 10.2 хувиар өссөн байна. Үүнээс гэр бүлийн эрх зүйн маргаан гэхээр гэрлэлт цуцлалт, гэр бүлийн гишүүдийн дундын өмчийн маргаан, эцэг эх тогтоолгох, тэжээн тэтгэх зэрэг маш олон төрлийн маргаан хамаарах боловч хамгийн эмзэг асуудал нь гэрлэлт цуцлалт юм. Дээр дурдсан 2013 оны статистик мэдээнээс үзэхэд гэр бүлийн эрх зүйн 4276 хэргээс 3382 буюу 79 хувь гэрлэлт цуцлуулах тухай маргаан эзэлж байна¹.

2003 онд Монгол Улсын Их хурлын тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого"²-ын 1 дүгээр зүйлд "Гэр бүл нь хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн" гэж заасан. Иймд гэр бүл гэдэг бол Монгол Улсын нийгмийн хөгжлийн гол цөм боловч дээр дурдсан тоо баримтаас харахад гэрлэлт цуцлалтын хувь өндөр байгаа нь тэр хэмжээгээр нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихтэй юм. Дээр дурдсан тоо баримт нь зөвхөн 2013 онд

¹ Шүүхийн ерөнхий зөвлөл "Монгол Улсын Шүүхийн тайлан (2013)", 2013 он. 95-97 дахь тал.

² Монгол Улсын Их Хурлын тогтоол 2003 оны 05 дугаар сарын 15-ны өдөр №16, "Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай"

шүүхээр шийдвэрлэгдсэн гэрлэлт цуцлалт бол үүнээс гадна захиргааны журмаар 1224 гэрлэлт цуцлалт бүртгэгдсэнээс үзвэл төрийн зүгээс гэр бүлийн талаар оновчтой бодлого хэрэгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх уян хатан тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай болсны тод илрэл юм. Иймд энэ өгүүлэлд гэр бүлийн эрх зүйн маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх ажиллагаа буюу эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх онцлог, эрх зүйн зохицуулалтын талаар өгүүлэх болно.

ХОЁР. ГЭР БҮЛИЙН МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Олон улсад шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх ажиллагаанд ADR буюу Alternative Dispute Resolution гэх нэршлийг хэрэглэдэг бөгөөд энэ нь шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн утгыг илэрхийлдэг байна. Дэлхийн хөгжиж буй орнуудад сүүлийн жилүүдэд шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд аливаа хэрэг, маргааныг дан ганц шүүхээр бус бусад уян хатан хийгээд зардал багатай аргаар шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн хандлага хүчтэй дэлгэрч энэ талаарх хууль тогтоомж боловсронгуй болон хөгжиж байна.¹

Манай улсын хувьд ч шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Их хурлаас батлан гаргасан шүүхийн багц хуулийн нэг нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль юм. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль² нь 2012 онд батлагдаж 2013 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна. Энэхүү хуулиар эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зохицуулах ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, улмаар тухайн ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах ба иргэний эрх

зүйн болон хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, гэр бүлийн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэхээр заасны дотор гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэх болсон нь тухайн харилцааны онцлог буюу төрөөс гэр бүлийг дэмжих, хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд анхаарч байгаагийн илрэл болно¹.

Нөгөө талаараа гэрлэлт цуцлалтын хэргийг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх нь гэр бүл доторх маргааныг олон нийтэд дэлгэх шаардлагагүй болж, гэрлэгчдийг харилцан ярилцаж тохиролцоонд хүргэх, аль алиных нь сэтгэлд нийцэх шийдвэр гарган, гэрлэлт цуцлалтаас болж хамгийн их хохирдог хүүхдийн эрх, тэдний нийгмийн хамгааллын асуудлыг бодлогын түвшинд илүү уян хатан байдлаар зохицуулах боломжийг бий болгосон.

2.1. Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт

Дээр дурдсанчлан 2012 онд батлагдсан “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-иар иргэний эрх зүйн, хөдөлмөрийн ганцаарчилсан, гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх боломжийг олгосон. Гэвч энэ нь өмнөх хуулиудад огт эвлэрлийн ажиллагаа явуулдаггүй, бүх гэр бүлийн эрх зүйн маргааныг шүүх шууд хянан шийдвэрлэдэг байсан гэвэл өрөөсгөл ойлголт юм. Өөрөөр хэлбэл 2002 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд² “гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж тусгайлан бүлэг болгон хуульчилсан байдаг. Уг хуулийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн

⁵⁷ 山本和彦、山田文(2008年)「ADR中裁判」日本評論者、6項

⁵⁸ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2012 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

⁵⁹ Монгол Улсын Дээд шүүх “Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар /тойм/” 2013.

⁶⁰ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна” гэж заасан. Иймд гэр бүл нь аливаа үндэсний хөгжил, дэвшлийн эх үндэс, суурь нь болдгийн хувьд гэр бүлийн бат бэх байдалд анхаарал хандуулах шаардлагын үүднээс шүүгч бүр гэрлэлт цуцлах асуудалд туйлын анхааралтай хандаж, яаруу дутуу шийдвэрээр гэр бүлийн хувь заяаг дүгнэхгүй байх нь чухал гэдгийг илэрхийлж буй юм.

2010 онд Монгол Улсын Дээд шүүхээс гаргасан №2 зөвлөмжийн 2.1 дэх хэсгээс үзвэл “гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хүлээн авсан шүүх гэрлэгчдэд эвлэрэх хугацаа өгөхгүйгээр шууд гэрлэлтийг цуцалсан хэргийн тоо нийт гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлтэй хэргийн 90-91 хувийг эзэлж байгаа нь шүүхийн статистик судалгаагаар тогтоогдсон байна” хэмээжээ. Мөн үүнийг дүгнэхдээ шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх талаар ямар нэг ажиллагаа хийхгүйгээр шууд гэрлэлтийг цуцалж байгаа нь шүүхийн ажлын ачаалал болон эвлэрүүлэх ажиллагааг зохицуулсан тодорхой журам Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдаагүйтэй холбоотой гэсэн байна.

Дээр дурдсан тоо баримтаас үзэхэд манай улсын хувьд шүүхэд нэхэмжлэл гаргасан гэр бүлийн эрх зүйн маргааны дийлэнх хувийг гэрлэлт цуцлах маргаан эзэлж, эцэстээ шүүхээр гэрлэлтээ цуцлуулснаар маргаан эцэслэдэг болох нь харагдаж байна. Энэ нь улсын хөгжлийн суурь болж буй гэр бүлийн тогтворгүй байдлыг бий болгох, гэр бүлийн талаар төрөөс баримталж буй бодлоготой нийцэхгүй байсан тодорхой юм. Иймд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар хэрэг маргааныг аль болох эвлэрлийн журмаар шийдвэрлэх, тэр дундаа гэр бүлийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэдэг байх бодлогыг тусгасан.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.3-т заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулахаас татгалзах үндэслэл болохгүй”, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 13-т зааснаас бусад тохиолдолд гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ” гэж заасан нь гэр бүлийн холбогдолтой маргааныг шүүх хүлээн авахаас өмнө заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан байх нөхцөлийг бүрдүүлэхийг зорьсон байна. Гэхдээ ИХХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4-т заасан гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэх мэт нөхцөл бий болсон тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах шаардлагагүй юм.

Мөн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд сэтгэл зүйч болон төрөл, садан, найз нөхөд, хамтран ажиллагсдыг оролцуулж¹ болохоор заасан нь гэр бүлийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэх боломжит бүх арга хэмжээг авах агуулгыг илэрхийлж буй бөгөөд энэхүү хуулийн үндсэн зорилгыг ойлгож маргаанд оролцогч эвлэрүүлэн зуучлагч дээрх боломжуудыг бүрэн дүүрэн ашиглах тал дээр идэвхтэй ажиллах ёстой.

¹ “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль” 32 дугаар зүйл 32.4 дэх хэсэг.

2.2. Гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлагч оролцох нь

Гэрлэгчид ялихгүй шалтгаанаар үл ойлголцох байдалд орох, эцэг, эх, ах, дүүсийн таарамжгүй харьцаанаас тус тусдаа амьдарч байгаа хүмүүсийг аль болох эвлэрүүлэх нь зөвхөн шүүхийн үүрэг биш бөгөөд ингэх ч боломжгүй юм. Учир нь өнөөгийн манай улс дахь шүүхийн ажлын ачаалал, нэг шүүгчийн шийдвэрлэж буй хэргийн тоо зэргээс хамааран гэр бүлийн эрх зүйн холбоотой маргаан, тэр дундаа гэрлэлт цуцлахтай холбогдсон маргаанд шүүгч онцгой анхаарал хандуулан ажиллахад хүндрэлтэй. Энэ нь ч дээр дурдсан шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаа хийхгүйгээр шууд гэрлэлт цуцалж байгаа тоо хэмжээнээс тодорхой харагдана. Иймд гэрлэлт цуцлахтай холбоотой маргааныг эхний ээлжид шүүхийн бус журмаар эвлэрүүлэх ажиллагаа хийх нь илүү ач холбогдолтой¹.

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд хандахдаа гол төлөв сэтгэлийн хөөрлөөр хандах явдал байдаг. Иймд нийгмийн баялгийн үндэс суурь болсон гэр бүлийг хамгаалах зорилгоор гэр бүлийн эрх зүйн маргаанд мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч, шүүгчийн тусалцаатайгаар тэдгээрийг эвлэрүүлэхэд гол ач холбогдол нь байгааг эвлэрүүлэн зуучлагч сайтар ойлгож, бэлтгэгдсэн байх ёстой. Тиймээс эвлэрүүлэн зуучлагч юун түрүүнд харилцааны өндөр чадвартай байх шаардлагатай ба гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүйн байдалд анализ хийн, амьдралын туршлагадаа үндэслэн эвлэрэх явцыг дэмжих оролцоо маш чухал².

Иймд зөвхөн гэр бүлийн эрх зүйн маргаан бус бусад төрлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлагчаар оролцох эвлэрүүлэн зуучлагч нь дараах нийтлэг чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай.

- Тухайн хэрэг маргааны нөхцөл байдалд тал бүрийн, бодит дүгнэлт өгөх чадвартай байх;
- Харилцааны ур чадвартай байх;
- Ярих чадвар сайтай байх;
- Удирдах чадвартай байх;
- Маргалдагч талуудын яриаг сайтар сонсох чадвартай байх ёстой.

Эвлэрүүлэн зуучлагч дээрх чадваруудыг эзэмшсэний үндсэн дээр маргааны онцлогт тохируулан чадвараа ашиглах нь зохистой. Гэрлэлт цуцлах маргаанд талууд сэтгэл зүйн хувьд их эмзэг бөгөөд тогтворгүй байдаг тул өөрийгөө хөндлөнгийн байр сууринаас үнэлэх, асуудалд бодит дүн шинжилгээ өгөх нь хүндрэлтэй болсон байдаг. Ийм нөхцөл байдлыг эвлэрүүлэн зуучлагч бүрэн ойлгосны үндсэн дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулна.¹

2.3. Эвлэрүүлэн зуучлалын үр дагавар ба эвлэрлийн гэрээ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт "Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд талууд эвлэрсэн бол шүүх Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу эвлэрлийн гэрээг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно", ИХХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.6 дахь хэсэгт "Зохигчид эвлэрсэн тохиолдолд эвлэрлийн гэрээ байгуулж болно", 74 дугаар зүйлийн 74.2 дахь хэсэгт зааснаар эвлэрлийн гэрээг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамж гарна. Хэрэв талууд

⁶² Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж 2010 оны 06 дугаар сарын 02-ны өдөр №2, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь зохигчдыг эвлэрүүлэх шүүгчийн ажиллагааны тухай"

⁶¹ "Эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан гарын авлага", Б.Оюу "Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах нь" 2014 он, 158 дахь тал.

⁶⁴ "Эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан гарын авлага", Б.Оюу "Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах нь" 2014 он, 161 дэх тал.

шүүгчийн захирамжийг сайн дураар биелүүлэхгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэнэ. Гэхдээ энэ нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээнд хамаарна. Харин гэр бүлийн эрх зүйн холбогдолтой хэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрсэн бол тухайн шүүхийн шүүгч ИХШХШТХ-ийн 130 дугаар зүйлийн 130.2.1 дэх хэсэгт заасан журмын дагуу эвлэрлийн гэрээг баталгаажуулна. Хэрэв тухайн хэрэгт иргэний хэрэг үүсгэсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Харин эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулагдсан эвлэрлийн гэрээг шүүгч баталгаажуулахаас татгалзвал эвлэрүүлэн зуучлагч шүүгчийн татгалзсан үндэслэл, шалтгааныг харгалзан дахин эвлэрүүлэн зуучлалыг явуулах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллагааг үргэлжлүүлэн явуулна. Иймд эвлэрүүлэн зуучлагч талуудын тохиролцооны агуулгыг тусгасан, хуульд нийдсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй эвлэрлийн гэрээний төслийг боловсруулах ёстой.

Харин талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцоогүй, эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон, ажиллагааг дуусгавар болгох хүсэлт гаргасан, хугацаа дуусаж цаашид сунгагдахгүй болсон зэрэг нөхцөлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болно. Ингэж эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон тохиолдолд талуудад ИХШХШТХ-д заасны дагуу шүүхэд хандах эрх нь нээлттэй юм.

3. ДҮГНЭЛТ

Дээр дурдсанаар манай улсад шийдэгдэж буй хэргийн тоо, шүүхийн ачаалал зэргээс үзэхэд эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатайг харуулсан билээ. Гэхдээ эвлэрүүлэн зуучлал нь зөвхөн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад давуу талтай бус өнөөгийн нийгэмд тулгамдаад байгаа олон асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх зохистой арга юм. Үүний нэг нь гэр бүлийн эрх зүйн маргаан бөгөөд тэр дундаа гэрлэлт цуцлах маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн оролцоо туйлын чухал юм.

2012 онд батлагдсан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн нэг зорилго ч гэсэн үүнд чиглэж байгаа нь эргэлзээгүй юм. Иймд эвлэрүүлэн зуучлагч гэр бүлийн эрх зүйн маргаанд сайтар бэлтгэгдсэн, хуулийн үндсэн мөн зорилгыг ойлгож ажиллах нь хамгаас чухал. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлалын ач холбогдол, шүүхэд хандсанаас илүү иргэдэд давуу талтай гэдгийг олон нийтэд ойлгуулах, танин мэдүүлэх нь цаашид энэхүү ажиллагаа амжилттай хэрэгжих чухал нөхцөл болно.

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГ МОНГОЛ УЛСАД ХӨГЖҮҮЛЭХЭД ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ: ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЧИГ ХАНДЛАГА



*Монгол улсын Дээд шүүхийн шүүгч,
Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн
дарга Д.Тунгалаг*

1. Эвлэрүүлэн зуучлалын ойлголт, үүсэл хөгжил

Япон Улсын Засгийн Газрын харьяа Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /ЖАЙКА/-ээс Монгол Улсын хууль, эрх зүйн орчинг дэмжих Техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд ЖАЙКА болон Монгол Улсын Дээд шүүхтэй хамтран 2009 оны 6 дугаар сараас “Эвлэрүүлэн зуучлагч тогтолцоог сайжруулах” төслийг 2 шаттайгаар хэрэгжүүлэх явцад сонгосон загвар шүүхийн үйл ажиллагааны туршлагад тулгуурлан иргэний болон гэр бүлийн хэрэг маргаан эвлэрүүлэн зуучлах тогтолцоог бий болгосон ба Япон улс дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны түүхэн хөгжил, үйл ажиллагааны талаарх мэдлэгийг өмнөх сургалт, гарын авлага зэрэгт тодорхой тусгасан тул энэхүү нийтлэлд АНУ болон Европын холбооны улсуудын эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны түүх, хөгжил, эвлэрүүлэн

зуучлах ажиллагааны зарчмын талаар авч үзэхийг зорилоо.

Маргааныг шийдвэрлэж ирсэн түүх нь хүч хэрэглэх, /эрх зүйн эсрэг/ шүүхийн, /зөрчигдсөн эрхийг шүүхийн журмаар албадан сэргээх/ эвлэрүүлэх гэсэн гурван үндсэн хэлбэрүүд харилцан шилжиж ирсэн түүх юм”⁶⁵

Америкийн эрх зүйн номлолоор боловслогдсон “Alternative Dispute Resolution” /ADR/ нэр томъёо орчин үед дэлхийн улс орнуудын хууль тогтоогч, хэрэглэгч нарын анхаарлыг ихээхэн татаж байна. Эвлэрлийн энэ журам нь хэрэг маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх хамгийн үр нөлөөтэй нэг сонголт, хувилбар болон хөгжих үндэс суурийг тавьсан юм.

ADR-ийн төрөлд: хараат бус шинжээч, /expert determination/ арбитр - зуучлагч, /arb-med/ зуучлагч - арбитр, /med-arb/ мини-шүүх, /mini-trial/ эвлэрүүлэн зуучлал, /медиаци/ тусгай шүүх, (private judging) хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, олон хаалгатай шүүх /multi-door courthouse/; омбудсмен⁶⁶, шүүхийн бага хурал, /settlement conference/ эвлэрүүлэх ажиллагаа /conciliation/ болон бусад институциуд хамаарч байна.

ADR-ийн энэ олон төрлийг арбитр;⁶⁷ эвлэрэл, шүүх гэсэн гурван үндсэн хэлбэрт хувааж болох юмаа. Иймд ADR гэсэн ойлголт нь өөртөө арбитр, мөн

⁶⁵ Давыденко Д.А. Из истории примирительных процедур в Западной Европе и США // Вестник Высшего Арбитражного Суда Российской Федерации. - М.: ЮРИТ-Вестник, 2004, № 1. - С. 163

⁶⁶ Омбудсмен нь нийгэмд иргэн болон засгийн хооронд нэг ёсны арбитр болон үйлчилдэг учраас хараат бус алагчлахгүйгээр ажиллаж болно.

⁶⁷ Термин “арбитр” гэсэн нэр томъёо нь (1) маргааныг хянан шийдвэрлэхээр байгуулагдсан байгууллага буюу шүүх, (2) маргааныг шийдвэрлэх процесс гэх зэргээр хэд хэдэн агуулгаар хэрэглэгдэнэ.

шүүхийн журмаар эрх зүйн маргааныг шийдвэрлэх журам төдийгүй, талуудын хооронд үүссэн маргааныг өөрсдөө болон эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулан зохицуулах эвлэрлийн журмыг өөртөө агуулна. "Alternative Dispute Resolution" гэсэн нэр томъёог монгол хэлэнд үгчлэн орчуулахад "маргааныг шийдвэрлэх өөр арга буюу хувилбар" гэж орчуулж болох боловч энэ ойлголт нь агуулгын хувьд хэрэг маргааныг шийдвэрлэхээс гадна мөн зохицуулах, өөрөөр хэлбэл эвлэрлийн журмыг өөртөө багтааж байгаа юм. Ийм учраас манай улсад маргааныг төрийн /шүүхийн/ бус аргаар шийдвэрлэх, зохицуулах журам гэсэн утгаар ойлгож болохоор байна. Гэхдээ энэ ойлголт нь олон тохиолдолд шүүх бус процессын нэг хувилбар хэдий ч, зарим тохиолдолд шүүх эрх мэдлийн хяналтад байж, шүүн таслах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдчилсан нөхцөл болдог онцлогийг бас харгалзах хэрэгтэй юм.

Хэрэг маргааныг шийдвэрлэх энэ хувилбар нь шүүхэд хандахгүйгээр талуудын хооронд үүссэн маргаан буюу бусад тодорхойгүй нөхцөл байдлыг арилгах, зохицуулах зорилго бүхий олон журмыг өөртөө агуулна.

Гадаадын улс орнуудад хэрэг хянан шийдвэрлэх энэ ажиллагааны нэр хүнд өдрөөс өдөрт өсөж, зарим тохиолдолд бүр шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх нэг "сонголтын хувилбар"-ын хувьд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрсэн байна.

Эвлэрлийг шийдвэрлэх үндсэн арга хэрэгсэл бол эвлэрүүлэн зуучлал юм. "Медаци" гэсэн ойлголт нь латин хэлний "mediare"-зуучлах гэсэн үгнээс гаралтай бөгөөд энэ нь хараат бус, бие даасан зуучлагчаас маргалдагч талуудын хооронд шууд хэлэлцээр хийлгэх замаар тэдний асуудлыг шийдвэрлэж байгаа процесс мөн.

Энэ нь янз бүрийн ашиг сонирхлыг авч үзсэний үндсэн дээр, түүнийг ойлгож, хэлэлцэж, асуудлыг томъёолох, дараа нь маргалдагч талуудын хүлээн авахуйц шийдвэрийг хайх боломж мөн.

Өнгөрсөн зууны 90-ээд оны эхэн үед барууны шүүгч нар хэрэгт дарагдаж, талуудын хувьд өмгөөлөгчдийн үйлчилгээ дэндүү үнэтэй тусах болсон цаг үед медиаци буюу эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх болжээ. Эвлэрүүлэн зуучлал нь эхлээд АНУ, Их Британи, Австри, Герман улсад XX зууны дунд үеэс хөгжлийн түүхээ эхэлсэн гэж үздэг байна. Өнөөдөр хөгжингүй улс орнуудад эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар хэрэг маргааны ихэнх хувь нь энэ аргаар шийдвэрлэгдэж байна. Хэрэг маргааныг шийдвэрлэх энэ арга зам нь шүүхийн байгууллага болон иргэдийн талархлыг хүлээж, хууль тогтоомжийн хүрээнд зарим төрлийн маргаануудыг зуучлалын журмаар заавал шийдвэрлэх болсон байна.

АНУ, Австрали, Канад, Аргентин зэрэг улсад мөн эвлэрүүлэн зуучлалыг шүүхээс өмнөх ажиллагааны зайлшгүй нэг шат болгон ашиглаж байна. Эдгээр улс орнуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг учраас зарим хэргүүдийг энэ процессыг дамжин өнгөрөөгүй бол шүүхээр авч хэлэлцдэггүй журам тогтжээ. Өнөөдөр зуучлалыг Баруун Европт ихээхэн дэмжиж байна. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцэд сөргөлдөөнийг өөр бусад аргаар шийдвэрлэх оролдлого үр дүнгүй болсны дараа аливаа хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхээр хүлээн авч байх тухай асуудлыг хөнджээ⁶⁸.

Зуучлагч нь хуульд зааснаас бусад тохиолдолд сөргөлдөөнийг шийдвэрлэх явцад мэдэж авсан мэдээ, мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ. Маргааны

⁶⁸ Ч.Нямсүрэн. Виктимологи. УБ 2005 он

албан ёсны бус шийдэл нь туйлын нууц байдлыг хангах боломж олгоно. Зуучлалын журам нь болсон үйл явдлыг тайлбарлахад биш, харин сөргөлдөгч талуудыг зуучийн зүгээс зөөлрүүлж байгаа хэлэлцээрүүд буюу харилцан зөвшилцлийн эрэл хайгуул хийхэд чиглэнэ⁶⁹. Зуучлагч нь талуудын ашиг сонирхлын мөн чанарыг аль болох ихээр нээхийн хамт тэдний шаардлага, арга хэмжээ, санал хүсэлтийн бодит байдлыг тодорхойлоход байгаа юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д: “эвлэрүүлэн зуучлал” гэж талуудын хооронд үүссэн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэхэд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дэмжлэг үзүүлэх эвлэрүүлэн зуучлагчийн ажиллагааг” ойлгоно гэжээ. Манай улсад хэрэгжүүлж буй эвлэрүүлэн зуучлалын зорилго нь талууд өөрсдийн ашиг сонирхолд нийцэхүйц шийдлийг олоход нь зуучлагч дэмжлэг үзүүлж, тэдгээрийн хоорондын харилцааны зөрчил, маргааныг эвийн журмаар, шуурхай, зардал багатай зохицуулахад оршино.

Гэтэл гадаадын улс орнуудын хууль тогтоомжид мөн адил тодорхойлолтыг өгсөн байна. АНУ-ын Зуучлалын тухай 2001 оны загвар хуулийн 2 дугаар зүйлийн 1-д зааснаар “зуучлал нь сайн дурын үндсэн дээр үүссэн маргааныг зохицуулахад туслах зорилгоор талуудын хооронд хэлцэл хийх, харилцахад тусалж байгаа зуучлагч оролцсон процесс”⁷⁰ гэж тодорхойлжээ.

Австри улсын Иргэний хэрэг дэх зуучлалын тухай Холбооны хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д “Зуучлал нь талуудаас тогтоосон харилцах аргуудын ашиглан, мэргэшлийн хувьд бэлтгэгдсэн, төвийг сахисан, зуучлагчийн оролцоотойгоор хэрэгжих талуудын сайн дурын журам”

⁶⁹ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. Уб., 2005. 417 дахь тал

⁷⁰ АНУ-ын Зуучлалын тухай загвар хуулийн 2.1., 2001 он

гэж заажээ.

Итали Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны зургадугаар сарын 18-ны өдрийн Иргэний болон худалдааны маргааны талаар эвлэрүүлэхэд чиглэсэн эвлэрүүлэн зуучлалын хүрээнд № 69 хуулийн 60 дугаар зүйлийг үйлчлүүлж эхлүүлэх тухай 2010 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн хууль тогтоох декретийн 1 дүгээр зүйлийн а-д зааснаар зуучлал нь хоёр буюу түүнээс дээш субъектэд маргааныг шийдвэрлэх талаар нөхөрсөг зөвшилцлийг эрж хайх, мөн тэдний зөвшөөрлөөр санал боловсруулахад нь туслахад чиглэсэн хараат бус гуравдагч этгээдээс хэрэгжүүлж байгаа зуучлах үйл ажиллагаа” гэжээ⁷¹.

Зуучлал нь иргэний хэрэг маргаан төдийгүй, мөн эрүү, захиргааны хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах төрлөөр хөгжиж байна.

Жишээ нь, Австри улсын Иргэний хэрэг дэх зуучлалын тухай Холбооны хуулийн 1 дүгээр зүйлийн 2-д зааснаар “иргэний хэргийн талаарх зуучлал гэдэг нь иргэний ердийн шүүхийн харьяаллын хэрэг, тэдгээрийн шийдвэр, сөргөлдөөнийг шийдвэрлэхэд зуучлах” гэжээ.

Гадаад улс орнуудад захиргааны хэргийн талаарх эвлэрүүлэн зуучлал, ялангуяа татварын хэрэг маргааны хүрээнд дэх эвлэрүүлэн зуучлал нь Голланд, Герман, Австри улсад үр дүнтэй хэрэгжиж байна. Энэ төрлийн хэрэг маргааныг зохицуулсны үр дүнд эвлэрүүлэн зуучилсан хэргийн 80 орчим хувь нь харилцан хүлээн зөвшөөрөхүйц шийдэлд хүрч чадсан байна. Голланд улсад 2012 онд эвлэрүүлэн зуучлалд хэрхэн хандаж байгаа талаар санал асуулга явуулахад зуучлалын хэлцэлд оролцсон иргэдийн 90 хувь, татварын байцаагчдын 67 хувь нь цаашид шүүхэд хандахгүйгээр энэ журмаар маргаанаа шийдвэрлүүлэх боломжтой гэж үзсэн байна.

⁷¹ Италия. Законодательный декрет от 4 марта 2010. № 28

2002 онд ЮНСИТРАЛ Олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлалын журмын тухай загвар хуулийг гадаадын олон улс орны зөвшилцөх журмыг хэрэглэж ирсэн түүхэн туршлагыг нэгтгэн баталсан.

Үүнээс үзэхэд эвлэрүүлэн зуучлал гэж юу вэ гэдэгт улс орнуудын хууль тогтоогчид нэгдсэн нэг байр суурьт хүрч чадсан байна. Энэ нь:

Нэгдүгээрт, АНУ-ын нэвтрүүлсэн энэ шинэ институци нь шүүхийн ачааллыг хөнгөвчлөх, иргэдийн хооронд үүссэн маргааныг эвлэрлийн журмаар шийдвэрлэх замаар нийгмийн зөвшилцлийг хангахад чухал ач холбогдолтой болсон төдийгүй, америкийн "Alternative Dispute Resolution" /ADR/ институци нь аль ч улс орнуудын эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн зохицуулалт, практик, хөтөлбөрийн үндэс суурь болсон;

Хоёрдугаарт, НҮБ болон олон улсын эрх зүйн бусад баримт бичигт эвлэрлийн институцийг дэмжиж, нийт улс оронд нэвтрүүлэхийг санал болгосон;

Гуравдугаарт, ихэнх улс орнууд америкийн эвлэрүүлэн зуучлах номлол, практикийг өөрийн орны онцлогт тохируулан янз бүрийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн;

Дөрөвдүгээрт, эвлэрүүлэн зуучлал нь зөвхөн иргэний, худалдааны төдийгүй, мөн эрүү, захиргааны салбарт үр дүнгээ өгч эхэлсэн болон эвлэрүүлэн зуучлалын ойлголт, нэр томъёо, сургалт нь улс орнуудын үндэсний хууль тогтоомжид ижил тогтолцоогоор нэвтэрсэн болон бусад хүчин зүйлээр тодорхойлогдож байна.

2. Гадаад улс орнуудын эвлэрүүлэн зуучлагчдын төв байгууллага, тэдгээрийн онцлог

Гадаадын улс орнуудад эвлэрүүлэн зуучлагчдын дээд байгууллагын хэлбэр, зохион байгуулалт өөр хоорондоо

ялгаатай боловч, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг боловсронгуй болгох, эвлэрүүлэн зуучлагчдыг сургах, сонгон шалгаруулах, дадлагажуулах, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих талаар адил төстэй байна. Жишээ нь 1983 онд АНУ-д зуучлалын шинэ арга зүй, хэлцэл хийхэд сургах хөтөлбөр боловсруулах зорилтыг шийдвэрлэхийн тулд Маргаан шийдвэрлэх Үндэсний институтыг байгуулжээ. Өнөө үед тухайн улсад хувийн болон төрийн зуучлалын алба үйл ажиллагаа явуулж байна. Мөн шүүхээс өмнөх шатанд маргааныг зохицуулах олон арван тусгай компани үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ тусгай шүүгч-зуучлагчид бий болжээ. АНУ-ын олон компани, хууль зүйн фирмүүд маргааныг зохицуулах янз бүрийн аргуудыг туршиж, урд өмнө мэдэхгүй байсан зарим аргыг ажил хэрэгтээ нэвтрүүлж байна. Арбитр нилээд нэр хүндтэй боловч, шүүхийн тогтолцоонд байдаг зардал ихтэй, удаан, маргалдагч талуудын ашиг сонирхолд тэр бүр нийцээд байдаггүй маргааныг шийдвэрлэх нөхцөл байдал хязгаарлагдмал гэх зэрэг олон дутагдалтайг харгалзан мини-шүүх, хараат бус шинжээчийн дүгнэлт, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлж байна. Мөн энэ улсад Америкийн арбитрын ассоциаци /American Arbitration Association/ ихээхэн нөлөөтэй бөгөөд энэ байгууллага нь өөрийн гэсэн аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхийн тулд Хөндлөнгийн шүүхийн /арбитрын/ болон зуучлалын дүрмийг батлан хэрэгжүүлж байна. Мөн Америкийн хуульчдын холбооны /American Bar Association/ маргааныг шийдвэрлэх байгууллага болох салбарууд нь /секц/ өөртөө 13 мянга орчим практикийн хуульчдыг эгнээндээ нэгтгэсэн байна.

Австрали улсад 1975 онд Австралийн арбитрч болон зуучлагчдын холбоо байгуулж, шүүхээс гадуур зуучлалыг зохицуулахын тулд 1991 онд Арбитр болон зуучлалын тухай бие даасан хуулийг батлан гаргасан.

Их Британи улс 1999 онд Иргэний процессын хуулийг /Civil Procedure Rules/ шинэчлэн баталснаар Европтивд эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэхэд тэргүүлэх үүргийг гүйцэтгэх болсон. Хэрэв процессын аль нэг тал нь шүүхээс санал болгосон эвлэрүүлэн зуучлах журмыг хүлээн авахаас татгалзсан бол тэр тал нь ялсан байсан ч шүүхийн бүх зардлыг хариуцна. Төрийн дэмжлэгээр “Зуучлалын халуун шугам” гэсэн тусгай албыг байгуулж, энэ алба нь туслахыг хүсэж хандсан иргэнд маргааныг шийдвэрлэх хамгийн тохиромжтой журмыг сонгож, талуудын хүсэлтээр мэргэжилтэн-зуучлагчийг сонгоход нь тусална. Гэр бүлийн маргааны зуучлах бүх зардлыг төр даана. Зуучлалын хөдөлгөөн, зуучлагчдыг бэлтгэх ажлыг Их Британид хэд хэдэн байгууллага эрхлэх боловч, эдгээрийн дунд “Маргааныг үр нөлөөтэй шийдвэрлэх Британы төв” /CEDR/, Арбитр болон зуучлалын Төв /JAMS/ тэргүүлэх үүрэгтэй байдаг байна.

Австри улсад эвлэрүүлэн зуучлал богино хугацаанд амжилттай хөгжиж байгаа бөгөөд зуучлалын дэд бүтцийн хөгжингүй сүлжээний тусламжтайгаар талуудаас маргааныг шийдвэрлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлээд байна. 2004 онд Иргэний хэрэг дэх эвлэрүүлэн зуучлалын тухай Холбооны хуулийг батлан гаргасан. Австри нь мэргэжлийн жагсаалтад “зуучлагч” /медиатор/ гэсэн мэргэжлийг албан ёсоор бүртгэсэн цөөн орны нэг юм. Австри улсын Иргэний хэрэг дэх зуучлалын тухай Холбооны хуулийн “Холбооны хууль зүйн яамны дэргэдэх зуучлалын талаарх Зөвлөх /консультатив/ зөвлөл” гэсэн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 1-д зуучлалын асуудлаар хууль зүйн сайдын зөвлөлдөх болон мэдээллийн чиг үүргийг хангахын тулд Зөвлөх зөвлөлийг байгуулан ажиллана” гэж заажээ. Зөвлөлийн гишүүд, тэдгээрийн орлогчдыг холбооны хууль зүйн сайд 5 жилийн хугацаатайгаар нэг удаа улиран томилогдох эрхтэйгээр томилно. Хууль зүйн сайдын Зөвлөх зөвлөл нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Холбооны хууль зүйн яамнаас өөрт нь хамааруулсан асуудлыг хэлэлцэх, мөн зардлыг нөхөн төлөх тухай санал зөвлөмж боловсруулах;

2. Иргэний хэрэгт зуучлах эвлэрүүлэн зуучлалын талаар сургалтын байгууллага буюу дамжааг бүртгэх процесс (§ 24.1);

3. Холбооны хууль зүйн сайд Зуучлалын хорооны дарга гишүүдийн урамшууллын хэмжээг тодорхойлох, зуучлагчдаас мэргэжлийн сургалтын нарийвчилсан журмыг тодорхойлоход зөвлөх (§30);

4. Сургалтын байгууллага болон дамжааг бүртгэхэд оролцох;

5. Өөрийн тусгай комиссоор дамжуулан зуучлагчдын нэрсийн бүртгэл гаргахад оролцох зэрэг⁷² эрх үүрэгтэй оролцдог байна.

Зөвлөлдөх зөвлөлийн хуралдаан, Холбооны хууль зүйн сайд нь Зөвлөлийн хуралдааныг зарлана. Хуралдаанд Хууль зүйн яамны ажилтнууд оролцож болно. Зөвлөх зөвлөлийн хуралдааныг нээлттэй явуулна.

Хэрэв хуралдаанд зөвлөлийн гишүүдийн 50% нь хүрэлцэн ирсэн бол хуралдаан хүчин төгөлдөрт тооцогдоно. Зөвлөлийн дарга санал хураалтад оролцохгүй. Зөвлөлийн шийдвэр энгийн олонхоор хүчин төгөлдөр болно. Хэрэв санал тэнцсэн бол санал, хүсэлтийг хойшлуулна. Санал хураалтад цөөнх болсон бол Зөвлөлийн шийдвэрт тусгай саналаа бичгээр хавсаргаж болно.

Зөвлөлдөх зөвлөлийн гишүүнчлэл нь сайн дурын байна. Зөвлөлийн гишүүдийн зардлаа төлүүлэх, түүний дотор 1955 онд тогтоосон В журмын дагуу албан томилолтын гуравдугаар зэргийн хангамж эдэлнэ. Зөвлөл нь саналын эрхтэй гишүүдээс Зуучлалын комиссыг 5 жилийн хугацаатайгаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Зөвлөл нь мөн комиссын дарга,

⁷² Австри. Федеральный закон о медиации в гражданских делах // http://mediators.ru/rus/about_mediation/foreign_law///

түүний төлөөлөгчийг томилоно. Зуучлалын комиссын бүрэн эрхийн хугацаа шинэ комисс байгуулагдмагц дуусгавар болно. Комиссын дарга нь Хууль зүйн сайдын зөвшөөрлөөр хурлыг зарлан хуралдуулна.

Герман улсад эвлэрүүлэн зуучлалыг шүүхийн тогтолцооны салшгүй хэсэг гэж үздэг. Зуучлал нь шүүх, /шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэглэгдэх/, өмгөөлөгч, шинжээчийн гэх зэрэг чиглэлээр хөгжиж байна. Зуучлагчийн үүргийг өмгөөлөгч, эвлэрүүлэх албад, нотариат болон үйл ажиллагааны янз бүрийн шинжээчид гүйцэтгэж байна¹. Герман улсад шүүхээс гадуур зуучлалын зэрэгцээ шүүхийн зуучлал ихээхэн нэр хүндтэй байна. 2004 оноос шүүхийн зуучлал нь зарим муж улсын шүүхэд Германы хууль зүйн байгууллагын хяналтын дор хэрэгжүүлсэн загварын төслийн хэлбэрээр амжилттай хөгжиж байна. Энэ улсад эвлэрүүлэн зуучлал нь шүүх эрх мэдлийн тогтолцооны дагуу зохион байгуулагдсан байна. Жишээ нь зуучлагчид нь Германы шүүхийн дэргэд ажиллаж, шүүхийн ачааллыг илт багасгаж байна. Өнөөдөр зуучлал нь гэр бүлийн хэрэг маргааны хүрээнээс хальж, ерөнхий чиг үүрэг бүхий шүүх, захиргааны шүүхийн дэргэд ажиллаж байна. Герман улсын хууль зүйн ихэнх сургуулиудад зуучлалын эрх зүйн хичээл зааж эхэлснээр хууль зүйн факультет оюутан бүр зуучлалын эрхтэй төгсч байна.

Франц улсад зуучлал нь ихэвчлэн бизнесийн хүрээнд үйлчилж байна. Өмгөөлөгчдөөс бүрдсэн Зуучлагчдын холбоо амжилттай ажиллаж байна. Зуучлагчдын үүргийг өмгөөлөгч, нотариатч, бизнесменүүд эрхэлж байна.

Дээрх байдлуудаас үзэхэд Европын Холбоо эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар маргааныг шийдвэрлэх журмыг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг ижилтгэх ажиллагааг хайж байна.

¹ ФРГ. Медиация. Зарубежный опыт / URL: <http://dkvartal.ru/zastypnik/37802>

Европын Парламент 2008 онд иргэний болон худалдааны хэргийн зуучлалын зарим нэгэн чиг хандлагыг илэрхийлсэн 2008/52 Директив батлан гаргажээ. Энэ актаар ЕХ-ны гишүүн орнуудад 2011 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эвлэрүүлэн зуучлалын замаар маргааныг шийдвэрлэхдээ ЕХ-ны иргэдийг бага зардлаар, түргэн шуурхай шийдвэрлэх хялбаршуулсан шийдвэрлэх хууль, хэм хэмжээ, захиргааны журмыг боловсруулан хэрэгжүүлэхийг даалгасан байна.

ОХУ-д маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх хүрээнд хууль тогтоомжийг бүрдүүлэх, боловсронгуй болгоход ОХУ-ын Худалдаа аж үйлдвэрийн танхим /ХАҮТ/ чухал үүрэгтэй байна.

Голланд улсад 1995 онд батлагдаж, 2000 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Медиацийн журам /NMI/ нь зуучлагч, маргааны оролцогчид, шүүгч нарын стандартыг шинээр оруулсан байна. Энэ журам нь гурван үндсэн суурь зарчимд үндэслэнэ. Үүнд:

1. Эвлэрүүлэн зуучлал нь бүх талын сайн дурын зөвшилцөлд үндэслэгдэх;
2. Медиатор буюу эвлэрүүлэн зуучлагч нь хараат бус, алагчлахгүй байх;
3. Нууцлал болон арилжааны нууцыг эвлэрүүлэн зуучлалын үед, түүний дараа бүх оролцогчид хэлбэрэлтгүй сахин хамгаалах гэсэн зарчмуудад тулгуурлана гэжээ.

Нидерландын нэг онцлог нь шүүх бүр нэг болон хэд хэдэн эвлэрүүлэн зуучлагчийн асуудал эрхэлсэн зөвлөгчтэй байна.

Энэ албан хаагч нь эвлэрүүлэн зуучлагч, эвлэрүүлэн зуучлалд оролцож байгаа бүх этгээдийн хувьд мэдлэгийн үндсэн эх сурвалж болон ажиллана. Зөвлөгч нь явагдаж байгаа эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үйл явцад хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ. Ийм ч учраас

шүүгчээс эвлэрүүлэн зуучлагчид хэрэг шилжүүлэх тохиолдолд зуучлагч, мөн бусад зуучлагчидтай хамтран ажиллана. Зөвлөгч нь жилд хоёроос доошгүй удаа шүүхийн саналаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрэгжүүлж байгаа эвлэрүүлэн зуучлагч нартай уулзах үүрэгтэй. Энэ уулзалтын зорилго нь үйл ажиллагааг зохицуулах, тулгамдсан асуудлыг илрүүлж, шийдвэрлэхээс гадна мөн туршлага солилцоход чиглэнэ. Үүнээс дүгнэлт хийхэд эвлэрүүлэн зуучлагчийн талаарх зөвлөгч нь мэдээллээр хангах, талууд сонголт хийх боломж олгохын тулд тухайн шүүхэд эвлэрүүлэн зуучлагчдын нэрсийн жагсаалтыг гаргах, медиацийг явуулах талаар анхны уулзалтыг зохион байгуулах, эвлэрүүлэн зуучлалын явцад мониторинг хийх, санхүүгийн болон захиргааны албан ёсны баримт бичигт үзлэг шалгалт хийх эрх үүрэгтэй байна.

Нидерландын медиацийн институт /NMI/ нь эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар шийдвэрлэж байгаа маргаантай холбоотой олон асуудлыг шийдвэрлэнэ. Институтийг 1993 онд хэсэг эрдэмтэд, бизнес-өмгөөлөгчдийн санаачилгаар байгуулсан бөгөөд түүний үндсэн зорилго нь нийт иргэдэд эвлэрүүлэн зуучлалыг сурталчлах, дэмжих, чанарыг сайжруулах, практикийг дэлгэрүүлэхэд чиглэж байв.

Институт байгуулсан нь Нидерландад медици хөгжих анхны суурь болсон юм. Өнөөдөр Голландад /NMI/ эвлэрүүлэн зуучлагчид 2000 хол давж байгаа бөгөөд өдөр тутам өсөн нэмэгдсээр байна. Институт нь хараат бус байгууллага бөгөөд зуучлагчдын үйл ажиллагааны чанарт хяналт тавьж, тэдний сургалтыг зохион байгуулж, бүртгэж байна.

Эвлэрүүлэн зуучлалын стандарт нь уг үйл ажиллагааны үр дүнд өдөр тутам нарийвчилсан үнэлгээ өгөх, тэднийг үндсэн ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр эвлэрүүлэн зуучлагчдыг сургах үндсэн дээр тэднийг сонгон шалгаруулах, бүртгэх, эвлэрүүлэн зуучлалаар дагнасан байгууллагад сертификат олгох гэх зэрэг

ажиллагааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Институт нь өргөдөл гомдол хүлээн авах журам, сахилгын дүрэм, эвлэрүүлэн зуучлагчдын мэргэшил, эвлэрүүлэн зуучлалын чанарыг үнэлэх үндэсний хараат бус тогтолцоог боловсруулж баталсан байна. Энэхүү тогтолцоог нээлттэй, хөдөлгөөнтэй маягаар боловсруулжээ. Эвлэрүүлэн зуучлалын чанарын баталгааг хангах хэрэгцээ шаардлага нь тухайн институтээс гадна Голландын хууль зүйн яам, Шүүх эрх мэдлийн талаарх Парламентын байнгын хороо анхаарлын төвд байдаг¹.

1974 онд Канадын Торонто хотын хөндлөнгийн шүүхийн хэсэг шүүгч нар хөндлөнгийн шүүхийн эрх хэмжээг тодорхойлох тогтолцоог боловсруулах, эвлэрүүлэн зуучлах журмыг маргааны оролцогчид өргөн ашиглахыг дэмжих зорилгоор Канадын арбитрын институтийг байгуулжээ. Удалгүй Арбитрын Үндэсний институт байгуулагдсан бөгөөд түүний үндсэн зорилго нь:

1. Нийтлэг ашиг сонирхол, зорилт бүхий хүмүүсийг нэгтгэх;
2. Институтийн бүхий л гишүүдэд тэгш эрх олгох;
3. Институтийн санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг зохиох;
4. Ардчилсан процессын үндсэн дээр сайн дурын лидерүүдийг сонгох;
5. Институтийн гишүүдээс боловсруулсан дүрмийг батлах;
6. Гишүүнээр элсэх шаардлагыг тогтоох;
7. Гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөтөлбөрт оролцох болон бусад боломжоор хангах;
8. Институтийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор гишүүдийн тоог нэмэгдүүлэх зэрэг байв.

1988 оноос Канадад зуучлагч, зуучлагчдын сургалтын хөтөлбөр, зуучлалын стандартын эрэлт хэрэгцээ эрс өсөж, институт нь Канадын арбитрын

¹ Медиация в Нидерландах. Обзор/http://mediators.ru/rus/about_mediation/foreign_law/

болон зуучлалын Институт болон өргөжиж, зуучлалын сургалтын шинэ хөтөлбөрүүдийг боловсруулж байна.

Бельги улсад 2005 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдан гарч, Бельги улсад бүхий л төрлийн эвлэрүүлэн зуучлал хэрэгжих эрх зүйн үндэс бүрдсэн байна. Энэ хууль батлагдан гарсантай холбоотойгоор Бельгийн Шүүхийн байгууламжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оржээ.

Дээр дурдсанаас дүгнэлт хийхэд гадаад улс орнуудын зуучлагчдын төв байгууллага нь комисс, альянс, холбоо, зөвлөл, институт гэх зэргээр олон янзаар нэрлэгдэж байна. Мөн эдгээр байгууллагуудыг байгуулагдах журам, бүтэц, харьяалал, үйл ажиллагааны чиглэл зэргийг харьцуулан авч үзэхэд англо-америкийн, эх газрын, уламжлалт гэсэн гурван загварт ангилан авч үзэж болохоор байна.

Англи-америкийн загвар нь ихэвчлэн сайн дурын үндсэн дээр болон төрийн ба төрийн бус байгууллагын эвлэрүүлэн зуучлах институци давамгайлах байдлаар илэрч байна.

Эх газрын загвар нь Шүүх, эсхүл Засгийн газар, түүний дотор Хууль зүйн яамны хатуу хяналтад байж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа шүүхийн болон төрийн тогтолцооны нэг салаа мөчир гэж үзэх хандлага байна.

Уламжлалт загвар нь шашны болон зан заншлын эрх зүйн тогтолцоотой улс оронд шашны номлол, зан заншилд тулгуурласан овгийн ахлагч, нэр хүндтэй иргэдэд тулгуурласан эвлэрүүлэн зуучлалын уламжлалт хэлбэр хадгалагдаж байгаа онцлогтой байна.

Монгол Улсын хувьд англо-америкийн болон эрх газрын загварын холимог тогтолцооны хэв шинжтэй байна. Монгол Улсын шүүхийн Ерөнхий зөвлөл нь Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийг байгуулахын хамт анхан шатны шүүх дэх орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч, мөн төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлагчдыг сонгон

ажиллуулахаар хуульд зохицуулсан байна. Эвлэрүүлэн зуучлагчаар дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан, тухайн чиглэлийн асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулна.

Гэхдээ, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлагчдыг зохион байгуулалтын ямар хэлбэрээр ажиллуулах нь тодорхой бус байна. Гадаад орнуудын туршлагаар Монгол Улсад Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд олон улсын худалдааны асуудлаар, цаашдаа хууль тогтоомжийн зохицуулалтын хөгжлийг дагаж Сангийн яаманд татварын асуудлаар дагнасан захиргааны, УПЕГ -ын дэргэд эрүүгийн чиглэлээр эвлэрүүлэн зуучлагч ажиллах боломжтой гэж үзэж байна.

3. Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл, түүний бүрэн эрх.

Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийн дагуу Улсын Их Хурлаас шүүхийн багц хуулиуд баталсны нэг нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль юм. Шүүхийн бус журмаар гуравдагч этгээдийн тусалцаатайгаар талуудыг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх хэлбэр нь манай оронд төдийгүй дэлхийн ихэнх улс оронд шинэ тутам хөгжиж байгаа тогтолцоо юм. Энэхүү хуулиар эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зохицуулах ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, улмаар тухайн ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Тухайн хуулиар иргэний эрх зүйн болон хөдөлмөрийн ганцаарчилсан, түүнчлэн гэр бүлийн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэхээр заасны дотор гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэх болсон нь тухайн харилцааны онцлог тухайлбал төрөөс гэр бүлийг дэмжих, хүүхдийн эрх ашгийг нэн

тэргүүнд анхаарч байгаагийн нэг илрэл гэж үзнэ.

Энэ хуулийн ач холбогдол нь шүүхийн бус аргаар дээрх төрлийн маргааныг шийдвэрлэснээр иргэдийн хувьд ердийн журмаар шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээс хөрөнгө мөнгө, цаг хугацааны хувьд хэмнэлттэй байхаас гадна эвлэрүүлэн зуучлах журмаар байгуулагдсан эвлэрийн гэрээ шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх боломжийг энэ хуулиар бий болгосон юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлд “Шүүхийн ерөнхий зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ -ийг байгуулна” гэж заажээ.

Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн хуралдаанаар Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийг албан ёсоор байгуулж, “Эвлэрүүлэн зуучлагчдын Зөвлөлийг байгуулах болон загвар батлах тухай” 10 дугаар тогтоолыг гаргажээ. Уг хуралдаанаас хуульд заасны дагуу шүүгч, өмгөөлөгч, судлаач зэрэг таван хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийн 5 гишүүдийг баталсан бөгөөд энэ нь Зөвлөлийн үйл ажиллагаа хуулийн дагуу хэрэгжих эрх зүйн үндэслэлийг бий болгосон юм. Түүнчлэн мөн тогтоолоор эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдөл, эвлэрийн гэрээний болон мэдэгдэх хуудасны загварыг баталсан байна.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн эрхийг дараах байдлаар тодорхойлжээ. Энэхүү бүрэн эрхэд “эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, дүрэм, эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлс, урамшууллын журам, эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм, ажлын байрны стандартыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих, эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан

сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах, эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох, эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэрсийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэрсийн жагсаалтаас хасах, мөн Зөвлөлийн хуралдааны дэгийг тогтоох” зэргийг хамааруулжээ.

Түүнээс гадна Зөвлөл нь зуучлагчийн нэрсийг анхан шатны шүүх, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоонд санал болгох мөн түүний санал болгосон эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага болон Шүүхийн ерөнхий зөвлөл эвлэрүүлэн зуучлагчийг сонгон бүртгэж, тэднийг холбогдох журмын дагуу ажиллах нөхцөл, боломжоор хангаж ажиллах ёстой юм.

Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь хуульд заасны дагуу “Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн дүрэм”, “Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм”, “Шүүх дэх орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчид ажлын хөлс, зардал, урамшуулал олгох журам”, “Эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, бэлтгэх, давтан сургах журам”, “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны ажлын байрны стандарт”, “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам”, “Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн хуралдааны дэг”, “Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн зөрчлийг шалгах үйл ажиллагааны журам” болон “Эвлэрүүлэн зуучлагчийн энгэрийн тэмдэг”, “Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэг маргааны хавтас болон тухайн ажиллагаанд хэрэглэгдэх баримт бичгийн загвар”, “Эвлэрүүлэн зуучлагчийн эрхийн гэрчилгээ”, “Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хэрэглэх тэмдэг”-ний загваруудыг баталж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн вэб сайтад байршуулсан байна.

Гадаад улсын практикаас үзэхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэхэд эвлэрүүлэн зуучлагчийн мэргэжил, мэргэшил чухал үүрэгтэй

байна. Эвлэрүүлэн зуучлагч нь дараах шаардлагыг хангасан байхыг чухалчлан үздэг байна. Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулах үндсэн мэдлэгийг эзэмшсэн байхаас гадна мэргэжлийн тодорхой хүрээний /салбарын/ мэдлэгтэй байх, түүнчлэн мэргэжлийг нь илтгэсэн дипломтой байх хоёр гол чиг хандлагын байр суурийг баримталж байна. Хэдийгээр эвлэрүүлэн зуучлагч нь тусгай мэргэжил мэт боловч, мэдлэгийн янз бүрийн салбарт хэд хэдэн чиглэлээр дээд боловсролтой байхыг шаардах ёстой гэж үздэг юм байна.

Монгол улсад Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжихээс өмнө Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага “ЖАЙКА” болон Улсын Дээд шүүх, Монголын Өмгөөлөгчдийн холбооноос хэрэгжүүлж буй “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”-ийн хүрээнд дээрх байгууллагууд хамтран 2011 оноос өнөөдрийг хүртэл нийт 7 удаагийн Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалтаар улсын хэмжээнд нийт 400 гаруй эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгээд байна. Эвлэрүүлэн зуучлагчид тооны хувьд олон хэдий ч зарим алслагдсан аймагт 4-7 эвлэрүүлэн зуучлагч бэлтгэгдсэн нь хангалттай бус байгаа тул цаашид эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалтыг давтамжтайгаар явуулж байх шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн, эвлэрүүлэн зуучлагчийг зөвхөн тооны хувьд бус тэдгээрийг бэлтгэх сургалтын агуулгыг зөв тодорхойлох, улмаар тэдгээрт сургалтаар олгох шинэ мэдлэг, эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар, эвлэрлийн гэрээг боловсруулах улмаар эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүй, өөрсдөдөө сэтгэлгээний өөрчлөлт хийх шаардлага зэрэг зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг, мэдээллийг агуулсан байх нь зүйтэй гэж үзэж байна.

Эвлэрүүлэн зуучлагчийн байр суурь гэдэг маань төвийг сахисан, талууд өөрсдийн ашиг сонирхолд нийцэхүйц шийдлийг олох, тэдгээрийн хоорондын харилцааны зөрчил, маргааныг эвийн журмаар шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг

үзүүлэх явдал болохоос биш төрийн ямар нэгэн албадлагын шинжийг агуулж оролцохыг хуулиар хориглосон юм. Шүүгч, өмгөөлөгчөөр ажиллаж байсан хүмүүсийн ажлын арга барил эвлэрүүлэн зуучлагчийн ажлын арга барил эрс тэс өөр нь ойлгомжтой. Иймээс шүүгч, өмгөөлөгчөөр ажиллаж байсан хүмүүс шинэ ажлынхаа арга барилд маш хурдан сурах шаардлага чухал байгаа нь ойлгомжтой. Энэ үүднээс тэдэнд явуулах сургалтын нэг хэсгийг энэ ажиллагаанд зориулж, аль болох практик, туршлагад тулгуурлан явуулах шаардлагатай гэж үзнэ. Түүнчлэн шүүгч, өмгөөлөгчөөр ажиллаж байсан хүмүүсээс гадна шинэ залуу хуульчид олон байгаа учир тэднийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд сургах ажилд онцгой анхаарах шаардлагатай байгаа юм.

2012 онд Эвлэрүүлэн зуучлал ирэх 10 жилд гэсэн сэдвээр олон улсын хурал Сингапур улсад болсон бөгөөд уг хурлаас “Хүн бүр эвлэрүүлэн зуучлалыг ойлгодог болох хүртэл буюу жинхэнэ мэргэжил болтол хөгжүүлэх нь нэн шаардлагатай” болсныг хуралд илтгэл тавьсан судлаач, эрдэмтдийн илтгэлээс харж болно

Уг илтгэлүүдэд “Удирдагчид, ажил олгогч, уран бүтээлчид адилаар эвлэрүүлэн зуучлагч нь төрмөл байдаг, Эвлэрүүлэн зуучлагчид боловсрол болон техникийн ур чадвар зэрэг өөр бусад мэргэжил шаардагдах хэдий ч цэвэр дадлага хувь хүний ярианы болон итгүүлэх ур чадварт төвлөрсөн байдаг. Авьяас зөн совингоороо нөгөө талаа буулгаж авах нөгөө талаа буулгаж авахын тулд хоёр талд амжилттай ажиллах зуучлагч эрхгүй шаардагдана. Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан өөрийн бололцооны хүчээр итгэл төрүүлэх нь зуучлагчийн хамгийн дээд чанар байх ёстой. Энэ нь бардам бас даруу, хатуу чанга бас зөөлөн, хөнгөн бас ул суурьтай, итгэлтэй бас хашир, өөдрөг бас бодит байдалд тулгуурласан байхын тулд сэтгэл зүйн шинжтэй амжилтад хүрэхийн тулд суралцаж, хувь хүн талаасаа бас уг чанараар бэлтгэгдсэн байх ёстой. Өнөөдөр олонх зуучлагчид бэлтгэгдсэн хэдий ч

зөвхөн зуучлагчийн ажлын талаар мэдлэг олсноос бус эвлэрүүлэх арга барил, ярианы ур чадвар дутмаг байгаа талаар дээрх хурлын илтгэлд дурдсан байна. Энэ асуудал нь бас л бидний өмнө тулгамдаж байгаа болно.

Эвлэрүүлэн зуучлагчийн нэр хүнд нь түүний ажил үүргээ гүйцэтгэх чадвараас илүү харилцааны соёл, эв дүйг хэрхэн эзэмшсэнээс шууд хамааралтай болно. Түүнээс гадна эвлэрүүлэн зуучлагч албандаа хүндэтгэлтэй хандах, харилцааны соёлыг эрхэмлэн, төвийг сахисан байр суурьтай байж, талуудад алагчлалгүй тэгш хандан тэдний нууцыг хадгалах ёс зүйтэй байхыг эрхэмлэх энэ байдлыг эзэмшүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэрэгслийг судлах, сургах нь төр, засгийн түвшинд хэрэгжих ёстой тул эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдлэгийг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах зайлшгүй шаардлага гарна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой, улмаар уг ажиллагааны эцсийн үр дүн болох эвлэрлийн гэрээг баталгаажуулах, албадан биелүүлэх ажиллагааны үндэслэл болох гүйцэтгэх баримт бичгийг үйлдэх, албадан биелүүлэх шийдвэр гаргах ажиллагааг шүүхийн оролцоотой хийх учир Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс гаргаж буй зарим журам, дүрмийг гаргахдаа шүүхийн байгууллагатай хамтран ажиллах ёстой юм.

Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохын сацуу төрийн болон төрийн бус байгууллага, холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийг бий болгоход цаашдын үйл ажиллагааны зорилгыг чиглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

---o0o---

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛТОЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛААР ШИЙДВЭРЛЭХ НЬ

*ЖАЙКА-гийн “Эвлэрүүлэн зуучлах
тогтолцоог сайжруулах төсөл”-ийн
хуулийн зөвлөх Б.Оюу*

Удиртгал

Аль ч нийгмийн амьдралд зөрчил маргаан гардаг, харин тэр маргаанаа хэрхэн шийдвэрлэн зохицуулж чадаж байна вэ? гэдгээр нь тухайн нийгмийн хөгжлийн төвшинг үнэлж болох юм. Цаг хугацааг мөнгөөр хэмждэг болсон өнөө үед аль болох хурдан хугацаанд, ухаалаг аргаар аливаа асуудлаа зохицуулахыг эрмэлзэх хандлагатай болсон. Манай улсын хувьд хэрэг маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх “эвлэрүүлэн зуучлах тогтолцоо” нэвтэрч, бүх иргэний хэргийн анхан шатны шүүх дээр хэрэгжиж эхлээд удаагүй байгаа билээ. Иргэний эрх зүйн, хөдөлмөрийн ганцаарчилсан, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг¹ эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар талууд өөрсдөө шийдвэрлэх боломжтой болсон гэсэн үг.

Үүнтэй холбогдуулж, иргэд зам тээврийн ослоос үүдсэн иргэний эрх зүйн маргаанаа эвлэрүүлэн зуучлалаар шийдэх хандлага цаашид өсөх хандлагатай байна гэж таамаглаж болно. Тиймээс зам тээврийн ослоос үүдсэн гэм хорын хохирол барагдуулахтай холбоотой маргааныг шүүхийн бус аргаар хэрхэн шийдвэрлэдэг, энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагын бүтэц зохион байгуулалтын тухай Япон улсын туршлагыг цухас авч үзье.

1. Япон улсын туршлага-Зам тээврийн ослоос үүссэн маргааныг шийдвэрлэх төвийн үйл ажиллагаа

¹ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 3.1 зүйл

Маргаан үүссэн тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хандах, шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх төрийн болон төрийн бус байгууллагад хандах гэсэн хөндлөнгийн байгууллагын оролцоотойгоор шийдвэрлэх ерөнхий 3 арга хэлбэр бий. Эдгээрийн дотроос шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх ADR (Alternative Dispute Resopluton) байгууллагын жишээг авч үзье.

Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж буй Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслөөс 2014 онд зохион байгуулсан Япон дахь сургагч багш бэлтгэх сургалтын үеэр Зам тээврийн ослоос үүдэлтэй маргааныг шийдвэрлэх төвийн үйл ажиллагаатай танилцах боломж гарсан юм. Тус төв нь 1974 онд байгуулагдаж, шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх ажиллагаа явуулах байгууллагын хувиар зам тээврийн ослоос үүсэн хохирлын нөхөн төлбөртэй холбоотой эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, үнэлгээний ажлыг гүйцэтгэсээр ирсэн. Япон улсын хувьд, сүүлийн жилүүдэд авто ослын тоо болон үүнээс үүдсэн нас баралт, бие махбодид гэмтэл учирсан хэргийн тоон үзүүлэлт буурах хандлагатай байгаа ч тус төвөөс зөвлөгөө авах үйлчлүүлэгчдийн тоо тогтмол хэмжээгээр ихсэх хандлагатай байгаа юм.¹

Зам тээврийн ослын хохирогч нь автомашины хариуцлагын даатгал зэрэг төрөл бүрийн даатгалд хамрагдан тодорхой хэмжээнд хохирлоо барагдуулж чаддаг. Гэвч ихэнх тохиолдолд, хохирогч нөхөн төлбөр болон даатгалын тухай хангалттай мэдлэгтэй байдаггүйгээс гадна

²⁶ Япон улсад 1 жилд дунджаар 4600 хүн амь нас, 850000 хүн эрүүл мэндээрээ хохирдог байна. Харин Монгол Улсад 2013 оны байдлаар нийт 18367 зам тээврийн осол гарч, 423 хүн нас барж, 1282 хүн гэмтсэн байна.

тохиролцоонд хүрэх тал дээр нааштай ханддаггүй учраас маргаанаа шийдвэрлэх явц хүндэрч удаашрах хандлагатай байдаг ба хохирлоо нөхөн төлүүлж чадахгүй үлдэх тохиолдол ч бий. Ийм төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлж болох ч, хуулинд нарийн заагдсан шийдвэрлэх ажиллагаанд цаг хугацаа их зарцуулагддаг, мөн эрх зүйн мэдлэггүйгээс өмгөөлөгч хөлслөх зэрэг ихээхэн зардал гаргаж болох зэрэг шалтгаанаас энэ төвд хандах иргэдийн тоо нэмэгдсээр байна.

Тус төвийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах өмгөөлөгч төвийг сахисан байр суурьтай байж, талуудын тэгш эрхт оролцоог хангаж ажиллахад оршино. Эдгээр зарчим нь эвлэрүүлэн зуучлалын амин сүнс бөгөөд манай улсын хуульд ч энэ тухай заасан байдаг¹. Мөн тус төвд ажиллах өмгөөлөгч зөвлөгөө өгөх, талуудыг эвлэрүүлэх ажиллагаа явуулахдаа талуудаас ямар нэгэн хураамж авдаггүй гэдгээрээ онцлогтой. Санхүүгийн эх үүсвэр нь даатгалын компанийн холбооноос байгуулсан тусгай сан. Тайлбар гаргагч талыг төлөөлөн маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцох даатгалын компани нь шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээр бол хэрэг тус бүрт өмгөөлөгчийн үйлчилгээний өндөр хөлс гаргах зэрэг олон эрсдэлтэй тул ийнхүү нэгдсэн санг байгуулан, даатгуулагчтай холбоотой үүссэн маргааныг тус төвөөр шийдвэрлүүлэх зохицуулалт хийсэн байна. Тиймээс хохирогч тус төвд хандах үндсэн нөхцөл нь нөгөө талын даатгалд нь ийм төрлийн үйлчилгээ дагалдсан байх юм. Япон улсын хувьд, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал зөвхөн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлөгддөг ба түүнийг хохирогч даатгагч компаниас шууд шаардах эрхтэй байдаг.

Шийдвэрлэх ажиллагааны хувьд өргөдөл гаргагч утсаар цаг авч, тус төвийн өмгөөлөгчөөс зөвлөгөө авна. Нийт өргөдөл

гаргагчийн 80.4%¹ нь зам тээврийн ослын хохирогч байдаг. Ийнхүү зөвлөгөө авсны дараа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах өргөдөл гарган, өмгөөлөгч энэ ажиллагааг явуулах боломжтой гэж үзсэн тохиолдолд тус төвөөс тайлбар гаргагч тал эсвэл тухайн даатгагч компанийг оролцуулснаар ажиллагаа эхэлдэг. Хүний бие махбодид гэмтэл учирсан маргааны хувьд дунджаар 3-5 удаагийн уулзалтаар, эд хөрөнгийн хохиролтой холбоотой маргаан ихэвчлэн 2 удаагийн уулзалт явуулсны дүнд эвлэрсэн гэсэн судалгаа гарсан байна. Хэрэв эвлэрч чадаагүй бол өргөдөл гаргагч тал хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох мэргэжлийн үнэлгээ явуулах хүсэлт гаргах боломжтой. Өөрөөр хэлбэл, эвлэрүүлэх ажиллагааны үр дүнд өмгөөлөгчийн санал болгосон дундын хувилбар болох шийдлийг талууд зөвшөөрөөгүй бол нөхөн төлбөрийн хэмжээг шууд тогтоолгож болно. Өргөдөл гаргагч үнэлгээний дүн гарснаас хойш 14 хоногийн дотор татгалзах эрхтэй ба хэрэв татгалзаагүй бол тайлбар гаргагч тал болох даатгагч компанид тухайн үнэлгээний дүнгээр нөхөн төлбөр төлөх үүрэг үүснэ. Энэ нь даатгалын компани тус байгууллагын үнэлгээний хорооноос гаргасан шийдвэрийг хүндэтгэнэ. Гэсэн агуулгатай хэлэлцээр байгуулдаг учраас юм. Тиймээс хэрэв тайлбар гаргагч даатгалын холбоонд нэгдсэн даатгалд хамрагдсан бол өргөдөл гаргагчаас ямар нэг зардал гарахгүй, мөн богино хугацаанд шийдэлд хүрч болно гэдэг утгаараа хохирогч талын эрх ашгийг хамгаалахад чухал хувь нэмрээ оруулж байна.²

Хэрэв эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад даатгалын компаниас энэ ажиллагааг дуусгавар болгон, шүүхээр хянан шийдвэрлүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зогсоон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэх тухай хяналтын зөвлөл хэлэлцэж хүсэлтийг шийдвэрлэдэг. Жишээ нь ослын байдлыг тодорхойлох

¹ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 5.2 зүйл

² 2012 онд 6824 маргаан гарчээ.

³ "Зам тээврийн ослын нөхөн төлбөр ба ADR", Токно хот., 2010 он, 119 дэх тал

баримт байхгүй, осол болон гэмтлийн шалтгаант холбоог тодорхойлох боломжгүй зэрэг шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх нь зохистой гэж шийдвэрлэсэн тохиолдолд ажиллагаа дуусгавар болно. Даатгуулагчтай холбоотой маргааныг тус төвөөр эвлэрүүлэн зуучилдаг энэхүү тогтолцооны нөлөөгөөр шүүхэд хэрэг үүсэхээс өмнө талууд хэд хэд уулзаж, маргалдаж буй гол зүйлээ тодорхой болгох нь олонтаа.⁸⁰ Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хугацааг хэмнэхийн тулд нэгэнт тодорхой болсон гол маргаантай асуудлаа тайлбартаа урьдчилж нарийн тусгах шаардлагатай.

Дээр дурдсан эвлэрүүлэн зуучлал болон үнэлгээгээр нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож санал болгохдоо шүүхийн шийдвэрийн сан, тус төвөөс гаргасан үнэлгээний жишиг, нэгдсэн хуралдааны судалгааны дүн зэргийг ашигладаг. Эвлэрүүлэн зуучлалаар талууд тохиролцоонд хүрч чадсан бол энэ ажилагааг хариуцсан өмгөөлөгчийг байлцуулан эвлэрлийн бичиг(эрх зүйн хувьд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох чадваргүй ч мэдүүлгээ нотлох хэрэгсэл болгон ашиглагддаг), хариуцлагаас чөлөөлөх эсвэл багасгасныг батлах баримт бичгийг боловсруулдаг.

2012 оны байдлаар нийт хүлээн авсан хэргийн 88.6% (7608) нь эвлэрч, ямар нэг шалтгаанаар ажиллагаа явуулахаас татгалзсан эсвэл бусад шалтгаанаар эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон 8.5% (730); “нөхөн төлбөрийн хэмжээг тооцон, цаашид ямар аргаар маргаанаа шийдвэрлэх тухай зөвлөгөө авсан” 0.7% (59); “Шүүхэд хэрэг үүсгэн маргаанаа шийдвэрлүүлэх тухай, Эрх зүйн тусалцааны төв Өмгөөлөгчдийн холбооны тухай танилцуулсан” 0.2% (14); бусад буюу “зөвлөгөө авсан” 2.0% (173) байна. Эвлэрсэн 7608 хэргийн дотор үнэлгээ⁸² явуулж, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоон эвлэрсэн нь 8.2% (626) байна.

Дээрхээс үзэхэд цаашид зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлал бус энэ төрлийн маргааныг дагнан шийдвэрлэдэг төрийн болон төрийн бус байгууллага манай улсад үүсч хөгжих боломжтой нь харагдаж байна.

2. Зам тээврийн осолтой холбоотой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад анхаарах зарим зүйлс

Зам тээврийн ослоос үүдсэн нөхөн төлбөртэй холбоотой маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэхэд ашигтай тал хэд хэд бий.

Нэгдүгээрт, өргөдөлдөө маргааны агуулгыг тодорхой тусгасан байхад заавал нотлох баримт цуглуулах шаардлагагүй. Өргөдөлд ослын схем зураг, замын цагдаагийн дүгнэлтийг өргөдөлдөө хавсаргасан байх нь олон ч, энэ ажиллагааны үр дүнд гарах эцсийн шийд нь талуудын харилцан ойлголцол буюу тохиролцоо байдаг. Тиймээс нөхөн төлбөрийн хэмжээ, төлөх арга хэлбэрийг талуудын хэн алинд боломжтой байдлаар зохицуулах боломжтой.

Хоёрдугаарт, дээр дурдсанчлан харьцангуй богино хугацаанд шийдвэрлэх боломжтой. Ослын улмаас эд хөрөнгө бүр цаашлаад эрүүл мэндээрээ хохирсон бол энэ нь тухайн хохирогчийн эдийн засгийн болоод нийгмийн амьдралд үзүүлэх сөрөг нөлөө бусад төрлийн маргаанаас илүү их байдаг. Тиймээс маргааныг аль болох түргэн хугацаанд шийдвэрлэж, хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага хэрэгцээ өндөр юм. Түүнчлэн, шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлэж, эвлэрлийн гэрээ байгуулсан бол тухайн гэрээ нь шүүхийн шийдвэртэй нэгэн адил хүчин төгөлдөр буюу заавал биелэгдэх шинжтэй гэдэг нь бас нэгэн давуу тал юм.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь нарийн тогтсон хэлбэрт баригддаггүй ба тухайн маргааны нөхцөл байдал, эвлэрүүлэн зуучлагчийн өөрийнх нь “туршлагад

⁸⁰ “Шүүхийн шийдвэрийн тухай цуврал товхимол-Ханрэй таймз” №16, Токно хот., 2004 он, 21 дэх тал

⁸¹ Үнэлгээг хуульч эрдэмтэн судлаач, шүүгчээр ажиллаж байсан мөн туршлага арвин өмгөөлөгч нар явуулдаг.

⁸² “Зам тээврийн ослын нөхөн төлбөр ба ADR” , Токно хот., 2010 он, 133 дахь тал

үндэслэсэн” арга барилаас хамаарч ялгаатай байна. Гэвч зам тээврийн ослоос үүдсэн маргааныг эвлэрүүлэн зуучлахдаа дараах ерөнхий зүйлсийг тодруулах хэрэгтэй болдог.¹

1)Осол гарсан үеэс эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргах хүртэлх явцыг бүрэн ойлгохын тулд:

-Хэзээ гарсан осол вэ?;

-Ослын шалтгаан юу вэ?;

-Ослын шалтгаанд талууд хэрхэн нөлөөлсөн бэ?;

-Бие махбодид гэмтэл учирсан бол хэрхэн эмчлүүлж байгаа вэ?;

-Хэзээнээс эдгэрсэн бэ? Хамгийн сүүлд хэзээ эмчилгээнд хамрагдсан бэ?;

-Ажлаас хэр зэрэг завсардсан бэ?;

2) Өргөдөл гаргагч нь гэм хор учруулсан этгээд үү, эсвэл хохирогч тал уу?;

3) Өргөдлийн зорилго юу байв?;

-Өргөдлийн шаардлага юу байв?;

-Шаардаж буй нөхөн төлбөрийн хэмжээ хэр бодит вэ?;

-Өргөдөлд цагдаагийн дүгнэлт зэрэг баримтыг хавсаргасан эсэх;

4) Өргөдөл гаргагч ямар асуудлын улмаас эвлэрүүлэн зуучлагчид хандахад хүрсэн бэ? зэрэг ойлгох хэрэгтэй.

Эдгээр асуудал нь ихэвчлэн эвлэрүүлэн зуучлагчийн ажиллагаа эхлэхийн өмнөх бэлтгэл хангах үед зарим тохиолдолд ажиллагааны явцад талуудын өгөх тайлбар дундаас тодорхой болдог байна.

---о0о---

⁸¹ “Эвлэрүүлэн зуучлалын цаг үеийн мэдээ” №178, Токио хот..2011 он, 83-84 дэх тал

ЭВЛЭРЛИЙН ГЭРЭЭ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА



Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн гишүүн, Монгол-Өмгөөлөгч хууль зүйн фирмийн захирал З.Сүхбаатар

Удиртгал

Нийгмийн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуулиар зохицуулахын сацуу, талуудын хүсэл зоригийн илэрхийлэл болсон гэрээгээр зохицуулна. Гэрээг бид иргэний эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдсэн хоёр буюу түүнээс дээш этгээдийн хоорондын хэлэлцээр хэмээн түгээмэл байдлаар тодорхойлж заншжээ. Ер нь бол гэрээг эрх зүйн харилцааны түгээмэл хэлбэр гэж ойлгох явдлаар хязгаарлах нь төдий л оновчтой биш бөгөөд харин эрх зүйг хэрэгжүүлэх болон хэрэглэх үйл явцын нэг илрэл гэж үзэх нь онол практикийн чухал ач холбогдолтой⁸⁴.

Гэрээ нь хүмүүсийн хамтын үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах, тодорхой асуудлыг шийдвэрлэх, ашиг сонирхлыг уялдуулах түгээмэл хэрэглэл билээ. Тийм ч учраас гэрээний харилцааг төрөл бүрээр нь шинжлэх ухааны үндэслэлтэй судалж хууль тогтоомжийн

зохицуулалтад төлөвшүүлж, практик үйл ажиллагаа болговол үр өгөөж нь маш их юм. Гэрээний зохицуулалт нь тохиролцож буй талуудын нийгмийн гарал үүслээс огтхон ч хамаарахгүй. Харин гэрээний харилцаа нь талуудын хоорондох нийгмийн болон садан төрлийн харилцаанаас ихээхэн хамаарна. Огт танихгүй хөндлөнгийн хүмүүсийн хувьд гэрээнд өгөх ач холбогдол маш өндөр байдаг бол "талууд хэдий хэр дотны харилцаатай байна, тэр хэмжээгээр гэрээнд өгөх ач холбогдол сулрах ба зөвхөн гэрээ цуцлагдах тохиолдолд гэрээний ач холбогдол дахин өсдөг байна"⁸⁵.

Гэрээний төрлүүд дотроос эвлэрлийн гэрээ нь талуудын маргаан буюу санал зөрчилдөөнийг шийдвэрлэхэд түгээмэл хэрэглэгддэг. Эвлэрлийн гэрээ нь тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг нарийвчлан зохицуулдаг гэж хэлж болно.

Эвлэрлийн гэрээ, түүний ойлголт

1994 оны Иргэний хууль (шинэчилсэн найруулга)-ийн үүргийн нийтлэг үндэслэлд "талууд хоорондын маргаанаа харилцан буулт хийх замаар шийдвэрлэхээр эвлэрлийн гэрээг байгуулж болно" гэж зохицуулсан бол 2002 оны Иргэний хуульд тухайлан зохицуулаагүй бөгөөд гэрээний эрх зүйн нийтлэг үндэслэл (189 дүгээр зүйл)-д хамааруулахаар байна Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрсэн тохиолдолд маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар ИХШХШ тухай хуулийн 74-75 дугаар зүйлд тодорхой зохицуулсан байна.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд "эвлэрлийн гэрээ гэж маргаан буюу

⁸⁴ Д.Баярсайхан. Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудлууд. УБ.2012., 172-173 дахь тал.

⁸⁵ Норбер Рулан. Юридическая антропология. М.1999., стр 132

тодорхой санал зөрөлдөөнтэй асуудалд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсны үр дүнд талуудын хооронд бичгээр хийсэн хэлцлийг хэлнэ” гэсэн байна. Хэдийгээр амьдралд маргааны талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад болон тус ажиллагаанаас гадна өөрсдийн идэвх санаачилгаар эвлэрэлд хүрч гэрээ байгуулах нь нэлээдгүй байдаг.

Энд тухайлан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулагдаж байгаа эвлэрлийн гэрээний талаар авч үзэж байгаа болно. Талууд¹ эвлэрэлд хүрэх эсэх нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнгээс хамаарна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны мөн чанар нь талууд өөрсдийн ашиг сонирхолд нийцсэн шийдлийг олоход эвлэрүүлэн зуучлагч дэмжлэг үзүүлэх, ухаалаг хандах, төвийг сахин нөлөөлөл

¹ Талууд гэж иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг зохицуулах хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээдийг, түүнчлэн шүүх эвлэрүүлэн зуучлалыг зохистой гэж санал болгосныг зөвшөөрснөөр эвлэрүүлэн зуучлалд оролцох болсон зохигч /нэхэмжлэг, хариуцагч/-ийг хэлнэ.

үзүүлэхэд чиглэгдэнэ. Харин зөвхөн эвлэрүүлэхийн төлөө шахах, нэг талд зөвлөх, албадах зэрэг зүй бус байдлаар талуудад хандаж хэрхэвч болохгүй. Ийм хандлага нь итгэлцлийг үгүй хийх, улмаар шүүхээр шийдвэрлүүлэх маргаанд хүргэх гэмтэй. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлагч нь зөвхөн эцсийн үр дүнд хөтлөгдөж болохгүй. Зөвхөн эвлэрэлд хүргэх гэсэн уриа нь эцэстээ хэзээ ч эвлэрэхгүй байдалд хүргэж ч болох юм. Ерөөсөө талуудад эвлэрэхэд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн бүх талын зохистой арга хэмжээ нь эвлэрүүлэн зуучлагчийн ажлын үр дүн мөн. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах, эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох зарчимд үндэслэнэ.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хувийн эрх зүйн харилцаанаас үүссэн хэрэг маргаанд хэрэглэнэ. Тухайлбал:

д/д	Маргааны төрөл	Холбогдох тайлбар
1.	Иргэний эрх зүйн маргаан	Талууд маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлүүлэхээр гэрээндээ хэлэлцэн тохиролцсон, түүнчлэн шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэснээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно.
2.	Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	Уг маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ажил олгогч болон ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хүрээнд явагдана.
3.	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ. Шүүхээс тогтоосон хугацаанд гэрлэгчид эвлэрээгүй бол шүүх гэрлэгчдийн хооронд үүссэн гэрлэлт цуцлахаас бусад тэтгэвэр, тэтгэлэг, тэтгэмж, дундын хөрөнгө хуваахтай холбогдсон маргаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл гэрлэгчдийн сонгосон эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулж болно. Мөн гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд сэтгэл зүйч болон төрөл, садан, найз нөхөд, хамтран ажиллагсдыг оролцуулж болно.

Эвлэрлийн гэрээнд тавигдах хууль зүйн шаардлага

Эвлэрлийн гэрээ нь хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан нөхцөлд талуудын хооронд гэрээний эрх, үүрэг үүсгэнэ. Тиймээс Эвлэрлийн гэрээгээр эрх, үүрэг үүсгэхийн тулд гэрээний талууд дор дурдах шаардлагыг бүрэн хангуулах учиртай. Үүнд:

Нэг. Гэрээний талууд эрхийн чадвар, чадамжтай байх. Эвлэрлийн гэрээ нь талуудын хүсэл зоригийн илэрхийлэл тул талууд эрхийн чадамжийн тодорхой түвшинг илэрхийлнэ. Иргэний эрх зүйн чадамж гэдэг нь өөрийн үйлдлээр эрхээ хэрэгжүүлж, оногдсон үүргийг бие даан биелүүлж, эрх эдэлж үүрэг биелүүлснээс үүдэн гарах хууль зүйн үр дагаврыг хариуцахыг хэлнэ.

Эрх зүйн бүрэн чадамж нь иргэн өөрийн үйлдлээр эрх олж, үүрэг бий болгож түүнээс үүдэн гарах хууль зүйн үр дагаврыг өөрөө бүрэн хариуцах байдлаар илэрнэ. Эрх зүйн бүрэн чадамж нь ерөнхий тохиолдолд 18 наснаас бий болно. Харин зарим нэг онцгой тохиолдолд 16-18 хүртэлх насны иргэнийг өөрийнх нь хүсэлт, эцэг, эх, харгалзан дэмжигчийнх нь зөвшөөрлөөр эрх зүйн бүрэн чадамжтайд шүүхээс тооцож болно. Эрх зүйн бүрэн чадамжтай иргэд нь эвлэрлийн гэрээний нэг тал болох хууль зүйн боломжтой.

Хоёр. Гэрээний талуудын хүсэл зориг, хүсэл зоригийн илэрхийлэл, үр дагавар гурав нь нэгдэлтэй байна.

Эвлэрлийн гэрээний талуудын хүсэл зориг, хүсэл зоригийн илэрхийлэл нь хоорондоо нийцж тэдний хүссэн үр дагаврыг бий болгосон байх ёстой. Өөрөөр хэлбэл эвлэрлийн гэрээний талууд хүсэл зоригоо илэрхийлэхдээ ямар нэг алдаа магадгүй илэрхийлэх учиртай. Хэрвээ хүсэл зоригоо гадагш илэрхийлэхдээ алдаа гаргавал талуудын үнэнхүү хүсэж байсан үр дагавар бий болохгүй юм. Монгол Улсын

эвлэрлийн гэрээний харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн зохицуулалт ёсоор гэрээний анхдагч үндэс нь талуудын **хүсэл зориг** юм. Хүсэл зориггүйгээр эвлэрлийн гэрээ хийгдэхгүй бөгөөд хийгдсэн тохиолдолд хүчин төгөлдөр бус болно. Тиймээс хүсэл зориг нь аливаа хэлцэл тэр дундаа эвлэрлийн гэрээг хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байх, эсэхэд нөлөөлөх анхдагч нөхцөл болдог. “Хүсэл зориг нь субъектийн зан байдлыг зохицуулах сэтгэл зүйн процесс”¹ тул эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр байх нэг шалгуур болно. Түүнчлэн практикт “өөрийн дотоод хүсэл зориг байгаагүй байхад хийгдсэн ямар нэгэн үйлдэл, үйл хөдлөл нь хууль зүйн үр дагавар бий болгож болно”². Хүсэл зориг илэрхийлэгдээгүй хийгдсэн гэрээ нь “бусдын нөлөөллөөр буюу тийм нөлөөлөлгүй байж болдог”³ байна. Хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх, төөрөгдүүлэх замаар хийсэн эвлэрлийн гэрээ нь бусдын нөлөөллөөр хийсэн эвлэрлийн гэрээнд хамаарах бөгөөд, хүчин төгөлдөр бусад тооцуулж болно.

Эвлэрлийн гэрээг хийхийн тулд түүний агуулга, мөн чанар, үр дагавар, тохиролцсон зүйлс зэрэг цогц асуудлыг талууд урьдчилан төлөвлөж боловсруулдаг. Эдгээр субъектив дэг жаягийг агуулсан, өөрийн ухамсар бүхий санаа зорилгыг хүсэл зориг гэж хэлж болно. Хүсэл зориг нь хүний сэтгэлээс (дотоодоос) гадагш нийгэм рүү чиглэсэн, эрэлхийлсэн байдаг онцлогтой.

Гурав. Агуулга нь хуульд нийцсэн байх ёстой. Эвлэрлийн гэрээ нь хуульд нийцсэн байх ёстой. Энэ нь эрх зүйн тогтолцоонд хуулийн зохицуулалт тэргүүлэх үүрэгтэй байх үзэл санаанаас үүдэлтэй юм. Талууд хуульд нийцүүлэн эвлэрлийн гэрээ байгуулсан тохиолдолд эрх зүйн харилцаа

⁸⁷ Ойгензихт В.А. Воля и волеизъявление (Очерки теории, философии и психологии права) Душанбе, 1983, СТР 24.

⁸⁸ Наранчимэг Д. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. УБ. 1999, 39 дахь тал.

⁸⁹ мөн тэнд.

үүснэ. Харин хуулиар тогтоосон хэм хэмжээг зөрчин хийсэн эвлэрлийн гэрээ нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасны дагуу хүчин төгөлдөр бус байна. Энэ талаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т "...эвлэрлийн гэрээ нь иргэний хуульд нийцсэн байна" гэж заасан.

Дөрөв. Гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй байх ёстой. Талууд эвлэрлийн гэрээ байгуулах явцдаа гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа эсэх талаар сайтар анхаарах ёстой. Гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн эвлэрлийн тухай яриа, тохиролцоо нь үр дүнгүй болох магадлалтай. Тухайлбал: Иргэн А бусдаас мөнгө зээлдсэн бөгөөд, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад өөрийн дүүтэй хамтран өмчилдөг орон сууцаа зээлийн өрөнд өгөхөөр санал гаргасныг нэхэмжлэгч хүлээн зөвшөөрсөн байна. Энэ тохиолдолд А нь дүүгээсээ заавал зөвшөөрөл авах ёстой. А-ийн хамтран өмчлөгч болох дүү нь зөвшөөрөөгүй нөхцөлд дээрх эвлэрэл хэрэгжих боломжгүй болно.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т "...эвлэрлийн гэрээ нь гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна" гэж заасан.

Тав. Хэлбэрийн шаардлагыг хангасан байх ёстой. Талууд эвлэрлийн гэрээг байгуулахдаа хэлбэрийн шаардлагыг хангуулах ёстой. Хэрэв хэлбэрийн талаарх шаардлагыг хангуулаагүй бол тухайн тохиролцоо хийгдсэн эсэх, талууд эвлэрэлд хүрсэн эсэх нь тодорхойгүй болно. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т эвлэрлийн гэрээг бичгээр хийх талаар зохицуулсан байна.

Гэрээний эрх зүйн онолын үүднээс авч үзвэл эвлэрлийн гэрээний агуулга нь гол нөхцөл, ердийн нөхцөл, тохиолдлын нөхцөлөөс бүрдэх бөгөөд, энэ нь тодорхой бүтцээр хэлбэрждэг. Хуульд зааснаар

эвлэрлийн гэрээнд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- Гэрээ байгуулсан он, сар, өдөр;
- Эвлэрүүлэн зуучлагчийн овог, нэр;
- Маргалдагч талуудын овог, нэр;
- Маргалдагч талуудын хаяг;
- Эвлэрүүлэн зуучлал эхэлсэн он, сар, өдөр;
- Маргааны агуулга;
- Маргааны талаарх талуудын байр суурь;
- Тохиролцсон зүйлс;
- Бусад асуудал.

Эдгээр зүйлсийн бүрдлээр эвлэрлийн гэрээний бүтцийг илэрхийлж болно. Эвлэрлийн гэрээний төслийг талуудын хэн аль нэг нь эсхүл тэдний хүсэлтээр эвлэрүүлэн зуучлагч боловсруулж болно. Эвлэрлийн гэрээний төслийг Монгол хэлээр болон талуудын тохиролцсон гадаад хэлээр боловсруулж болно. Гадаад хэлээр гэрээний эхийг боловсруулсан бол албан ёсны орчуулгыг дагалдуулна.

Эвлэрлийн гэрээний төслийг боловсруулахдаа эвлэрлийн нөхцөл буюу тохиролцсон зүйл, үүрэг биелүүлэх газар, хэлбэр, дараалал, хугацаа, эрх, үүрэг зэргийг сайтар ойлгож зөв томъёолох ёстой. Хэрэв эдгээр нөхцөлүүдийг тодорхой бус томъёолбол тухайн эвлэрлийн гэрээ хэрэгжих нөхцөлгүй болж улмаар шинэ маргаан үүсэж болно.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд эвлэрлийн гэрээ байгуулсан боловч үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх явдал гарч болно. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь эрх, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж шүүхэд мэдүүлэх эрхтэй. Ийнхүү мэдүүлсэн нөхцөлд шүүх хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн захирамж гаргах бөгөөд тухайн захирамжид талуудын аль нэг нь гомдол гаргах эрхгүй. Түүнчлэн захирамжийг сайн дураараа биелүүлээгүй нөхцөлд шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэж болно.

---о00---

ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА БА ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫГ ҮНЭЛЭХ НЬ



МУИС-ийн ХЭС-ийн багш, хууль зүйн ухааны доктор (LL.D), дэд профессор Д. Гангабаатар

Удиртгал

Эвлэрүүлэн зуучлах нь маргааныг шийдвэрлэх түгээмэл арга болохын хувьд эртний түүхтэй боловч эрх зүйн салбарт шинэлэг үзэгдэл юм.¹ Хэдийгээр шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлах тухай ойлголт нь маргааныг шийдвэрлэх уламжлалт арга механизмыг орлох шинэлэг боломж гэж үзэх хандлага байдаг ч хууль, эрх зүйн систем болон шүүхийн тогтолцоо бий болохоос өмнө дэлхийн улс орнуудад эвлэрүүлэн зуучлалын олон хэлбэр оршиж байжээ.² Тухайлбал, эртний Грекийн хот улсуудаас эхлээд дундад зууны Англид эвлэрүүлэн зуучлах аргаар маргааныг шийдвэрлэдэг байжээ.³

Бүр эртний Сумерийн соёл иргэншилд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэж байсныг батлах 4000-д жилийн өмнөх баримт байдаг.⁴

¹ Nadjia Marie Alexander, *Global Trends in Mediation* (Otto Schmidt Verlag DE, 2003), 1.

² Эвлэрүүлэн зуучлалын эртний хэлбэрүүдийн талаар эндээс үзнэ үү. Roebuck D., "The Myth of Modern Mediation," *Arbitration* 73 (n.d.): 106.

³ David Levinson, *Aggression and Conflict: A Cross-Cultural Encyclopedia* (ABC-CLIO, 1994); Roebuck, "The Myth of Modern Mediation," 105.

⁴ Larry Spain and Kristine Paranaica, *Consideration for Mediation*

Хорьдугаар зуунд АНУ болон Европын улс орнуудад эвлэрүүлэн зуучлалыг хөдөлмөрийн маргаанд хэрэглэж байсныг⁵ эс тооцвол орчин үеийн эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн үндсийг тавьсан хүн бол Харвардын их сургуулийн профессор Фрэнк Сандер гэж үздэг. Тэрээр 1976 онд "Паунд" эрдэм шинжилгээний хурал дээр "Маргаан шийдвэрлэх өөр арга замууд" сэдвээр тавьсан илтгэлдээ⁶ анх удаа "Alternative dispute resolution - шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх"⁷ гэдэг нэр томъёог анхлан хэрэглэснээр энэ салбарын эцэг хэмээн нэрлэгдэх болжээ.⁸

Сандерын илтгэлээс "олон хаалгат шүүх"-ийн талаарх ойлголт бий болов. Америкийн Барын Холбоо, мужийн болон холбооны засгийн газрын дэмжлэгтэйгээр эвлэрүүлэн зуучлалыг төрөл бүрээр туршиж байв. Үүнтэй зэрэгцэн адил төстэй туршилтыг Европын зарим улсад мөн хэрэгжүүлж байв. Гэвч удалгүй эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг иргэдэд түгээх боломж бага байсан

⁴ Alan Scott Rau et al., *Mediation and Other Non-Binding ADR Processes* (Foundation Press, 2002), 75.

⁵ Фрэнк Сандер энэхүү илтгэлийг тавьж байх үетэй давхцан Европт маргаан шийдвэрлэх өөр арга замын талаар судалгаа хийгдэж байжээ. Cappelletti, *Cappelletti Access to Justice 4 Vols* (BRILL, 1979).

⁶ "Alternative dispute resolution" хэмээх ойлголтын талаар Фрэнк Сандерын бусад эрдэмтэдтэй хамтран зохиосон дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү. Stephen B. Goldberg et al., *Dispute Resolution: Negotiation, Mediation, Arbitration, and Other Processes* (Wolters Kluwer Law & Business, 2012).

⁷ Орчин үеийн эвлэрүүлэн зуучлал, маргаан шийдвэрлэх өөр арга замын талаар Рожер Фишер болон Виллиам Ури нар анхлан хөндөж тавьсан тухай судалгааг эндээс уншина уу. Carrie Menkel-Meadow, "Mothers and Fathers of Invention: The Intellectual Founders of ADR," *Georgetown Law Faculty Publications and Other Works* (2000). http://works.bepress.com/carrie_menkel-meadow/11.

зэргээс шалтгаалан эвлэрүүлэн зуучлалын зарим хөтөлбөрүүд амжилтгүй болж эхэлжээ. Харьцангуй цөөн тооны иргэд, хуулийн этгээд эвлэрүүлэн зуучлалын аргыг сонгож, дийлэнх олонх нь маргаанаа шийдвэрлүүлэхээр шүүхэд хандсан хэвээр байв. Ийнхүү 1980-д оны дунд үеэс эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхийн институттай уялдаатайгаар хөгжүүлэх нь зүйтэй болох талаар эрдэмтэн, судлаачид бичиж эхэлжээ.¹

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад эвлэрүүлэн зуучлалыг уламжлалт эрх зүйн системтэй харилцан уялдаатай хөгжүүлэх нь үр нөлөөтэй болох нь харагддаг.² Сүүлийн 30 жилийн дотор эвлэрүүлэн зуучлал нь шүүхийн дэргэд болон шүүхээс гадуур төрөл бүрийн хэлбэрээр дэлхийн олон улсад эрчимтэй хөгжиж, эрх зүйн тогтолцоонд нь онцгой байр суурь эзлэх болсон. Эвлэрүүлэн зуучлалын хөгжил улс орон бүрд өөрийн гэсэн онцлогтой хөгжиж ирсэн боловч сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгаа нь эвлэрүүлэн зуучлалын давуу талуудтай холбоотой юм.

Шүүхийн журмаар хэрэг маргааныг шийдвэрлэхэд сар жилээр үргэлжлэх болдог бол эвлэрүүлэн зуучлалаар хэдхэн цагийн дотор маргааныг шийдвэрлэх боломжтой тул маргааныг түргэн шуурхай шийдвэрлэснээр оролдогч талуудын хувьд цаг хугацаа, зардал хэмнэх давуу талтай.³ Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролдогчдын нууцыг хадгалах нь энэ ажиллагааны хамгийн том давуу талын нэг юм. Талуудаас гадна эвлэрүүлэн зуучлагч л тухай хэрэг маргааны талаар мэдэх бөгөөд ихэнх эрх зүйн тогтолцоонд эвлэрүүлэн зуучлалын агуулгатай холбоотой мэдээллийн нууцлалыг хуулиар

баталгаажуулсан байдаг.¹ Олон тохиолдолд зуучлагч нт зуучлалын явцад хийсэн тэмдэглэлийг устгаж, нотлох баримтыг талуудад буцааж өгдөг. Түүнчлэн, талууд шийдэлд хүрэхийн тулд хамтран ажиллах сонирхолтой байх тул гаргасан шийдвэрээ хүндэтгэн биелүүлэх хандлагатай байдаг. Эвлэрүүлэн зуучлал нь дээр дурдсан олон давуу талтай тул сүүлийн хэдэн арван жилийн дотор дэлхийн олон улсад дэлгэрч, манай улсад 2012 онд тусгайлсан хуулиар энэ харилцааг зохицуулах болсон. Эвлэрүүлэн зуучлалыг төрөөс тухайлан дэмжиж, эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэг маргааныг шийдвэрлэхэд өргөн хүрээнд хэрэглэж байгаа нь зуучлалын үр дүнтэй шууд холбоотой. Олон судалгааны ажилд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа ихэнх тохиолдолд буюу 80-с 90% нь шийдэлд хүрдэг гэж дүгнэсэн нь маргаан шийдвэрлэх чухал арга зам болсныг харуулж байна.²

АНУ-ын туршлага

1998 онд АНУ-ын конгресс “Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх тухай” хуулийг баталж, холбооны бүх шүүхийн дэргэд маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх ажиллагааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх болжээ. Энэ хөтөлбөрийн цөм нь эвлэрүүлэн зуучлал юм. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хөтөлбөрөөс гадна эвлэрүүлэн зуучлалын бусад хэлбэрийг холбооны засгийн газар, үеийн ерөнхийлөгчид дэмжиж иржээ. Үүний үр дүнд 1994 онд АНУ-ын шуудан үйлчилгээний компани ажлын байрны маргааныг шийдвэрлэх зорилгоор эвлэрүүлэн зуучлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь улсдаа нэр хүндтэй загвар хөтөлбөр болоод байна.³

¹ Penny Brooker, *Mediation Law: Journey Through Institutionalism to Juridification* (Routledge, 2013), 10.

² S. Goldberg, E. Green, and F. Sander, *Dispute Resolution* (Little Brown and Company, 1985), 92; Hazel Genn and Hazel G. Genn, *Judging Civil Justice* (Cambridge University Press, 2010).

³ Amsler (formerly Bingham) and Lisa Blomgren, *Why Suppose? Let's Find Out: A Public Policy Research Program on Dispute Resolution*, SSRN Scholarly Paper (Rochester, NY: Social Science Research Network, April 30, 2001), <http://>

¹ Nancy A. Welsh, “Making Deals in Court-Connected Mediation: What’s Justice Got to Do With It?,” *Washington University Law Review* 79, no. 3 (January 1, 2001): 20.

² Clark, *Lawyers and Mediation*, 5.

³ G. Dixon and E. Carroll, “ADR Development in London,” *International Construction Law Review* 7 (1990); E. Carroll, “Are We Ready for ADR in Europe?,” *International Financial Law Review* 8, no. 12 (1989).

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа эрхэлдэг хувийн секторын мэргэжлийн байгууллага, холбоод эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа явуулах болсноор АНУ-ын өнцөг булан бүрт түгэн дэлгэрч хамрах хүрээ нь өргөжив. Эдүгээ бараг АНУ-ын бараг бүх хуулийн сургуулийн сургалтын хөтөлбөрт “эвлэрүүлэн зуучлал” хичээлийг тусгаж, эрх зүйн боловсролын салшгүй хэсэг¹ болсныг хүлээн зөвшөөрөх болжээ.

Франц улсын туршлага

Европын улсуудаас хамгийн түрүүнд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэсэн улсын тоонд Франц улс орно.² 1980-д оноос тус улсад хөгжиж эхэлсэн энэ салбар эдүгээ бизнес, гэр бүл, ажлын байрны маргаан зэрэг өргөн хүрээг хамарсан төрөл бүрийн маргааныг шийдвэрлэх арга зам болон хөгжжээ. Ялангуяа гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа илүү хөгжсөн нь гэр бүл салалтын дараа үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд эцэг эх нь хамтран зүтгэдэг Францын уламжлалтай холбоотой.³ Шүүгч гэр бүлийн холбогдолтой маргааныг талуудын зөвшөөрлийг авсны үндсэн дээр эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлж болохоор хуулиар зохицуулсан байна.⁴

Мөн 2002 оны хуулиар гэр бүлийн холбогдолтой тодорхой маргааныг эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд шилжүүлэх эрхийг шүүгчид олгожээ. Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлагч нь тусгай сургалтанд хамрагдаж диплом авсан байхыг шаарддаг байна. Гэр бүлийн холбогдолтой маргаанаас бусад чиглэлээр эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчинг

бүрдүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд ахиц гарч¹ Европын Эвлэрүүлэн Зуучлалын Зааварчилгааг дагаж мөрдөх тухай хууль саяхан баталсан байна.

Богино хугацааны үр дагавар

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнгээр зуучлалын үйл ажиллагааны ач холбогдол, үр нөлөөг үнэлдэг.² Зуучлалын үр дүнд үнэлгээ өгөх нь ач холбогдолтой боловч амаргүй ажил байдаг. Анхлан АНУ-д хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхэд хэрэглэгдэж байсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа өнөөдөр нийгэмд олон үүрэг гүйцэтгэж болжээ. Тухайлбал, зуучлал нь иргэдийн эрхийг хамгаалах, шударга ёсыг тогтооход чухал үүрэг гүйцэтгэх болсноос гадна шүүхийн үр нөлөөг улам дээшлүүлэхэд дэмжлэг болж байна.³

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь маргааныг шийдвэрлэх арга замыг боловсронгуй болгох боломжийг олгоно. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд олон хүчин зүйл нөлөөлдөг. Тухайлбал, зуучлагчийн мэдлэг чадвар, туршлага, зан ааш, онцлог шинж чанарууд нь эвлэрүүлэн зуучлалын богино болон урт хугацааны үр дүнд нөлөөлдөг байна. Өөрөөр хэлбэл, зуучлагч нь идэвхтэй оролцох, шударга зан төлөв, төвийг сахисан байр суурьтай байх, талуудын тэгш эрхийг хангасан байдлаар зуучлалыг явуулах үүрэг хүлээдэг.

Маргааныг шударга шийдвэрлэсэн эсэх, шударга ёсны талаарх ойлголт нь нэмэгдсэн эсэх, эвлэрүүлэн зуучлалын аргаар маргаанаа шийдвэрлэсэндээ сэтгэл

¹ Julie Macfarlane, “Culture Change - A Tale of Two Cities and Mandatory Court-Connected Mediation,” *Journal of Dispute Resolution* 2002 (2002): 241.

² Deborah Macfarlane, “Family Mediation in France,” *Journal of Family Studies* 10, no. 1 (April 2004): 97.

³ *ibid.*

¹⁰⁷ Энэ хуулийн зохицуулалт нь зөвхөн гэр бүлийн холбогдолтой маргаан төдий бус бусад төрлийн иргэний маргаанд хамаарах зохицуулалт юм. *Франц Улсын 95-125-р Хууль*, 21-р Эцсийн, n.d.

¹ Sassier M. *Arguments and Proposals for a Statute of Family Mediation in France* (Ministry of Family, Childhood and Handicapped Persons, Paris, 2001).

² Karen Grover Duffy, James W. Grosch, and Paul V. Olczak, *Community Mediation: A Handbook for Practitioners and Researchers* (Guilford Press, 1991), 21-34.

³ Roman Tomasic and Malcolm Feeley, *Neighborhood Justice: Assessment of an Emerging Idea* (Longman, 1982), 194-196.

хангалуун байгаа эсэх,¹ зуучлагчдаа сэтгэл хангалуун байгаа эсэх,² зуучлалын үр дүнд сэтгэл хангалуун байгаа эсэх³ болон гаргасан шийдвэрээ биелүүлэх талаар,⁴ эвлэрлийн гэрээний тухай,⁵ шүүхийн тогтолцоонд үзүүлэх үр нөлөө, зардлын талаарх⁶ гэх мэт эрдэмтдийн хийсэн олон судалгаагаар эвлэрүүлэн зуучлал нь богино хугацаанд эерэг үр нөлөөтэй байгаа нь батлагддаг. Жишээ нь: 2007 онд Шинэ Зеландад явуулсан судалгаагаар нийт 257 гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучилснаас 87 хувь нь маргаантай байсан бүх асуудлаар болон зарим асуудлаар тохиролцоонд хүрсэн бөгөөд оролцогчдын гуравны хоёр нь эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна.⁷

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа амжилттай болох эсэх нь маргагч талуудын хоорондын харилцаа, тухайн хэрэг маргааны онцлог зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Хэрэг маргааны нөхцөлөөс хамаарч маргагч талуудын хоорондын харилцаа шийдэлд хүрэхэд нөлөө үзүүлдэг болох нь судалгаагаар нотлогджээ. Талууд ямар нэг хэлбэрээр хоорондоо харилцаатай байгаа нь маргааныг шийдвэрлэхэд

эерэгээр нөлөөлдөг¹ бол гэр бүлийн гишүүд, хөршүүд, найз нөхдийн хооронд үүссэн маргаан нь бизнесийн харилцаатай холбоотой маргааныг бодвол эвлэрэх магадлал илүү өндөр байдаг байна.² Гэвч маргагч талууд ямар харилцаатай байх нь эвлэрлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нөлөө үзүүлдэггүй³ бөгөөд талуудын хоорондын маргааны агуулга болон зөрчилдөөн нь ноцтой эсэхээс зуучлалын үр дагавар ихээхэн хамаардаг байна. Ялангуяа, талууд урьд нь шүүх болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож байсан нь зэрэг нь зуучлалын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна.⁴

Төлбөр нэхэмжилсэн маргаан хийгээд бизнесийн харилцаатай холбоотой маргааны зуучлал ихэвчлэн амжилттай болдог бол замын осолтой холбоотой маргааны хувьд зуучлал голдуу амжилт муутай болдог байна. Маргалдагч талуудын онцлог, нийгмийн статус, хүйс, боловсрол, орлого зэрэг нь зуучлалын богино хугацааны үр дагаварт төдийлөн нөлөө үзүүлдэггүй нь судалгаагаар тогтоогджээ.⁵

Урт хугацааны үр дагавар

Эвлэрүүлэн зуучлалын урт хугацааны үр дүнг хоёр шалгуураар үнэлэх саналыг эрдэмтэд тавьдаг.⁶ Эхний шалгуур нь маргагч талуудын итгэл үнэмшил ба хандлагатай холбоотой бол удаах шалгуур нь талуудын тохиролцоо, гэрээний үүргээ биелүүлэхтэй холбоотой. Үйлчлүүлэгчийн

¹ R.B. Coates and J. Gehm, "An Empirical Assessment," in *Mediation and Criminal Justice: Victims, Offenders, and Community*, ed. Martin Wright and Burt Galaway (Sage Publications, 1989).

² P.J.D. Camevale, L.L. Putnam, and K.M. O'Connor, "Mediator Behavior and Effectiveness in Community Mediation," in *Community Mediation: A Handbook for Practitioners and Researchers*, ed. Karen Grover Duffy, James W. Grosch, and Paul V. Olczak (Guilford Press, 1991), 119-136.

³ Howard H. Irving and Michael Benjamin, "An Evaluation of Process and Outcome in a Private Family Mediation Service," *Mediation Quarterly* 10, no. 1 (1992): 43, doi:10.1002/crq.3900100105.

⁴ Coates and Gehm, "An Empirical Assessment."

⁵ Kenneth Kressel et al., "A Typology of Divorcing Couples: Implications for Mediation and the Divorce Process," *Family Process* 19, no. 2 (1980): 101-116, doi:10.1111/j.1545-5300.1980.00101.x.

⁶ H. Irving Howard and Benjamin Michael, "Family Mediation," *SAGE*, 62, accessed February 17, 2014, <http://www.sagepub.com/books/Book4932?prodId=Book4932>.

⁷ "7 Outcomes — Ministry of Justice, New Zealand," accessed February 17, 2014, <http://www.justice.govt.nz/publications/global-publications/1/family-mediation-evaluation-of-the-pilot-april-2007/7-outcomes>.

¹ Raymond A. Whiting, "Family Disputes, Nonfamily Disputes, and Mediation Success," *Mediation Quarterly* 11, no. 3 (1994): 247-260, doi:10.1002/crq.3900110305.

² Royer F. Cook, Janice A. Roehl, and David I. Sheppard, *Neighborhood Justice Centers Field Test: Final Evaluation Report* (U.S. Department of Justice, National Institute of Justice, Office of Program Evaluation, 1980).

³ Ibid.; Whiting, "Family Disputes, Nonfamily Disputes, and Mediation Success."

⁴ Irving and Benjamin, "An Evaluation of Process and Outcome in a Private Family Mediation Service."

⁵ Elizabeth Ellen Gordon Stevens H. Clarke, "Public Sponsorship of Private Settling: Court-Ordered Civil Case Mediation," *Justice System Journal - JUSTICE SYST J* 19, no. 3 (1997): 311-339.

⁶ Margaret S. Herrman, *The Blackwell Handbook of Mediation: Bridging Theory, Research, and Practice* (John Wiley & Sons, 2009), 53.

итгэл үнэмшил, хандлага, сэтгэл ханамж зэрэг нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг үнэлж, дүгнэх гол үндэс болдог тул эвлэрүүлэн зуучлал амжилттай болсноос хойш тодорхой хугацааны дараа хийсэн судалгаа цөөнгүй байна.¹ Хандлагатай холбогдох судалгаанд эвлэрүүлэн зуучлалын үйл явц шударга болсон эсэх, зуучлалын үр дүнд сэтгэл ханамжтай байгаа эсэх, зуучлагчийн эрх мэдлийн талаар асуултууд орсон байх ба оролцогчдын дийлэнх хувь нь сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна. Эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурснаас хойш маргагч талуудын хоорондын харилцаанд эерэг сөрөг үр дагавар гарсан эсэхэд хийсэн судалгаагаар гэр бүл, эцэг эх, хүүхдийн харилцаатай холбоотой зуучлалын хувьд талуудын харилцаа сайжирсан тохиолдол нийтлэг байгаа нь харагддаг.²

Зуучлалаар хэлэлцэж тохиролцсон зүйлс болон эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болсон эсэхийг тогтоож, үр дүнг илтгэдэг үндсэн шалгуур юм.³ Хэрэв талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол нөгөө тал нь шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрх ихэнх улсад нээлттэй байдаг. Иймд эвлэрүүлэн зуучлалын урт хугацааны үр дагаварыг үнэлэхийн тулд

¹²⁴ Зуучлалаас хойш 12 сарын дараа хийсэн судалгаа Michael L. Bridenback, *The Citizen Dispute Settlement Process in Florida: A Comprehensive Assessment* (Office of the State Courts Administrator], n.d.); Эвлэрлийн гэрээ шударга болсон эсэх, зуучлагч шударга, төвийг сахиж чадсан эсэх зэрэг асуудлаар 3 сарын дараа авсан судалгаа Michael R. Van Slyck, Marilyn Stern, and Lori Moore Newland, "Parent-Child Mediation: An Empirical Assessment," *Mediation Quarterly* 10, no. 1 (1992): 75-88, doi:10.1002/crq.3900100107; Зуучлагч аль нэг талыг барьсан, хэлэлцүүлэгт хэрхэн оролцож байсан тухай судалгаа Nina R. Meierding, "Does Mediation Work? A Survey of Long-Term Satisfaction and Durability Rates for Privately Mediated Agreements," *Mediation Quarterly* 11, no. 2 (1993): 157-170, doi:10.1002/crq.3900110206.

² Carnevale, Putnam, and O'Connor, "Mediator Behavior and Effectiveness in Community Mediation."

³ Juan B. Kelly, "A Decade of Divorce Mediation Research," *Family Court Review* 34, no. 3 (1996): 373-385, doi:10.1111/j.174-1617.1996.tb00427.x.

шүүхийн мэдээлэлтэй танилцах замаар талууд шүүхэд хандсан эсэхийг олж мэдэж болно.¹

Эвлэрүүлэн зуучлал амжилттай болсноор талууд эвлэрсэн тохиолдолд тодорхой эрх зүйн үр дагавар үүсэн боломжтой. Зарим тогтолцоонд маргалдагч талууд санамж бичигт гарын үсэг зурдаг бол зарим тохиолдолд эвлэрлийн гэрээ байгуулж, түүнийг нь шүүгч баталгаажуулдаг. Зарим төрлийн маргааныг шүүхэд хянан шийдвэрлэхийн өмнө эвлэрүүлэн зуучлах ажиллагаа заавал явуулахаар хуулиар тогтоож өгөх нь шүүхийн ачааллыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй арга болохыг Францын жишээнээс харж болно.

Эвлэрүүлэн зуучлалын хөгжлийг дагаад үнэлгээний, зохицуулах, шийдвэр гаргах, ярилцах, өөрчлөлтийн гэх мэт эвлэрүүлэн зуучлалын тодорхой загварууд бий болсон.² Эдгээр загварууд нь маргааны төрөл, мөн чанар, оролцогчдын зан төлөв, зуучлагчийн оролцооны хэлбэр зэрэг олон хүчин зүйлээс хамааран өөрийн гэсэн давуу тал, онцлогтой байна. Эхэндээ шүүхийн тогтолцооноос гадуур сайн дурын шинжтэй байсан эвлэрүүлэн зуучлалыг уламжлалт шүүхийн тогтолцоонд холбож өгсөнөөрөө энэ салбарын хөгжилд түлхэц өгчээ. Харин эвлэрүүлэн зуучлалыг цаашид хөгжүүлэх бодлогоо тодорхойлоход эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны үр нөлөө, үн дүнд хийх богино болон урт хугацааны судалгаа ач холбогдолтой байх болно.

---000---

¹ Meierding, "Does Mediation Work?"

² Laurence Boulle and Miryana Nesić, *Mediation: Principles Process Practice* (Bloomsbury Publishing Plc, 2001), 31.

ЯПОН УЛС ДАХЬ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС БАЙХ ТУХАЙ ОНОЛЫН МАРГААН



ЖАЙКА-ийн мэргэжилтэн
J.D. Ока Хидео

1. Асуудал

Ямар үед шүүх дээр явагдсан эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр бус байх вэ?

Энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрхэн үргэлжлүүлэх вэ?

2. Эвлэрлийн хүчин төгөлдөр байдал

Монгол улсын хувьд, эвлэрүүлэн зуучлалд талууд буюу зохигчид эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрч, шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, шаардлага болон нэхэмжлэлээсээ татгалзаж болно (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26.5). Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулан, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.2, 75 зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27.2). Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тухайд, эвлэрүүлэн зуучлал амжилттай болсон

тохиолдолд түүний хүчин төгөлдөр байдал нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийн нэгэн адил хүчин төгөлдөр байна. Өөрөөр хэлбэл, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргахыг хориглох ба (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 74.4) албадан гүйцэтгэгдэнэ (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 75.6).

Япон улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлал Монголтой мөн л адил юм. Эвлэрлийн гэрээ (Японы Иргэний хуульд Эвлэрлийн гэрээний төрөл тусгагдсан байдаг) хүчин төгөлдөр болсон үеэс эвлэрлийн гэрээнд бичигдсэн асуудлаар шүүхэд дахин мэдүүлэхийг хориглох зарчимтай ба албадан гүйцэтгэгдэх шинжтэй байна.

3. Хүчин төгөлдөр бус эвлэрүүлэн зуучлал, дахь түүний үр дагавар, талуудын байр суурь

Эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр бус гэдэг нь ерөнхийдөө эвлэрлийн гэрээ нь хүчин төгөлдөр бус байх эсвэл хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон тохиолдууд юм.¹

Японы хувьд эвлэрлийн гэрээ хүчин

¹²⁹ Эвлэрлийн гэрээ (Япон) болон баталгаажуулах захирамж (Монгол) алдаатай байж болох ч энэ нь зөвхөн онцгой тохиолдол юм. Шүүхийн шийдвэртэй нэгэн адил хүчин төгөлдөр байх учиртай ч эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр бус болсон бол тухайн хэрэг дуусгавар болоогүй гэж үзэж болно. Энэ тохиолдолд эвлэрлийн гэрээ (Япон) болон баталгаажуулах захирамж дахь алдааг засаж өөрчилнө. Өөрчлөх боломжгүй тохиолдолд уулзалтын өдрийг товлож, дахин хэргийг дуусгавар болгох ажиллагааг явуулна.

төгөлдөр бус байх тохиолдол нь Хориглох шинжтэй хуулийн заалтыг зөрчсөн¹, Хүсэл зоригийн илэрхийлэл буруу байсан Эвлэрлийн гэрээн дэх үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээ цуцлагдах зэрэг нөхцөл байдалтай холбоотой

Хориглох шинжтэй заалтыг зөрчсөн тохиолдол буюу хориглох шинжтэй заалтыг зөрчсөн гэрээ нь хүчин төгөлдөр бус байна. Тиймээс эвлэрлийн гэрээ хүчингүй болж, тухайн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргахыг хориглох, албадан гүйцэтгэх зарчим үйлчлэхгүй болно.

3.1. Хүсэл зоригоо буруу илэрхийлсэн тохиолдол

Япон улсын хувьд, эрх зүйн хэлцэл дэх ямар нэг элементийн тухай төөрөгдсөн тохиолдолд тухайн хүсэл зоригийн илэрхийлэл нь хүчингүй болно. Гэвч төөрөгдсөн этгээд нь өөрийн хайхрамжгүйгээс төөрөгдсөн бол хүчин төгөлдөр бус байх талаар мэдүүлэх эрхгүй. Хууран мэхэлсэн, хүч хэрэглэхээр заналхийлж хийсэн хэлцлийн зохигч этгээд нь хүчин төгөлдөр бус гэж тооцуулах шаардлага гаргаж болно. Ийнхүү хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон бол анхнаасаа хүчин төгөлдөр бус болно.

Хүсэл зоригоо буруу илэрхийлсний улмаас хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон тохиолдолд эвлэрлийн гэрээ мөн адил хүчин төгөлдөр бус болж, Монголын хувьд тухайн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж ч мөн адил хүчин төгөлдөр бус болно. Тиймээс тухайн асуудлаар шүүхэд нэхэмжилж болох ба албадан гүйцэтгэл явагдахгүй.

Эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр бус болох тул талууд Эвлэрүүлэн зуучлалыг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах гомдлын шаардлага гаргах, Эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон гэж үзэн уулзалтын өдрийг дахин товлох хүсэлт гаргаж болно.

¹⁰ Монголын хувьд гуравдагч этгээдийн эрх ашиг хөндөгдөх тохиолдол үүнд багтна.

Эдгээр тайлбаруудын тухайд эрх зүйн тогтвортой байдал алдагдах бус уу? гэсэн асуудал тавигддаг. Баталгаажуулах шийдвэртэй адил гэж үзвэл хянан шийдвэрлэх ажиллагаагаар хүчин төгөлдөр бус гэж тооцогдоогүй л бол эвлэрлийн гэрээнд бичигдсэн зүйлсийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргахыг хориглох ба хэрэв сайн дураар биелүүлээгүй бол албадан гүйцэтгэнэ гэсэн үг. Энэ тохиолдолд зөвхөн "талууд хүсэл зоригоо буруу илэрхийлсэн" гэсэн үндэслэлээр хүчин төгөлдөр бус болох уу. Япон улсын шүүхийн шийдвэрээс харахад эвлэрлийн гэрээ нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр байх үндэслэл нь талуудын хүсэл зориг байна гэсэн байр суурьтай байдаг. Тиймээс талуудын хүсэл зоригийн илэрхийлэл буруу байсан гэсэн үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцохоос өөр аргагүй гэж үздэг байна.

Мөн хүсэл зоригийн илэрхийлэл буруу байсан гэсэн үндэслэлээр хүчин төгөлдөр бус байх тохиолдолд талууд төөрөгдсөн нь эвлэрүүлэн зуучлагчийн үйлдлээс болж үүссэн бол хэрхэх вэ, мөн эвлэрүүлэн зуучлагч талуудыг заналхийлсэн тохиолдолд хэрхэх вэ гэсэн асуудлууд гардаг. Эдгээр нь Иргэний хуулийн заалттай ихээхэн хамааралтай боловч тухайн хэргээс хамааран хүчин төгөлдөр бусад тооцох шаардлагыг зөвшөөрөх тохиолдол ч бий.

3.2. Эвлэрлийн гэрээний үүрэг биелүүлээгүй гэсэн үндэслэлээр цуцлагдсан тохиолдол

Япон улсын хувьд гэрээн дэх үүргээ зөрчсөн тохиолдолд шаардах эрх бүхний этгээд нь тодорхой хугацаа тогтоон үүргийн гүйцэтгэлийг шаардан, тэр хугацаан дотор гүйцэтгээгүй бол гэрээг цуцалж болно. Мөн үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон бол үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэхгүйгээр цуцалж болно. Цуцлах эрхийг хэрэгжүүлснээр гэрээ анхнаасаа "байгуулагдаагүй" болж¹, анхны

¹¹ Шүүхийн шийдвэр, дийлэнхээр дэмжигдсэн онолын тайлбарт: Цуцлах эрхийг хэрэгжүүлэхэд гэрээ нь хийсэн үсэсээ цуцлагдаж, үүний үр дүнд анхны байдал

байдалд буцаан оруулахыг шаардах эрх үүснэ. Шүүхийн шийдвэр, дийлэнхээр дэмжигдсэн онолын тайлбарт, хэрэв гэрээ цуцлагдсан бол анхнаасаа гэрээ байгуулагдаагүйд тооцогдно.

Энэ тохиолдолд, эвлэрлийн гэрээг баталгаажуулах үед эвлэрлийн гэрээнд хүчин төгөлдөр бус болох нөхцөл байхгүй. Үүний дараа шинээр үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан эвлэрүүлэн зуучлалын үр дагавар өөрчлөгдөх эсэх нь маргаантай асуудал болно.

Япон улсын хувьд, эвлэрүүлэн зуучлал биш, харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрсэн тохиолдолд эвлэрсний дараа үүрэг биелүүлээгүйгээс гэрээ цуцлагдсан бол дахин шинээр шүүхэд хэрэг үүсгэн маргасан ч, нэг асуудлаар адил шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргасанд тооцогдохгүй” гэж тогтоосон Дээд шүүхийн шийдвэр бий.¹

Шүүхийн шийдвэрт, хэдий гэрээг цуцалсан ч зөвхөн тухайн эвлэрлийн агуулга болох хувийн эрх зүйн эрхийн харилцаа дуусгавар болох ба эвлэрлээр нэгэнт дуусгавар болсон өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сэргэхгүй гэж үзсэн. Цуцлах эрхийг хэрэгжүүлснээс үүссэн маргаан нь өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас тусдаа маргаан бөгөөд, дараагийн маргааны тухай нэхэмжлэл гаргасан нэг асуудлаар шүүхэд

дахин нэхэмжлэл гаргахыг хориглосон зарчимд харшлахгүй.¹

Дээрх тохиолдолд, өмнөх эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр байх учир талууд үүнд үндэслэн шинээр нэхэмжлэл гаргаж болно гэсэн үг.²

4. Дүгнэлт

Эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр бус байх тухай Япон улсын онолын тайлбаруудыг ерөнхийд нь авч үзлээ. Хэлбэр тус бүрт эвлэрүүлэн зуучлалын хүчин төгөлдөр байдлын тухай зохицуулалт нь ялгаатай байгааг анхаарах хэрэгтэй.

Монголын хувьд, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүгч түүнийг баталгаажуулдаг гэдгээрээ манай улсын тогтолцооноос ялгаатай. Гэвч Японы хувьд, эвлэрэл нь шүүгчийн явуулах ажиллагаа юм. Мөн эвлэрүүлэн зуучлалын тухайд ч ажиллагаа явуулах бүрэлдэхүүнд шүүгч оролцдог. Тиймээс хоёр улсын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны ерөнхий хэлбэр төсөөтэй юм.³

---o0o---

¹² Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрлийн тухайд шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал нь эвлэрсний дараа тодорхой үндэслэлд тулгуурлан гэрээг цуцлах эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй. Тиймээс эвлэрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс эвлэрлийн гэрээг цуцлаж болох нь маргаангүй юм. Гэвч нийхүү цуцласнаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ч дуусгавар болох эсэх нь маргаантай асуудал юм.

¹³ Өмнөх хэргийн хувьд, нэг асуудлаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргахыг хориглох зарчим хэвээр үйлчилнэ.

¹⁴ Өмнөх эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр учир эвлэрүүлэн зуучлалын хүчин төгөлдөр бус гэж тооцуулах нэхэмжлэл гаргах, эвлэрүүлэн зуучлал амжилгүй болсоныг үндэслэн дахин эвлэрүүлэн зуучлах ажиллааны уулзалт явуулах хүсэлт гарах ёсгүй.

¹⁵ Эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотойгоор эвлэрэх, шүүгч талуудыг эвлэрүүлэн захирамж гаргах хоёрын хоорондын харилцан хамаарлыг илүү нухацтай судлаж үзэх хэрэгтэй гэж бодож байна.

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛ*

/Бодлогын судалгааны товч тайлан/

УДИРТГАЛ

Интернэт дэх аливаа мэдээллийг хүүхдийн сайн сайхны төлөө хязгаарлах, зохицуулах асуудал нь мэдээллийн эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөө зэрэг олон улсын хэмжээнд баталгаажсан хүний суурь эрхийг хөндөж байдаг учраас тодорхой байдлаар зохицуулахад хүндрэлтэй асуудал юм. Иймд энэхүү судалгааг өнөөгийн манай холбогдох хууль тогтоомжийг судлан үгүйлэгдэж буй бодлого, зохицуулалтыг тодруулах, энэ хүрэн дэх олон улсын, бүс нутгийн болон гадаад улсуудын сайн туршлагыг судалж улмаар мэдээллийн эрх чөлөөг хангах болон цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг хэрхэн тэнцвэртэй байдлаар үр дүнтэй авч хэрэгжүүлэх хүрээнд тодорхой санал, зөвлөмж боловсруулах зорилготой гүйцэтгэсэн болно. Судалгааны ажил цахим орчинд хүүхдийн эрхэд халдсан нийтлэг зөрчил, үүнтэй тэмцэхийн тулд хууль тогтоомжийн хүрээнд болон дэвшилтэт техник, технологийг ашиглан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, улс орны холбогдох хөтөлбөр, бодлого, цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага, агуулгыг зохицуулах хүрээ зэрэг асуудлуудын хүрээнд хийгдсэн юм.

Ингэхдээ судалгааг үр дүнтэй болгохын тулд өөрийн орны зохицуулалтыг судлахаас гадна Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын “Цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах нь” хэмээх судалгаанд улс орны авч хэрэгжүүлж буй арга хэмжээний онцлогийг нь харгалзан гурван төрөл болгон ангилсны ангилал тус бүрээс

нэг орон төлөөлөл болгон судалсан болно.¹ Дээрх гурван ангиллын нэгдүгээрт цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн хуульчилсан хэм хэмжээ тогтоохын зэрэгцээ техник технологийн дэвшлийг ашиглан зохицуулалтыг хэрэгжүүлж буй улсын төлөөлөл болгон Япон Улсын; хоёрдугаарт салбарын өөрийн зохицуулалт, төрийн, олон нийтийн, иргэний нийгмийн төлөөллийг хамруулан хамтын зохицуулалтыг хэрэгжүүлж буй АНУ-ын; гуравдугаарт тодорхой нэг зохицуулах арга барилыг хэрэгжүүлэх гэж туйлшрахгүйгээр бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлж буй улсын төлөөлөл болгон Европын Холбоо үүн дотроо Их Британийн зохицуулалтыг тусгайлан судалалаа.

II. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Монгол Улс дахь цахим орчинд хүүхдийг хамгаалах эрх зүйн зохицуулалт

Юуны түрүүнд манай улсад цахим орчинд хүүхдэд ямар аюул нүүрлэж буйг товчхон дурдъя. Ерөнхий сайдын тэргүүлсэн Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2010 оны 1 дүгээр тогтоолын хавсралт болох

¹ Organization for economic co-operation and development (OECD), *Recommendation of the OECD Council, Report on risks faced by children online and policies to protect them*, 2011. Энэхүү судалгаанд Эдийн Засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнууд болон АНУ-ын цахим орчинд хүүхдэд учирч буй аюул болон хүүхдийг хамгаалахад чиглэсэн бодлогуудыг судалсан бөгөөд бид энэхүү судалгааг гүйцэтгэхдээ энэхүү судалгааг ашигласан болно.

* Судалгааны ажлыг ХЗҮХ-ийн Судалгааны төв нь “Цахим эрх зүй” номын зохиогч Б.Галбаатартай хамтран хийж гүйцэтгэв.

“Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх (2010-2015) стратеги”-т дурдсанаар Монгол Улсын хэмжээнд дараах төрөл, хэлбэрийн үйлдлээр зонхилон хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих явдал илэрч байна. Үүнд:

- Хүүхэд эрүүл мэнд, боловсрол, халамж, бүртгэл, эрх зүйн зэрэг нийгмийн суурь үйлчилгээний гадна үлдэх, хараа хяналтгүй байх, тэдний үзэл бодлыг үл хүндэтгэх, хайхрамжгүй хандах, алагчлах үйлдлээр хүүхдийг үл хайхрах;
- Хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, бэлгийн бойжилтод зүй бус хандах, шийтгэх, дарамтлах, хурьцах үйлдлээр хүүхдийг хүчирхийлэх;
- Хүүхдийн биеийг үнэлүүлэх, хөдөлмөрлүүлэх, худалдаалах, хуурч ашиглах, золиослох үйлдлээр хүүхдийг мөлжих.

Ингэж хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих явдал өнөө цагт Монгол Улсын мэдээллийн технологийн хэрэглээтэй салшгүй холбоотой болж байна. Тодруулбал, ЗГ-ын тохируулагч агентлаг болох МТШХХГ-ын бэлтгэн гаргасан “Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын хөгжлийн цагаан ном-2013”-т дурдсанаар интернэтийн бүртгэлтэй хэрэглэгчид 641 мянга болж өмнөх оноос 40%-иар өссөн бөгөөд Монгол Улсын 2010 оны хүн амын тооллогын дүнгээр хүн амын 30,6% нь интернэт ашиглаж байгаа ба хэрэглэгчдийн тоо 709.6 мянга болсон дүн гарчээ. Мөн улсын хэмжээнд 30 Гб/с буюу 2009 оныхоос 10 дахин нэмэгдсэн өндөр хурдаар дэлхийн мэдээллийн сүлжээнд холбогдсоноор Монгол Улсад гэр бүл, хүүхдүүдийн интернэт хэрэглээ өсөн нэмэгдэх болж интернэт дэх төрөл бүрийн харилцаанд оролцсоноор цахим орчин буюу интернэтэд хүүхдийг хамгаалах, зохисгүй нөлөөллөөс сэргийлэх шаардлага тулгарсаар байна.

БСШУЯ-ны Мэргэжлийн боловсролын газрын захиалгаар МУИС-ийн НШУС-ийн Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны тэнхимийн судалгааны багийн 2011 онд гүйцэтгэсэн “Мэдээллийн хэрэгслийн хүүхдийн хүмүүжилд үзүүлэх нөлөө” төслийн судалгааны тайлангийн 39 дэх талд Монгол Улсад хамгийн өргөн хандалттай вэб сайтуудын хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх сөрөг нөлөөг дараах 3 төрөлд ангилжээ. Үүнд:

1. Садар самуунтай тэмцэх тухай хуулийг зөрчин үйл ажиллагаа явуулдаг вэб сайтууд аль ч насны хүүхдүүд шууд нэвтэрхүйц садар самуун агуулгыг нээлттэйгээр дэлгэн тавьсан байдаг. Цаашид энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг вэб сайтад хүүхдүүд хандах боломж, нөхцөлийг хязгаарлах шаардлагатай;
2. Шар мэдээ хөөцөлддөг вэб сайтууд хүүхдийн хүмүүжлийн болоод нийгмийн хариуцлагын асуудлыг огт харгалздаггүй бөгөөд нийтлэлийн тодорхой бодлогогүй юм. Цаашид мэдээллийн агуулгын зааг, шалгуурыг тодорхой болгож хүүхдүүдэд сонгон үзүүлэхгүй бол тэдгээрийн оюун санаа, хүмүүжил, нийгмийн амьдралд хортой юм;
3. Нийгэмшлийн вэб сайтуудад хүүхдүүд өөрийн мэдээллийн буланг үүсгэж, хувийн мэдээллээ оруулдаг бөгөөд энэ нь тэдний аюулгүй байдалд тодорхой байдлаар аюул, занал учруулдаг. Мөн зарын вэб сайтуудад төрөл бүрийн танилцах зарыг тодорхой шалгуургүйгээр байрлуулах нь биеэ үнэлэх, садар самуунд

уруу татагдах эерэг эрсдэлийг үүсгэдэг.

Дээр дурдсан сөрөг нөлөөг багасгах буюу цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалахын тулд эрх зүйн болон зохион байгуулалтын үе шаттай арга хэмжээ хэрэгжүүлж, хэвшүүлэх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс цахим орчинд хүүхдийг хамгаалах эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх шаардлага тулгарч байна.

Иймд цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалтын талаарх өнөөгийн Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын түвшинг хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомжийг түүвэрлэн судалж тодорхойлох нь нэн чухал.

- *Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль*

1998 оны 08 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд энэ талаар тодорхойлоогүй бөгөөд Ерөнхийлөгчийн тамгын газраас санаачлан боловсруулж, УИХ-аар хэлэлцсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 3.1.1-т зааснаар "хэвлэл, мэдээллийн хэрэгсэл гэж олон нийтэд редакторласан мэдээлэл тогтмол түгээдэг хэвлэл, радио, телевиз, цахим хуудас" юм. Эндээс Монгол Улсад "цахим хуудас"-ыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн гэж цээх хандлагатай болох нь харагдаж байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн 3.1-т зааснаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй. 3.2-т зааснаар Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.

- *Зар сурталчилгааны тухай хууль*

Цахим орчин буюу вэб сайтад зар сурталчилгаа байршуулах, түгээх нь энгийн бөгөөд нийтлэг үзэгдэл болсон. 2002 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Зар сурталчилгааны тухай хуулийн 6-р зүйлийн 6.5-д зааснаар зар сурталчилгаа бүтээх, түгээхэд дараах зүйлийг хориглоно:

- айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;
- хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчлах.

Хүүхдүүдийн хувьд вэб сайтаар чөлөөтэй зорчих бололцоотой байгаа энэ үед зар сурталчилгааны хэлбэртэй хүчирхийлэл, садар самуун агуулгатай байнга тулгарч, түүнийг унших, үзэх зэргээр хэрэглэх орчин нэгэнт бүрэлдсэн нь дээрхээс харагдаж байна.

- *Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль*

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5.1-т зааснаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр /шинэчилсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн дагуу интернэтээр/ садар самууныг сурталчлахыг хориглоно. Мөн 8.1.3-т зааснаар 18 насанд хүрээгүй хүнд эротик кино, дүрс бичлэг, бусад үзвэрийг үзүүлэхийг хориглоно.

- *Тамхины хяналтын тухай хууль /шинэчилсэн найруулга/*

2005 оны 07-р сарын 01-ний өдөр батлагдсан Тамхины хяналтын тухай хуулийн 8.1.1-т зааснаар тамхи болон тамхины үйлдвэрийн нэр, тэмдэг, түүнтэй холбоотой зураг ашиглах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл /шинэчилсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн дагуу интернэтээр/-ээр сурталчлахыг хориглоно.

- *Эрцүгийн хууль*

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 25-р бүлэгт компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг хуульчилсан. Тодруулбал, ЭХ-ийн 226-229 дүгээр зүйлд заасан үйлдлийг гэмт хэрэг болгон хуульчлах замаар хүүхдийн компьютерийн мэдээллийн аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалсан байна.

- *Эрцүгийн байцаан шийтгэх хууль*

2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 4-р бүлэгт зааснаар Эрүүгийн хуулийн 25-р бүлэгт заасан Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг нь хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт хамаарах тул энэхүү гэмт хэрэгт Цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулна.

- *"Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем"-ийн тухай*

Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай Засгийн газрын 2013 оны 1 дүгээр тогтоолын 2-т Монгол Улсад мэдээ, мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим хуудсанд тавигдах шаардлагыг тодорхойлох, зохицуулах журмыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ХХЗХ-нд даалгасан. Энэ заалт нь мэдээллийн цахим хуудаснуудын агуулгыг хууль тогтоомжид нийцүүлэх, хууль бус агуулга нэвтрүүлэхээс сэргийлэх

ач холбогдолтой тул хүүхэд, өсвөр үеийг нийтлэл, нэвтрүүлгийн бодлого бүхий цахим орчинд байх, хамгаалагдахад нөлөөлөх юм.

- *Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам*

ХХЗХ-ны 2013 оны 05 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан тус журмаар вэб сайтуудад иргэдийн бичсэн сэтгэгдлийг зохицуулах бөгөөд вэб сайтууд нь хэрэглэгчийн үүсгэх контент, түүнтэй холбоотой асуудлуудыг зохицуулах үүрэг хүлээнэ. Энэ хүрээнд шүүлтүүр программын асуудал тусгагдсан бөгөөд ямар төрлийн шүүлтүүрийг хэрхэн хэрэглэх асуудлыг уян хатан зохицуулснаараа онцлогтой.¹

- *Аж ахуйн цйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль*

2010 оны 12-р сард Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.3-д Мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр "Контентийн" тусгай зөвшөөрөл олгох гэж нэмэгдсэн нь тоон контентийн талаар зохицуулалт хийх үндэслэл болж байна.

- *Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага*

ХХЗХ-ны 2011 оны 08 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага" гэх журам нь харилцаа холбооны сүлжээгээр контентийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Тус журмын 4-р зүйлд зааснаар контентийг бүтээж, түгээх, сурталчлахад Монгол Улсын холбогдох хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг мөрдлөг болгох ба 15 төрлийн болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн контент бүтээх, түгээхийг хориглосон.

¹ <http://galbaatar.blogspot.com/2011/02/blog-post.html>

Энэхүү журам нь цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Гэхдээ “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”-ыг хэрэгжүүлэхийн тулд Харилцаа холбооны зохицуулах хорооны зүгээс холбогдох бусад байгууллагыг татан оролцуулах, идэвхжүүлэхгүйгээр үр дүнгүй юм.

- Цахим тоглоомын газрын цйл ажиллагааг зохицуулах журам

Засгийн газрын 2013 оны 12-р сарын 14-ний өдрийн 410 дугаар тогтоолын хавсралтаар хүүхэд, залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баталсан.

- Гэмт хэргийн тухай хуулийн төсөл¹

Хууль зүйн яамнаас 2013 оны 10-р сард УИХ-д өргөн барьсан¹ “Гэмт хэргийн тухай хуулийн төсөл”-ийн 26.1, 26.2, 26.3, 13.9, 7.3-р зүйлд цахим мэдээлэл, сүлжээ, цахим хэрэгсэлтэй холбоотойгоор хүүхдийн эрхийг цахим орчинд зөрчихөөс хамгаалах зохицуулалт тусгагдсан байна.

2.2. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа, хэрэгжүүлэгч байгууллага

Монгол Улсын хувьд “Хүүхдийн эрхийн тухай” хууль 1996 оны 6-р сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа бөгөөд энэ хууль бүх төрлийн орчинд хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад үйлчилнэ. Тус хуулиар хүүхдийн эрх, үүргийг тогтоосон төдийгүй хүүхдийг хамгаалах үүргийг дараах этгээдэд хүлээлгэсэн. Үүнд:

- Засгийн газар;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга;

- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч;
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;
- Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн төв болон орон нутгийн байгууллага;
- Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл;
- Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах олон нийтийн байгууллага.

Эндээс харахад хүүхдийг хамгаалах үүрэгтэй этгээд олон байгаа ч тэдний зүгээс цахим орчинд хүүхдийг хэрхэн хамгаалах талаарх эрх зүйн бие даасан, боловсронгуй зохицуулалт Монгол Улсад дутагдалтай байна.

Монгол Улсад цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн дараах бодлого, хөтөлбөр хэрэгжиж байна.

- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого батлах тухай;
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай;
- “Цахим монгол” үндэсний хөтөлбөр;
- Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Үндэсний хөтөлбөр батлах тухай (мэдээллийн аюулгүй байдал);

¹ <http://www.parliament.mn/laws/projects/256>

III. ОЛОН УЛСЫН ХҮРЭЭН ДЭХ САНААЧИЛГА

3.1. Цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалт

Цахим орчинд хүүхдийг хамгаалахтай холбоотой олон улсын зохицуулалтын тухайд Кибер гэмт хэрэгтэй тэмцэх Европын зөвлөлийн конвенц нь хүүхдийн порнограф гэдэгт хүүхдийг садар самуун байдлаар үзүүлсэн материалыг төдийгүй техник технологи ашиглан хүүхдийн дүр төрхтэй садар самуун дүрс бий болгох үйлдлийг хамруулах болсон ба хүүхдийн порнограф үйлдвэрлэсэн, түгээсэн, дамжуулсан зэрэг үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу шийтгэж байхаар заасан.¹

3.2. Цахим орчинд олон улсын хэмжээнд хэрэгжиж буй хүүхдийн эрхийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа

НҮБ-ын төрөлжсөн агентлаг болох Олон улсын цахилгаан холбооны байгууллага нь 2008 онд Цахим орчинд хүүхдийг хамгаалах санаачилгын (*Child Online Protection initiative* буюу COP) хүрээнд төрийн болон засгийн газар хоорондын агентлагууд /intergovernmental agencies/ хууль сахиулах байгууллагууд, харилцаа холбооны салбарын хувийн хэвшлийн байгууллагууд, ТББ-ын төлөөлөгчдөөс бүрдсэн томоохон баг бүрдүүлэн улмаар бодлого тодорхойлогч, хүүхдүүд, эцэг эхчүүд, асран хамгаалагчид, энэ салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийнхэнд зориулсан цахим

орчинд хүүхдийг хамгаалах талаарх цуврал зөвлөмж гаргасан.¹

Түүнчлэн олон улсын хэмжээнд хэд хэдэн амжилттай бодит хамтын үйл ажиллагаанууд өрнөж байна. Цахим сайт дахь хууль бус агуулгын талаар харилцан мэдээлэл өгөх, хамтран хууль сахиулах зорилгоор улс хоорондын шуурхай INHOPE сүлжээг бий болгосон.² Мөн цахим орчинд хүүхдийг хамгаалах асуудлаар сайн туршлага солилцох улс хоорондын мэдээлэл солилцох INSAFE сүлжээ бий болжээ.³ Цаашлаад Европын Холбооны санаачилгаар олон улсын хэмжээнд Дэлхийн аюулгүй интернэтийн өдрийг зарлан тэмдэглэх болсон нь олон улсын хэмжээнд цахим орчинд хүүхдийг хамгаалах асуудлыг онцгойлон анхаарч ухамсар хандлагыг дээшлүүлэхэд нэн чухал алхам болжээ. Шүүгч программ гэх мэт техник технологийн стандартыг ч олон улсын түвшинд нэгдсэн стандартад байлгах асуудлын хүрээнд төсөл хөтөлбөр хэрэгжиж байна.⁴

IV. ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА

4.1. Япон Улсын эрх зүйн зохицуулалт

4.1.1. Цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалт

¹ United Nations Children's Fund (UNICEF), *The Innocenti Research Centre, Child Safety Online, Global Challenges and Strategies*, 2012. OECD, *Recommendation of the OECD Council, Report on risks faced by children online and policies to protect them*, 2011.

² International Association of Internet Hotlines. <http://www.inhope.org/gns/home.aspx>

³ Safer Internet Centers. <http://www.saferinternet.org/>

⁴ United Nations Children's Fund (UNICEF), *The Innocenti Research Centre, Child Safety Online, Global Challenges and Strategies*, 2012. OECD, *Recommendation of the OECD Council, Report on risks faced by children online and policies to protect them*, page 41, 2011.

¹ Council of Europe Convention on Cybercrime. United Nations Children's Fund (UNICEF), *The Innocenti Research Centre, Child Safety Online, Global Challenges and Strategies*, 2012.

1. Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хууль

Сүүлийн жилүүдэд интернэт хэрэглээ нэмэгдэж, насанд хүрээгүй буюу 18 насанд хүрээгүй этгээдүүд олон нийтийн харилцаа холбооны сүлжээг ашиглах нь улам бүр нэмэгдсээр байна. Үүний улмаас олон эцэг эхчүүдэд насанд хүрээгүй этгээдийн интернэт хэрэглээтэй холбоотойгоор “сөрөг нөлөөлөл бүхий мэдээлэл олж авах, үүний улмаас гэмт хэрэгт холбогдож болзошгүй” гэх зовнил нь улам бүр сэтгэл түгшээсэн асуудал болжээ. Иймд 2008 оны 6 дугаар сарын 11-нд “Насанд хүрээгүй этгээдийн аюулгүй интернэт хэрэглээний орчинг бүрдүүлэх тухай хууль”¹ /цаашид “Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах хууль” гэх/ батлан гаргажээ. Энэхүү хуулийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Насанд хүрээгүй этгээдийн интернэтийг зохицуулах хууль нь гар утас үйлдвэрлэгч болон интернэтийн холболт үйлчилгээ үзүүлэгчтэй сөрөг нөлөөтэй мэдээллийг шүүгч программ хангамжийн үйлчилгээ үзүүлэх үүрэг зэрэг олон төрлийн зохицуулалтыг хуульчилсан.

Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хуульд насанд хүрээгүй этгээдийг амар тайван, аюулгүйгээр интернэт ашиглах орчныг бүрдүүлэх бодлоготой холбогдуулан дараах үндсэн зорилтуудыг тусгажээ:

Нэг. Насанд хүрээгүй этгээдэд өөрт нь интернэтийг зохистой ашиглах чадварыг эзэмшүүлэх;

Хоёр. Насанд хүрээгүй этгээд сөргөөр нөлөөлөх мэдээлэл олж авах боломжийг интернэт ашиглах үед аль болох бага байлгах;

¹ 青少年が安全に安心してインターネットを利用できる環境の整備等に関する法律（平成二十年六月十八日法律第七十九号）<http://law.e-gov.go.jp/html/data/H20/H20HO079.html>

Гурав. Интернэт нь өргөн тархсан онцлогтой учир иргэдэд интернэтийн зүй зохистой хэрэглээг өөрсдийн хүслээр зохицуулах чухал үүргийг ногдуулж, улс болон орон нутгаас түүнийг нь дэмжих гэсэн гурван үндсэн зарчмыг баримталдаг. Мөн улс болон орон нутгийн захиргаа; холбогдох үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч, асран хамгаалагч нарт ч дээрх хуулиар тодорхой үүргүүдийг ногдуулсан¹.

Насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээлэл /Harmful information/

Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээлэл гэдэг нь интернэт ашиглан олон нийтэд хүргэх мэдээлэл /сонсох мэдээлэл мөн хамаарна/ насанд хүрээгүй этгээдийн цогц хөгжилд илтэд сөргөөр нөлөөлөх зүйл” гэж тодорхойлсон бөгөөд тухайлбал дараах мэдээллүүд хамаарна.

Нэг. Гэмт хэрэг эсхүл Эрүүгийн хууль тогтоомжид заасан үйлдлийг шууд болон илтэд даалгах, хамтран оролцуулах, эсхүл татан оролцуулах, мөн амиа хорлоход шууд болон илтэд уруу татсан агуулга бүхий мэдээлэл;

Хоёр. Хүний бэлгийн харьцаа мөн садар самууныг илтгэсэн зураг, түүнээс гадна илтэд бэлгийн дур хүслийг өдөөсөн, сэргээсэн /stimulus/ мэдээлэл;

Гурав. Амиа хорлох, цээрлэл, хүчирхийллийн өнгө аяс бүхий зураг түүнээс гадна илтэд харгислалын агуулга бүхий мэдээлэл юм.

Дээрхийг тоймловол **нэг дэх хэсгийн мэдээлэл** бол гэмт үйлдэл болон хууль

¹⁰ “Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хууль”, 3 дугаар зүйл.

бус үйлдэлд татан оролцуулах зорилготой бохир сайт болон амиа хорлох үйлдлийг сурталчилдаг сайт, **хоёр дахь хэсгийн мэдээлэл** нь бэлгийн харьцааны талаар илэрхийлэх насанд хүрэгчдийн сайт, **гурав дахь хэсгийн мэдээлэл** нь насанд хүрээгүй этгээдүүдэд хүчирхийлэл, харгислалыг сурталчлах зорилготой мэдээллийг зохицуулах зорилготой.

Сөргөөр нөлөөлөх мэдээллийг шүүгч программ хангамж /Filtering software/

“Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах” хуульд “Насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээллийг шүүгч программ хангамжийг хөгжүүлэх болон дэлгэрүүлэх” гэж зорилгодоо дурдсан нь насанд хүрээгүй этгээдийн эрхийг хамгаалах үндсэн арга нь мэдээллийг шүүгч программ хангамж ашиглах юм.

Шүүгч программ гэдэг нь хүүхдэд үзүүлэхийг хүсэхгүй байгаа танилцах сайт, насанд хүрэгчдийн сайт, хүүхдэд сөргөөр нөлөөлөх мэдээлэл бүхий сайтыг интернэт холболт нь блоклох төхөөрөмж юм. Энэхүү шүүгч программыг дараах гурван аргаар ашигладаг.

Нэг. Хоосон жагсаалтын арга /white list/ буюу хүүхдийн хувьд аюулгүй гэж бодож байгаа сайтыг л зөвхөн нээх бөгөөд түүнээс бусад сайтыг блоклож байхаар тохируулах арга;

Хоёр. Хориглосон жагсаалтын арга /block list/ буюу танилцах сайт болон насанд хүрэгчдийн сайт гэх мэт хүүхдийн хувьд сөргөөр нөлөөлөх мэдээллийг агуулах бүхий л сайтыг блоклож байхаар тохируулах арга;

Гурав. Ашиглалтын цагийг хязгаарлах арга буюу хүүхэд нь ганцаараа шөнийн цагаар интернэт ашиглахгүй байх буюу

шөнөөс өглөө хүртэл интернэт ашиглах боломжгүй байхаар тохируулах арга юм¹.

Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хууль батлагдаж 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш 18 нас хүрээгүй этгээд нь шинээр гар утас болон PHS сүлжээгээр интернэт ашиглах тохиолдолд **заавал шүүгч программыг ашиглах ёстой** болсон бөгөөд асран хамгаалагчийн хүсэлтээр түүнийг цуцалж болно.

Хууль тогтоогчийн хүсэл ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх

Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулахад ийм төрлийн хуультай улсуудын хувьд тулгарч буй бэрхшээл нь Үндсэн хууль дахь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг зөрчиж байна гэх хандлага байдаг байна. Энэ асуудал нь Япон Улсыг мөн тойрч гараагүй бөгөөд Япон Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Цугларах, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулна” гэх заалтыг зөрчиж, хүүхдийн чөлөөтэйгээр мэдээлэл хүлээн авах, цуглуулах эрхийг хязгаарласан ноцтой зөрчил гэж үзэн Гифү мужийн шүүхэд нэхэмжлэл гаргаж² байжээ. Харин Гифү мужийн шүүхийн шүүгч Ито Үндсэн хууль зөрчөөгүй гэх шийдвэр гаргасан. Ерөнхийдөө Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хууль 2008 онд батлагдсанаас хойш даруй 6 жилийн хугацаа өнгөрч олон нийтийн болон иргэдийн хамтын ажиллагаа сайжран улмаар төр болон олон нийтийн зүгээс олон арга хэмжээг авч байгаа ч интернэтийн хэрэглээг дагасан насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээллийн хэмжээ төдийлөн ахицтайгаар буурахгүй байна. Түүнчлэн өндөр хүчин чадалтай гар утас буюу ухаалаг утас /Smart phone/,

¹ 「青少年インターネット環境整備法について」、http://www8.cao.go.jp/youth/youth-harm/seibi_law/#a2

² 最判平元・9・19型集43巻8号785項

таблет зэрэг олон төрлийн интернэтэд холбогддог бүтээгдэхүүн олширч, олон төрлийн утасгүй сүлжээгээр хүүхдүүд цахим ертөнцтэй холбогдож байна.

2. Хүүхдийн биеэ үнэлэх, хүүхдийн порно үйлдэлд хариуцлага ногдуулах болон хүүхдийг хамгаалах тухай хууль¹

1998 онд “Хүүхдийн биеэ үнэлэх, хүүхдийн порно үйлдэлд хариуцлага ногдуулах болон хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль” батлагджээ. Энэ хууль нь хүүхдийн эрхийг илтэд зөрчих садар самууныг сурталчилсан болон хүүхдийг садар самуун, биеэ үнэлэх үйлдлээс сэргийлэх, эрүүгийн хариуцлага ногдуулах, хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зорилготой. “Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай” хууль нь насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээлэл гэж юу болох, ямар арга хэмжээ авч урьдчилан сэргийлэх, насанд хүрээгүй этгээдийн аюулгүй интернэтийн орчинг бүрдүүлэх зорилготой бөгөөд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулаагүй.

3. Насанд хүрээгүй этгээдийг хамгаалах, сурган хүмүүжүүлэх журам

Япон Улсад бүх хот, тосгон, засаг захиргааны нэгжүүд “Насанд хүрээгүй этгээдийг хамгаалах, сурган хүмүүжүүлэх журам²”-тай байдаг. Хэдийгээр бүх засаг захиргааны нэгжүүд дүрэмтэй байдаг ч зохицуулж буй харилцаа нь харилцан адилгүй байдаг байна. Уг дүрэм нь 1970-аад он хүртэл насанд хүрээгүй этгээдэд худалдаж болохгүй ном, сонин, сэтгүүл

болон номын санд байршуулах ном зэрэг зүйлсийг зохицуулж байсан бөгөөд 1976 оноос автомат худалдааны машинаар борлуулах бүтээгдэхүүнд хязгаарлалт хийх¹, насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээллийг хязгаарлаж байсан. 2008 онд “Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хууль” батлагдсанаар дээрх дүрмүүд нь интернэт дэх насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээллийг хянах, интернэт кафенуудын шүүгч программ хангамжийн ажиллагаа, түүнд дэмжлэг үзүүлэх зэрэг нарийвчилсан хэрэгжилтийг зохицуулж байна.

4.1.2. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа, хэрэгжүүлэгч байгууллага

1. Насанд хүрээгүй этгээдийн аюулгүй интернэтийн хэрэглээг бий болгох бодлого ба үндсэн төлөвлөгөө

“Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хууль”-ийн хоёрдугаар бүлэгт “Үндсэн төлөвлөгөө”-ний талаар хуульчилсан бөгөөд 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Хүүхэд залуучуудын боловсролыг дэмжих хуулийн 26 дугаар зүйлд заасан Хүүхэд, залуучуудын боловсролыг дэмжих зөвлөл нь насанд хүрээгүй этгээд аюулгүйгээр интернэт ашиглах орчныг бүрдүүлэх бодлоготой холбогдсон үндсэн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх арга хэмжээг авна” гэж заасны дагуу 2009 онд Насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх

¹ 児童買春、児童ポルノに係る行為等の処罰及び児童の保護等に関する法律(平成十一年五月二十六日法律第五十二号) <http://law.e-gov.go.jp/htmldata/H11/H11HO052.html>

² 青少年保護育成条例

¹ <http://ja.wikipedia.org/wiki/%E9%9D%92%E5%B0%91%E5%B9%B4%E4%BF%9D%E8%AD%B7%E8%82%B2%E6%88%90%E6%9D%A1%E4%BE%8B>

мэдээллийн эсрэг бодлого, орчныг бүрдүүлэх зөвлөлөөс “Насанд хүрээгүй этгээдийн аюулгүй интернэтийн хэрэглээг бий болгох бодлогын үндсэн төлөвлөгөө”¹-г баталжээ. Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах хуульд зааснаар үндсэн төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгахаар заасан байна.

Нэг. Насанд хүрээгүй этгээдийн аюулгүй интернэтийн хэрэглээг бий болгох бодлогын үндсэн чиглэл;

Хоёр. Интернэтийн зохистой хэрэглээг бий болгох боловсролын болон соён гэгээрүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх бодлого;

Гурав. Насанд хүрээгүй этгээдэд сөргөөр нөлөөлөх мэдээллийг шүүгч программ хангамжийн чанарыг дээшлүүлэх, хэрэглээнд дэлгэрүүлэх бодлого;

Дөрөв. Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн зохистой хэрэглээг бий болгоход иргэд, олон нийтийн байгууллагын дэмжлэг, бодлого зэрэг юм.

2. Хэрэгжүүлэгч байгууллага

Өдөр ирэх тусам өргөжин тэлж буй интернэтээр цацагдаж буй мэдээлэл дээр нэмэгдээд гадаадын улсуудын серверээр дамжин цацагдах нэвтрүүлэг, цахим халдлага, хууль бус мэдээллийн эсрэг тэмцэх оновчтой арга нь интернэт хэрэглэгчидтэй нягт хамтран ажиллах шаардлагатай бөгөөд дараах байгууллагууд хариуцан ажилладаг байна.

2.1. Төрийн болон орон нутгийн байгууллага

Насанд хүрээгүй этгээдийн аюулгүй интернэт хэрэглээний орчныг бүрдүүлэх

үндсэнтөлөвлөгөөнд үндэслэн хэрэгжилтийг хангах ажлыг Засгийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах агентлаг, Дотоод хэргийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Эдийн засаг үйлдвэрийн яам зэрэг байгууллагууд гүйцэтгэж байна. Тухайлбал Дотоод хэргийн яам, Эдийн засаг үйлдвэрийн яамны зүгээс үйлдвэрлэгчдэд хяналт тавьж ажиллах, цагдаагийн байгууллагаас хууль бус, сөрөг нөлөөлөл бүхий мэдээлэлд хяналт тавьж ажиллах үүрэгтэй¹. Орон нутгийн байгууллагын хувьд ч муж бүр “Насанд хүрээгүй этгээдийн эрхийг хамгаалах, дээрх хуулийн хэрэгжилтийг хангах журам”-ыг баталж, мөрдүүлж байна.

2.2. ИНС-н үүрэг /Hotline center/

Мөн хууль бус мэдээлэл, сөрөг нөлөөлөл бүхий мэдээлэлд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий байгууллага нь 2006 онд байгуулагдсан Internet Hotline center /цаашид ИНС гэх/ юм. Энэхүү байгууллага нь олон улсын цахим сүлжээ болох INHOPE-н гишүүн бөгөөд Цагдаагийн ерөнхий газраас чиг үүрэг шилжүүлэн авсан олон нийтийн сангийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага юм. ИНС нь интернэт хэрэглэгчдээс хүлээн авсан мэдээлэлд үндэслэн дараах үйл ажиллагааг явуулдаг.

Нэг. Цагдаагийн байгууллагад хууль бус мэдээллийг дамжуулах;

Хоёр. Хууль бус болон сөрөг нөлөөлөл бүхий мэдээллээс урьдчилан сэргийлэх үүднээс интернэтийн үйлчилгээ үзүүлэгч болон серверийн админтай хамтран ажиллах;

¹ 「青少年に安心してインターネットを利用できるようにするための施策に関する基本的な計画」、<http://www8.cao.go.jp/youth/youth-harm/suisin/>

¹ 利用者視点を踏まえたICTサービスに係る諸問題に関する研究会2011年、「青少年に安心してインターネットを利用できる環境の整備に関する提言」・スマートフォン時代の青少年保護を目指して」p.14

Гурав. Холбогдох байгууллагуудад мэдээлэл түгээх;

Дөрөв. Шүүгч программ хангамж үйлдвэрлэгчдэд мэдээлэл хүргэх зэрэг үүргийг гүйцэтгэдэг¹.

4.2. АНУ-ын эрх зүйн зохицуулалт

4.2.1. АНУ-ын эрх зүйн зохицуулалт

Энэ улсын ардчиллын хөгжил, либерал тогтолцоо нь Холбооны түвшинд цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн хуульчилсан хэм хэмжээ шууд тогтооход тийм ч нааштайгаар нөлөөлдөггүй байх магадлалтай. Учир нь АНУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан мэдээллийн эрх чөлөөг хангахгүй, Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг зөрчиж байна гэсэн үндэслэлээр цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах ялангуяа хүүхдийг садар самуунаас хамгаалах үүднээс Холбооны хэмжээнд батлагдан гарсан томоохон хэмжээний хоёр хууль хүчингүй болсон юм. Эхнийх нь Харилцаа холбооны салбар дахь садар самуун зүйлийг зохицуулах тухай хууль (The Communications Decency Act of 1996) нөгөөх нь Хүүхдийг цахим орчинд хамгаалах тухай хууль байсан байна (The Child Online Protection Act of 1998).²

Эдгээр хуулийн дараагаар Интернет орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль (Child Internet Protection Act) гарсан юм.³ Уг хуулийн дагуу нийтийн номын сангууд, сургуулиуд нь зохисгүй материалыг шүүх программыг өөрсдийн компьютерт суурилуулан хүүхдийг порно материал, садар самуун материал гэх мэт хүүхдэд хор хөнөөлтэй материал үзэхээс сэргийлэх арга хэмжээ авахыг шаардсан ба шаардлагатай

арга хэмжээ аваагүй боловсролын байгууллагад Холбооны тусламжийн дагуу түгээдэг интернэтийн үйлчилгээг хүртэх эрхгүй болох зохицуулалттай тул санхүүгийн хувьд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах сайн механизм болсон гэж тооцогддог.

Түүнчлэн Домэйн нэр үнэн зөв байх тухай хууль (Truth in Domain Names Act) нь хууран мэхлэх, төөрөгдүүлэх байдлаар хүүхдэд хор хөнөөлтэй материал үзүүлэх нөхцөл бүрдүүлэхийг хориглосон байна. Интернет дэх хүүхдийн хувийн мэдээллийн нууцлалын асуудлыг шийдвэрлэхийн тулд АНУ-д тусгайлан Цахим ертөнцөд хүүхдийн нууцыг хамгаалах тухай хууль (Children's Online Privacy Protection Act) гаргасан бөгөөд уг хуулийн дагуу 13 нас хүртэлх хүүхдэд хандаж буй вэбсайтын оператор эсхүл 13 нас хүртэлх хүүхэд сайтад хандаж байна гэдгийг нь мэдэж байвал заавал эцэг эхийн зөвшөөрөл авах ёстой аж.¹ Гэхдээ мөн л хэрхэн хүүхэд, том хүн гэдгийг нь ялгах вэ гэдэг асуудал шийдвэрлэгдээгүй учраас энэхүү хуулийн үр дүнтэй хэрэгжилтийг хангаж чадаагүй байна.

АНУ-ын ихэнх муж улсууд "cybergrooming" буюу "насанд хүрсэн этгээд хүүхдийн итгэлийг цахим орчинд олж аван улмаар түүнтэй найз нөхдийн дотно харилцааг бий болгосны дараа хүүхдийг садар самуун үйл хэрэгт ашиглах зорилго агуулсан цахим өдөөлт" болон "cyberbullying" буюу "цахим шоглолт, зовоолт"-ыг хориглох хуулиуд гаргасан байна.²

¹ ホットライン運用ガイド <http://www.iajapan.org/hotline/center/20130329guide.pdf>

² Cheryl B. Preston, *Zoning the Internet: A New Approach to Protecting Children Online*, Brigham young university law review, 2008.

³ Federal Children's Internet Protection Act, 2000.

¹ United Nations Children's Fund (UNICEF), *The Innocenti Research Centre, Child Safety Online, Global Challenges and Strategies*, 2012. OECD, Recommendation of the OECD Council, Report on risks faced by children online and policies to protect them, 2011.

² National Conference of State Legislatures, *Children and the Internet. Overview of State Laws. Cyberbullying*. <http://www.ncsl.org/research/education/cyberbullying.aspx>

4.2.2. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэгч байгууллага

Цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах Холбооны хэмжээний хөтөлбөр, бодлого байхгүй ба энэ хүрээнд хийгдсэн томоохон ажлууд нь төдийлөн амжилтгүй болсон учраас тодорхой яамдын болон муж улс нь өөрсдийн санаачилгаар тодорхой арга хэмжээ аван ажиллаж байна.

АНУ-д сошиал сүлжээний хэрэглэгчдийн тоо асар ихээр өсөн нэмэгдэж байгаа нь сошиал сүлжээний ангуучин (Social networking sexual predators) буюу хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг өдөөн үйлдэх этгээдүүд бий болгож байгаа ба энэ хүрээнд тодорхой зохицуулалтыг хэрэгжүүлэх оролдлого ч АНУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан мэдээллийн эрх чөлөөний эсрэг хэмээн тооцогдсон.¹ Иймд салбарынхныг өөрсдийн салбарын зохицуулалтыг бий болгон ажиллахыг уриалсан байна.² Харилцаа холбооны салбар дахь Google, Yahoo, Microsoft, MySpace зэрэг үндэсний томоохон корпорацууд өөрсдийн ёс зүйн дүрэм гарган, үйл ажиллагаандаа хяналт тавин ажиллаж байна.

4.3. Европын Холбооны эрх зүйн зохицуулалт

4.3.1. Европын Холбооны эрх зүйн зохицуулалт

Европын Холбоо хүүхдийг цахим орчинд хамгаалах асуудалд маш өндөр ач холбогдол өгдөг ба мэдээллийн эрх чөлөө, хүүхдийн эрхийг хангах асуудлыг тэнцвэржсэн байдлаар зохицуулах бодлого баримталдаг. Европын холбооны цахим орчинд хүүхдийг хамгаалах эрх зүйн

зохицуулалт болон холбогдох бодлого, хөтөлбөрийг авч үзье.

Холбооны түвшинд хуульчлан тогтоосон хэм хэмжээний тухайд Холбооны Цахим худалдааны директивд зааснаар (Directive on Electronic Commerce) аж ахуйн нэгжүүд цахим орчинд хүүхдийг хамгаалах талаарх ёс зүйн дүрэмтэй байх, үүнийгээ хэрэгжүүлэн ажиллах шаардлага тогтоосон.¹ Үүний зэрэгцээ Европын Холбооны “Дуу дүрс бичлэгийн хэвлэл мэдээллийн үйлчилгээний тухай директив” (EC Directive of the Audiovisual Media Services 2010/13/EU)-д хэрэглэгчдийн хүсэлтээр интернэтээр нэвтрүүлэг түгээгч /on-demand audiovisual services delivered over the internet/ хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс мөн зохисгүй зар сурталчилгаанаас хамгаалах ёстой байхаар заасан нь хүүхдийг сөрөг нөлөөтэй мэдээллээс хамгаалах маш чухал зохицуулалт болсон.²

Мөн Холбоо нь гишүүн-орнуудыг цахим орчинд хүүхдийг хамгаалах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг байнга үнэлэн дүгнэлт өгч байх “эргэх” механизмтай байхыг шаардсан нь бодлогын нэгдсэн байдал, сайн туршлагыг илрүүлэн дэмжих, алдаа оноог засан сайжруулахад нэн хэрэгтэй арга хэмжээ болсон байна.³

4.3.2. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа

ЕХ-ны үндсэн бодлого нь хүүхдийн эрхийг хамгаалах асуудалд тэргүүлэх чиглэл өгөн улмаар мэдээллийн эрх чөлөөг хангах, хүүхдийг хамгаалах асуудлыг тэнцвэржсэн байдлаар зохицуулахад оршино. Энэ хүрээнд ЕХ нь 1996 онд Цахим ертөнцөд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх баримт бичиг гарган мөн Аюулгүй интернэт орчин

¹ Article 16 I(e) of Directive on Electronic Commerce.

² EC Directive of the Audiovisual Media Services 2010/13/EU.

³ The regulatory framework concerning online protection of minors in China, Research paper. University of Oslo, 2011.

¹ Sander J.C. van der Heide, *Social Networking and Sexual Predators: The Case for Self-Regulation*, Hastings communications and entertainment law journal, 2008.

²⁴ Мөн тэнд.

1999-2004, Аюулгүй интернэт орчин 2005-2008 болон 2006 онд Бага насныхан болон хүний халдашгүй байдлыг хамгаалах талаарх зөвлөмж зэрэг шат дараалсан зөвлөмж, хөтөлбөрийг авч хэрэгжүүлж байна.¹

Аюулгүй интернэт орчин хөтөлбөрийн хүрээнд салбарын өөрийн зохицуулалт мөн төрийн болон салбарын хамтарсан зохицуулалтын дагуу гурван гол арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: уг салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг ёс зүйн дүрэмтэй байхыг хөхиүлэн дэмжих замаар бий болгуулах; контентийг шүүх болон контентийн рэйтинг тогтоох техникийг хөгжүүлэх; эцэст нь олон нийтийн дунд энэ талаарх ухамсар мэдлэгийг дээшлүүлэх болно.

Үүний зэрэгцээ хүүхдүүд гар утаснаасаа интернэт өргөнөөр ашиглах болсон тул ЕХ-ны “Хүүхэд залуучууд гар утсыг хор хөнөөлгүй, аюулгүй байдлаар ашиглах талаарх санаачилга” (European Framework for Safer Mobile Use by Younger Teenagers and Children)-д гишүүн-орны маш олон томоохон харилцаа холбооны операторууд нэгдсэн.

4.4. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын эрх зүйн зохицуулалт

4.4.1. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын эрх зүйн зохицуулалт

¹ Green Paper on the Protection of Minors and Human Dignity in Audiovisual and Information Service, presented by the Commission of the European Communities, [COM(96) 483 final], Brussels 16.10.1996. Decision No 276/1999/EC adopting a multiannual Community action plan on promoting safer use of the Internet by combating illegal and harmful content on global networks, O.J. L 033, 06 February 1999, p. 1-11, adopted 25 January 1999. Decision No 854/2005/EC of establishing a multiannual Community Programme on promoting safer use of the Internet and new online technologies, O.J. L 149, 11 June 2005, p. 1-13, adopted 11 May 2005.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (цаашид Их Британи гэх) нь өөрийн улсын нийгэм, улс төр, соёлын онцлогт тохирсон бодлогыг цаг алдалгүй авч хэрэгжүүлж байгаа ба энэ хүрээнд дэх уг улсын зохицуулалт, бодлого нь харьцангуй дэвшилттэй хэмээн тооцогдож байна. Ялангуяа Их Британи нь төрийн шууд зохицуулалтаас гадна төрийн болон бусад оролцогчдыг хамруулсан хамтын зохицуулалт болон салбарын өөрийн удирдлага/зохицуулалтыг (co-regulation, self-regulation) дэвшилттэй хэрэгжүүлж байгаа төдийгүй маш олон төрлийн арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлж буй жишиг улс гэж судлаачид үзэж байгаа учраас уг улсын холбогдох эрх зүйн зохицуулалт, бодлогыг авч үзье.

Эрүүгийн болон олон нийтийн хэв журмыг сахиулах тухай хуульд садар самуун материал “хэвлэн нийтлэх” гэдэг ойлголт нь интернэт дэх агуулгыг нэн адид хамрах болсон. Түүнчлэн технологи ашиглан компьютерийн тусламжтай эсхүл өөр ямар нэгэн техник ашиглан бий болгосон хүүхдийн дүр зураг бүхий садар самуун хэв маягтай “дууриамал зураг” нь эрүүгийн гэмт хэрэг хэмээн тооцогддог.¹ Цаашлаад Хүүхдийн эрхийг хамгаалах тухай 1978 оны хуульд заасан “зураг” гэдэг ойлголт нь цахим хэлбэрийг оруулан ойлгохоор болон нэмэлт өөрчлөлт орсон.² Садар самууны тухай 2003 оны хууль нь интернэтийг буруугаар ашиглан хүүхдүүдийг хохироох аюулаас хамгаалах үүднээс хүүхдийг садар самуун үйл хэрэгт ашиглах зорилгоор хүүхдийн итгэлийг олж аван түүнтэй найз нөхдөг дотно харилцааг бий болгодог “grooming” гэмт хэргийг хамрах болсон.

¹ Section 84, Criminal Justice and Public Order Act, 1994.

² Section 7(4), Protection of Children Act, 1978.

4.4.2. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэгч байгууллага

Мэдээжээр Их Британи нь ЕХ-ны гишүүн-орон учир Холбооны хүрээнд хүлээсэн хариуцлагын дагуу ЕХ-ны хөтөлбөр арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа төдийгүй өөрийн орны түүх, соёлын онцлогт тохирсон тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Их Британийн Дотоод хэргийн яам нь энэхүү асуудлыг хариуцан ажилладаг байна. Уг байгууллагын дэргэдэх Аюулгүй интернэт орчин бүрдүүлэх комисс (The Home Secretary's Internet Task Force) нь хүүхдэд зориулсан аюулгүй орчин бий болгох, хүүхдийг хамгаалах гэсэн хоёр үндсэн зорилго, чиг үүрэгтэй ажилладаг. Үүний зэрэгцээ төрийн санхүүжилттэй салбарынхны төлөөлөл, цагдаа, шүүх байгууллагын төлөөлөл орсон хамтарсан байдлаар цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор бий болсон "Цахим ертөнц дэх хүүхдийн эсрэг хүчирхийллийн төв" /The Child Exploitation and Online Protection Centre/ хэмээх хамтын зохицуулалт хэрэгжүүлдэг байгууллага эрчимтэй үйл ажиллагаа явуулдаг.

Их Британийн томоохон 4 интернэтийн үйлчилгээ түгээгч операторууд нь ЕХ болон Английн төрийн уриалга, санаачилгын дагуу хүүхдийг цахим орчинд хамгаалах үйл хэрэгт өөрсдийн хувь нэмрийг оруулах үүднээс өөрсдийн ёс зүйн дүрэмтэй болсон бөгөөд шүүгчийн болон контент блоклох техникийн тусламжтай амиа хорлолт, хүчирхийлэл, порнограф, зүй бус контент зэрэг контентийг блоклох болсон.¹

Их Британийн хүүхдэд зориулсан боловсролын, үйлчилгээний байгууллагуудын стандартад хяналт тавин ажилладаг Офстед байгууллагын гаргасан (Office for Standards in Education, Children's

Services and Skills /Ofsted/) Цахим орчинд аюулгүй байдлыг хангах талаарх заавар (the Ofsted eSafety guidance) гэж байдаг ба уг зааврын дагуу цахим аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг гүйцэтгэсэн эсэхийг сургууль, дээд боловсролын байгууллагуудыг аттестатчилахдаа дүгнэдэг байна.¹ Үүний зэрэгцээ энэ хүрээн дэх нийгмийн ухамсар хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүүхдүүд, эцэг эхчүүд, сурган хүмүүжүүлэгчид, харилцаа холбооны хувийн хэвшлийн байгууллагуудад зориулсан тусгай цахим сайтыг төрийн зүгээс ажиллуулдаг.²

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэ хэсэгт эхлээд манай улсын дараагаар нь гадаад улсуудын туршлагыг дүгнээд холбогдох санал дэвшүүлэв.

-Боловсролын хүрээнд мэдлэг олгох, олон нийтийн дунд ухамсар хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, техникийн тусламжтай хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улсын мэдээллийн технологи, интернэтийн хэрэглээ байнга өсөн нэмэгдэж байгаа энэ үед хүүхдүүд цахим орчинд ихэнх цагаа зарцуулах болсон. Үүнтэй холбоотойгоор цахим орчинд хүүхдийг шууд болон шууд бусаар сэтгэл зүй болон хүмүүжлийн хувьд хүчирхийлэх, мөлжих явдал илэрч байна. Гэвч манайд цахим орчинд хүүхдийг хамгаалах талаар олон нийтийн ялангуяа хүүхдүүд, эцэг эхчүүд, сурган хүмүүжүүлэгч болон харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг

¹ Office for Standards in Education, Children's Services and Skills. Briefings and information for use during inspections of maintained schools and academies. <http://www.ofsted.gov.uk/resources/briefings-and-information-for-use-during-inspections-of-maintained-schools-and-academies>

² OECD, Recommendation of the OECD Council, Report on risks faced by children online and policies to protect them. 2011. www.thinkuknow.co.uk хэмээх сайт байдаг.

¹ Мөн тэнд.

этгээдүүдэд тодорхойлон чиглэж авч хэрэгжүүлж буй зүй зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлсэн арга хэмжээ болон цахим орчны хор хөнөөлийн талаарх ухамсар хандлагыг нэмэгдүүлсэн арга хэмжээ аль аль нь дорвитой байдлаар хийгдэж эхлээгүй байна. Техник технологи ашиглан цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ, зохицуулалт мөн л байхгүй.

- *Хууль бус агуулгатай тэмцэх арга хэмжээ*

ХХЗХ-оос “Контентийн” тусгай зөвшөөрөл олгох болсноор контентийн үйлчилгээний бизнест оролцогч болох контентийн агрегатор, контентийн хостингийн үйлчилгээ эрхлэгчдийг хууль бус (illigal content) агуулга түгээхэд хориг тогтоох хууль зүйн үндэслэлтэй болсон хэдий ч яг хэрхэн хууль бус агуулгатай тэмцэх талаарх зохицуулалт, арга хэмжээ нь тодорхойгүй. Тиймээс энэ асуудлын хүрээнд төрөөс санаачлан бий болгосон институт, салбарын өөрийн удирдлага/зохицуулалт (self-regulatory), хамтын удирдлага/зохицуулалт (co-regulatory), хуульчилсан хэм хэмжээ гэх мэт цахим орчин дахь аюулыг мэдэгдэх, түүнтэй тэмцэх харилцан уялдаа бүхий механизм байхгүй байдалтай байна.

Энэ асуудлын хүрээнд Их Британид хууль бус агуулгатай тэмцэхийн тулд харилцаа холбооны салбарын интернэтийн үйлчилгээ түгээгч байгууллагууд шүүгч программыг ашиглан хууль бус агуулгыг блоклох үйл ажиллагаа явуулдаг нь тэд өөрсдийн нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан салбарын өөрийн удирдлага/зохицуулалтыг хэрэгжүүлж байгаагийн нэг хэлбэр юм. Япон Улс нь мөн л Насанд хүрээгүй этгээдийн интернэтийн хэрэглээг зохицуулах тухай хуульд 18 нас хүрээгүй этгээд нь гар утас болон PHS сүлжээгээр интернэт ашиглах тохиолдолд заавал шүүгч программыг ашиглах ёстой болгон хуульчилсан бөгөөд мэдээллийн эрх чөлөөг хангах үүднээс уг

шаардлагыг асран хамгаалагчийн хүсэлтээр цуцалж болдог байдлаар зохицуулсан. Үүнээс үзэхэд манай улсад хууль бус агуулгатай тэмцэх эрх зүйн орчин дөнгөж бүрэлдэж эхэлж байгаа гэж үзэж болохоор байгаа ба харин уг асуудалтай хэрхэн тэмцэх арга зам, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага ерөнхийдөө энэ талаар тодорхой бодлогоо хараахан бий болгоогүй байна. Түүнчлэн цахим орчинд хүүхэдтэй харилцаа тогтоон үйлдэгддэг гэмт хэрэг (cybergrooming, cyberbullying) болон бусад эрсдэлтэй тэмцэх эрх зүйн орчин бүрэлдээгүй мөн эдгээрээс урьдчилан сэргийлсэн тодорхой бодлого манайд үгүйлэгдэж байгаа нь судалгааны явцад илэрхий байна. Ялангуяа “grooming” буюу “садар самуун үйлдэл хийлгэх зорилготой цахим өдөөлт” нь өргөн хүрээнд үйлдэгдэх гэмт хэрэг болсон ба ихэнх улс орон уг гэмт хэргийг эрүүгийн хуулийн хүрээнд зохицуулдаг болсон байхад манай улсад уг гэмт хэргийг зохицуулах хэм хэмжээ байхгүй байгаа төдийгүй Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд ч тусгагдаагүй байгааг анхаарах нь чухал болов уу.

- *Хүүхдэд хор хөнөөлтэй, сөрөг нөлөөтэй агуулгыг зохицуулахад чиглэсэн арга хэмжээ*

Цахим орчинд хүүхдэд хор хөнөөлтэй, сөрөг нөлөөтэй (harmful, inappropriate content) агуулгыг зохицуулах нь мэдээллийн эрх чөлөөг хангах асуудалтай зөрчилддэг учраас цахим орчинд хүүхдэд сөрөг нөлөөтэй агуулгыг зохицуулах нь хэцүүхэн асуудал гэдэг нь АНУ-ын туршлагаас илэрхий. Иймд бидний судалсн ихэнх улс оронд хүүхдийг цахим орчинд хор хөнөөлтэй, сөрөг нөлөөтэй мэдээллээс хамгаалахын тулд боловсролын хүрээнд интернэтийн зүй зохистой хэрэглээний талаарх хичээл оруулах, олон нийтийн дунд интернэтийн хор хөнөөлийн талаар ухамсар мэдлэгийг нэмэгдүүлэх гэх мэт урьдчилан сэргийлэх олон арга хэмжээг техникийн тусламжтайгаар авч хуульчилсан хэм хэмжээний хамт зохицуулдаг байна.

Тухайлбал Япон Улс нь тусгайлан хууль баталж хүүхдэд сөрөг нөлөөтэй мэдээллийг онцлон зохицуулах болсон бөгөөд уг хуульд шүүгч программ ашиглах, зүй зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх гэх мэт цахим орчинд сөрөг мэдээллээс хүүхдийг хамгаалахад чиглэсэн олон арга хэмжээг цогц байдлаар хуульчлан зохицуулсан байх жишээтэй. Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын "Цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах нь" хэмээх судалгаанд Солонгос Улсыг цахим бүртгэлийн тогтолцоонд суурилсан хүүхдийн насыг магадлах системийг цахим орчинд хүүхдийг сөрөг нөлөөтэй мэдээллээс хамгаалахад ашигладаг төдийгүй хууль бус агуулгыг шүүгч программ ашиглаж байхыг интернэтийн үйлчилгээ түгээгч байгууллагуудаас хуульчлан шаардсан зохицуулалттай гэдгийг онцлон тэмдэглэснийг анхааран цаашид судлуулжтай.

Манай улсад хүүхдийг цахим орчинд хамгаалахтай холбоотой зохион байгуулалтын асуудлыг хөтөлбөр, төлөвлөгөө байдлаар тусгасан тул тэдгээрийн заавал хэрэгжих байдал дутагдалтай байгаагаас гадна энэхүү хэдэн бодлого хөтөлбөр ч харилцан-уялдаагүй, харилцан-зохицолдоогүй, нэгдсэн цогц бус байдлаар хэрэгжиж байна. Үндсэндээ манайд цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн тодорхой орчин бүрэлдээгүй байдлыг дүгнэвэл энэ асуудал нь манай улсын тухайд харьцангуй шинэ зүйл бололтой. Гэсэн хэдий ч МУИС-ийн НШУС-ийн Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны тэнхимийн гүйцэтгэсэн "Мэдээллийн хэрэгслийн хүүхдийн хүмүүжилд үзүүлэх нөлөө" төслийн судалгааны тайлан нь цахим орчинд нүүрлэх агуулгын, харилцааны, мэдээллийн аюулгүй байдлын гэх мэт эрсдэлд хүүхдүүд аль хэдийнээ өргөнөөр өртөх болсныг харуулсан.

Харин одоо Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын "Цахим

ертөнцөд хүүхдийг хамгаалах нь" хэмээх судалгаанд улс орны авч хэрэгжүүлж буй арга хэмжээний онцлогийг нь харгалзан гурван төрөл болгон ангилсны нэгдүгээрт цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн хуульчилсан хэм хэмжээ тогтоохын зэрэгцээ техник технологийн дэвшилийг ашиглан зохицуулалтыг хэрэгжүүлж буй улсын төлөөлөл болгон Япон Улсын; хоёрдугаарт салбарын өөрийн зохицуулалт мөн төрийн, олон нийтийн, иргэний нийгмийн төлөөллийг хамруулан хамтын зохицуулалтыг хэрэгжүүлж буй АНУ-ын; гуравдугаарт тодорхой аль нэг зохицуулах арга барилыг хэрэгжүүлэх гэж туйлшрахгүйгээр бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлж буй улсын төлөөлөл болгон Европын Холбоо үүн дотроо Их Британийн зохицуулалтын талаар товч дүгнэлт хийе.

Эхний ангиллаас төлөөлөл болгон судалсан Япон Улсын хувьд дэлхийд техник, технологийн хөгжлөөрөө тэргүүлэгч орны хувьд энэ төрлийн салбараа ямагт хөгжүүлэхийн тулд төрийн зүгээс бизнес эрхлэгчдээ дэмжиж ажилладаг. Гэвч хөгжил бүхэн сайнаас гадна сөрөг зүйлийг дагуулдаг учир техник, технологи хөгжих тусам тухайн орчинд өсөн торниж буй хүүхдүүд буюу насанд хүрээгүй хүмүүсийн цаашдын зан төлөв, бие махбодын бүрэн төлөвшилд сөргөөр нөлөөлдөг байна. Үүний нэг жишээ нь цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах асуудал бөгөөд 2008 онд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалж, аюулгүй байдлыг хангах бие даасан хуулийг батлан мөрдүүлж байна. Энэ хуулийн онцлог нь төр болон бизнес эрхлэгч, иргэд, эцэг эхчүүдийн хамтын ажиллагаанд тулгуурлан заавал албадлагын бус илүү боловсрол, оюун санаанд нь чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх асуудал юм. Энэ нь ч уг хуульд техникийн тусламжтай авах арга хэмжээ болох шүүгч программыг мэдээллийн эрх чөлөөг хангах мөн хүүхдийн эрхийг цахим орчинд хамгаалахад ухаалгаар ашиглаж чадсантай холбоотой.

Мөн Япон Улсын хувьд хуулийг хэрэгжүүлэхдээ төрийн албадлагын хүчээр бус энэ төрлийн харилцаанд оролцогчдод үүрэг болгох замаар өөрсдөөр нь хэрэгжилтийг нь хангуулж байгаа нь төрийн зүгээс шууд хүүхдийн эрхийг хязгаарлаж байгаа бус, эргээд бүх нийтээр хуулийг ойлгож, зөвхөн мэргэжлийн этгээд бус эцэг эхээс эхлээд хүүхэд хүртэл цахим орчинд өөрийн эрхийг хамгаалах, мэдээллийн ёс зүйг чандлан сахих, ёс зүйн төлөвшлийг тогтооход чухал ач холбогдолтой байна.

АНУ-ын тухайд Үндсэн хуулиар баталгаажсан мэдээллийн эрх чөлөөг хангах асуудал нь цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах санаачилга, тодорхой ажлуудыг хүчингүй болгох, нураах эсхүл далайцтай шийдвэрлэхэд ихээхэн саад тогтор болж байгаа учраас хүүхдийг цахим ертөнцөд хамгаалах хүрээнд хийгдэж байгаа ажлууд туйлын хангалтгүй гэж олон эрдэмтэд үзэж байна.¹ Гэсэн хэдий ч Холбооны түвшинд номын сан, сургуулиуд гэх мэт хүүхэд ихээр цуглардаг орчинг бүсчлэн зохицуулсан хууль, хүүхдийн цахим орчинд хууран мэхлэх үйл ажиллагаанаас тодорхой хэмжээнд хамгаалах үүднээс Домэйн нэрийг үнэн зөв байлгах тухай хууль, хүүхдийн и-мэйлийн спамд ирдэг зохисгүй мэдээллийг зохицуулах хүрээнд мөн хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах хүрээнд гэх мэт тодорхой хуульчилсан хэм хэмжээ мөрдөгдөж байна.

АНУ-диргэнийнийгмийнбайгууллагууд нь төлөвшсөн ба энэ хүрээнд маш идэвхтэй үйл ажиллагааг бие даан болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран явуулдаг. Мөн мэргэжлийн ёс зүйн өндөр хөгжилтэй улс учраас харилцаа холбооны салбарын томоохон хувийн хэвшлийн байгууллагууд нь ёс зүйн дүрэм гарган үүнийхээ дагуу ажиллах буюу салбарын өөрийн удирдлага/зохицуулалтыг (self-regulation) түлхүү хэрэгжүүлж байгаа нь цахим орчинд хүүхдийг хамгаалахад томоохон үүрэг гүйцэтгэж байна.

Харин ЕХ-ны санаачилга зохицуулалт нь гишүүн-орнуудыг уриалсан цаашлаад энэ хүрээнд авах шаардлагатай арга хэмжээний хүрээг тодорхойлсон суурь нь болж чадсан. Энэ хүрээнд Холбооны түвшинд бодлого, хөтөлбөр боловсруулах, хуульчилсан хэм хэмжээ тогтоон шууд зохицуулах арга барилаас гадна Холбоо нь салбарын өөрийн (self-regulatory), төрийн болон салбарын хамтарсан зохицуулалтыг (co-regulatory) дэмжин хөгжүүлэн ажиллахыг гишүүн-орнуудад Холбооны түвшинд үр дүнтэй уриалж чадсан.

Цахим орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн маш сайн арга хэмжээг хэрэгжүүлэгч Их Британи нь мэдээллийн технологийн дэвшилттэй холбоотойгоор үүсч буй асуудлуудыг цаг алдалгүй, үр дүнтэй шийдвэрлэхийн тулд холбогдох хууль тогтоомжид тухай бүр нь шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулж байсны зэрэгцээ төрийн санаачилга, дэмжлэгтэйгээр салбарын, төрийн, төрийн бус, олон нийтийн хүчийг хамруулан цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах асуудлыг зохицуулах тодорхой чиг үүрэг бүхий олон байгууллагуудыг бий болгон улмаар энэ хүрээнд харилцан уялдаа бүхий нэгдсэн тогтолцоо бүрдүүлэн ажиллахыг зорьж байна. Салбарын болон хамтын зохицуулалтыг төр хувийн хэвшлийн түншлэл хэлбэрээр үр дүнтэй хэрэгжүүлдэг.

Цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах үндэсний хэмжээний стратеги хөтөлбөр боловсруулан тодорхой бодлого болон үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлж байгаа нь бодлого боловсруулах түвшнийхэн, олон нийтийн дунд төдийгүй салбарынхны дунд энэ талаарх ухамсар, хандлагыг нэмэгдүүлэн идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлэх үндэс суурь нь болж байна. Харин дээрх улсуудыг төлөөлөл болгон судалсан аль ч ангилалд манай улс нь хамаарахгүй тул хэдий цахим орчинд хүүхдийг хамгаалах талаар тодорхой хэмжээнд анхаарч байгаа ч цахим орчинд

¹⁴ Мөн тэнд.

хүүхдийн хамгаалах тодорхой бодлогогүй улсын тоонд манай улс нь хамаарна гэж үзэж болохоор байна.¹

Ингээд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын “Цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах нь” хэмээх судалгаанд улс орны авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бодлогын цар хүрээг тоймлон тодорхойлсныг авч үзээд уг судалгаанд улс орон холбогдох бодлогыг хэрэгжүүлэхэд юуг анхаарах шаардлагатай талаар дэвшүүлсэн саналыг цухасхан дурдъя. Уг судалгаанд арга хэмжээг тоймлохдоо:

i) шууд болон шууд бус байдлаар хэрэгжүүлж буй олон давхаргат арга хэмжээ (multi-layered policies);

Олон давхаргат арга хэмжээ гэдэгт эрх зүйн хэм хэмжээ тогтоох, хүүхэд ихээр цуглардаг орчныг бүсчлэн зохицуулах /жишээ нь: боловсролын байгууллага/, салбарын өөрийн зохицуулалт, төрийн болон салбарын хамтын зохицуулалт, техникийн тусламжтай авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, олон нийтийн мэдлэг ухамсрыг нэмэгдүүлэхэд болон боловсролын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүүхдэд ээлтэй буюу тусгайлан хүүхдэд зориулсан цахим сайтуудыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ хэмээн тодорхойлсон бөгөөд ихэнх улс орон цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах үндэсний хөтөлбөр, бодлогын хүрээнд дээрх олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.²

ii) хамаарал бүхий олон оролцогчдын үүрэг хариуцлагын хүрээнд хэрэгжих олон оролцогчдыг хамарсан арга хэмжээ (multi-stakeholder policies);

Олон оролцогчдыг хамарсан арга хэмжээний хүрээнд тодорхой төрийн байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд, боловсролын байгууллагууд,

эцэг эхчүүд, хүүхдүүд, салбарынхан тус тус өөрсдийн үүрэг хариуцлагатайгаар цахим орчинд хүүхдийг хамгаалах үйлст зүтгэж байна. Ялангуяа төр засгийн дээд түвшинд үндэсний хэмжээний бодлогыг тодорхойлох нь эдгээр оролцогчдыг өөр өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцон, тодорхой арга хэмжээ аван санаачилгатай ажиллах нөхцөлийг хангахад нэн чухал байдаг нь тодорхойлогдсон.¹

iii) нэгэнт л интернет дэх хууль бус агуулгыг таслан зогсоохын тулд хэрэгжүүлэх арга хэмжээ нь зөвхөн нэгэн улсын хэмжээнд хязгаарлагдах боломжгүй учраас үндэсний, бүсийн болон олон улсын хэмжээнд хамтран хэрэгжүүлэх олон түвшинт арга хэмжээ (multi-level policy) байна.²

Олон түвшинт арга хэмжээ гэдэгт үндэсний хэмжээний бодлого, тив бүсийн хэмжээний хөтөлбөр, санаачилга болон олон улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг хамруулан ойлгодог.

САНАЛ

Эцэст нь тусгайлан судалсны хувьд манай улсын тухайд энэ хүрээнд авч хэрэгжүүлэх боломжит бодлогын талаар товчхон санал дэвшүүлье. Манай улс нь ёс зүй өндөр төлөвшсөн, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгэм бүрэлдсэн АНУ-ын салбарын удирдлага/зохицуулалтад (self-regulatory) тулгуурласан зохицуулалтын хэв маягаас суралцах зүйл олон байгаа хэдий ч манай орны нийгмийн тогтворгүй байдал, иргэний нийгмийн тогтвортой оролцоо, мэргэжлийн ёс зүйн төлөвшил зэргийг харгалзан энэхүү хувилбар нь дангаараа манай улсад төдийлэн тохиромжгүй байх магадлалтай гэж үзэж байна. Харин энэ хүрээнд Япон Улсын бодлого нь цэгцтэй бөгөөд

¹ OECD, *Recommendation of the OECD Council, Report on risks faced by children online and policies to protect them*, page 42, 2011.

² Мөн тэнд.

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ Мөн тэнд.

хууль бус агуулгатай тэмцэх тодорхой арга хэмжээг авч байгаагаас гадна хүүхдэд сөрөг нөлөөтэй агуулгыг зохицуулах тусгай хууль баталсан нь олон нийтийн дунд энэ асуудалд хандуулах ач холбогдлыг нэмэгдүүлсэн төдийгүй бүхий л иргэдийнхээ тогтвортой, тууштай, идэвхтэй оролцоог бий болгоход уриалж чадсан арга хэмжээ болсон гэж үзэж байгаа учраас манай нөхцөлд нутагшуулахад боломжтой мөн үр дүнтэй байх магадлалтай. Түүнчлэн маш олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн цахим орчинд хүүхдийг хамгаалахыг зорьж буй Их Британийн туршлагаас ч суралцах зүйл олон байна. Ингээд хуульчлан зохицуулах болон бодлого, хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дараах саналууд байна:

-Эрх зүйн зохицуулалтын тухайд:

Цахим орчинд хүүхдэд нүүрлэдэг агуулгын, харилцааны, хүүхэд хэрэглэгчийн хувьд, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотойгоор үүсдэг гэх мэт бүхий л эрсдэл, аюулаас хүүхдийг хамгаалахын тулд холбогдол бүхий хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах арга замаар, тухайлбал Хүүхдийн эрхийн тухай хуульд, Эрүүгийн тухай, Зар сурталчилгааны тухай гэх мэт холбоо бүхий бүхий л хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой. Хууль бус агуулгатай тэмцэх хүрээнд техник технологи¹ ашиглан авах боломжит арга хэмжээг интернэтийн үйлчилгээ түгээгч байгууллагуудаас хуульчлан шаардах мөн цахим орчинд хууль бус агуулга ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийллийг харуулсан гэмт хэрэгт ногдуулах хариуцлагыг чангатгах нь хууль бус агуулгатай тэмцэхэд үр дүнтэй байх болов уу.

Үүний зэрэгцээ хүүхдийг сөрөг нөлөөтэй мэдээллээс цахим орчинд хамгаалах асуудалд чухал ач холбогдол өгөх, мөн олон нийтийн дунд энэ талаарх ухамсар хандлагыг нэмэгдүүлэх үүднээс цахим орчинд хүүхдийг сөрөг нөлөөтэй, хор хөнөөлтэй агуулгаас хамгаалахад чиглэсэн бие даасан эрх зүйн зохицуулалттай болох шаардлагатай. Ялангуяа хүүхдийг цахим орчинд сөрөг нөлөөтэй агуулгаас хамгаалах зохицуулалт нь мэдээллийн эрх чөлөөг зөрчихгүй байдлаар хэрэгжих ёстой гэдгийг анхаарах шаардлагатай учраас сөрөг нөлөөтэй агуулгыг зохицуулахын тулд техник технологи ашиглан авах боломжит арга хэмжээг эцэг эхийн хяналттай уялдуулан мөн интернэтийн үйлчилгээ түгээгч оператруудад тодорхой үүрэг оноох байдлаар хуульчлах боломжтой. Энэ хүрээнд Япон Улсын тусгайлан хуулийг чиг баримжаа болгох боломжтой. Цаашлаад сөрөг нөлөөтэй агуулгыг зохицуулах хүрээнд хийгдэж буй АНУ болон Их Британийн Цахим худалдааны тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Сургууль болон боловсролын байгууллагуудыг бүсчлэн зохицуулсан хууль зэргээс туршлага суралцах нь нэн чухал. Түүнчлэн цахим мөрийтэй тоглоомыг хүүхдэд хуульчлан хорих, хүүхдэд цахим болзооны сайтыг ашиглахыг хязгаарлах хүрээнд ч хэм хэмжээ тогтоох шаардлагатай байна.

Хүүхдийг сөрөг нөлөөтэй мэдээллээс цахим орчинд үр дүнтэй хамгаалахын тулд ийнхүү хуульчилсан хэм хэмжээнээс гадна өргөн хүрээний цогц бодлого хэрэгжүүлэх ч шаардлагатай байна.

*-Бодлого, хөтөлбөр,
хэрэгжүүлэгч байгууллагын
тухайд*

Ухамсар хандлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ: Улс орон болгон нь интернэт орчинд заналхийлдэг аюулын талаар мөн энэ асуудлаарх ухамсар мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг

¹ Joshua A.T. Fairfield, *Protecting virtual playgrounds: children, law, and play online: Virtual parentalism*, Washington & Lee Law review, 2011. Энэ судалгаанд АНУ-ын жишээн дээр шүүгч програмыг хэрхэн мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлөхгүй байдлаар хуульчлан ашиглахыг дэмжих талаар санал тусгагдсаныг ашиглах боломжтой.

боловсролын салбарын хүрээнд мөн эцэг эхчүүдэд, хүүхдүүдэд зориулан өргөнөөр хэрэгжүүлж байна. Ялангуяа хууль сахиулах дэд бүтэц, төсөв мөнгө багатай манай нөхцөлд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон олон нийтийн дунд энэ асуудлын талаарх ухамсар хандлагыг нэмэгдүүлэх тодорхой бодлогыг хэрэгжүүлэх нь нэн шаардлагатай. Ингэхдээ хүүхдэд зориулсан эерэг цахим сайтуудыг болон эцэг эхчүүд болон сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан гарын авлага, шаардлагатай мэдээллийг агуулсан цахим сайтыг олноор бий болгох шаардлагатай.

Боловсролын салбарын хүрээнд авах арга хэмжээ: Цахим аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг гүйцэтгэсэн эсэхийг сургууль, дээд боловсролын байгууллагуудыг аттестатчилахдаа дүгнэдэг болох нь чухал. Мөн боловсролын байгууллагуудыг шүүгч программтай байлгах асуудлыг анхааран шийдвэрлэх хэрэгтэй. Сургуулийн хүүхдүүд болон оюутнуудын мэдээллийн технологийн хичээлд интернэтийн зүй зохистой хэрэглээний ойлголтын талаар, цахим орчинд хүүхдэд нүүрлэдэг аюул, эрсдэлийн талаар заадаг болгох нь зүйтэй.

Техник, технологийн тусламжтай авах арга хэмжээ: Техник технологийн хүрээнд авах арга хэмжээг ч төрийн зүгээс санаачлан бий болгох, хөхиүлэн дэмжих шаардлагатай юм. Тухайлбал: шүүгч программ, рэйтинг тогтоох программ зэргийг нэн яаралтай нэвтрүүлэн хууль тогтоомжийн хүрээнд болон бодлого, хөтөлбөрийн хүрээнд төрөөс дэмжин ажиллах шаардлагатай.

Энэ асуудлын хүрээн дэх чиг цэрэг бцхий байгууллага: Харилцаа холбооны зохицуулах хорооноос гадна дараах байгууллага “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын 4-р зүйл буюу контентийг бүтээж, түгээх, сурталчлах үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох

хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг мөрдүүлэх, зөрчсөн контент бүтээх, түгээхийг хориглох зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтийн талаар тайлан, мэдээндээ тусгаж байх шаардлагатай байна. Үүнд: ҮАБЗ-ийн Ажлын алба, ТЕГ, Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын Цахим гэмт хэрэгтэй тэмцэх тасаг, ШӨХТГ, ОӨГ, Эротикийн сурталчилгаанд хяналт тавих зөвлөл, Хүүхдийн төлөө үндэсний газар хамаарна.

Мөн салбарын болон хамтын зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ хуульчлан тогтоох (institutional self-regulation) байдлаар бий болгох боломжтой. Түүнчлэн салбарын, хамтын зохицуулалтыг хэрэгжүүлэх үүднээс төр хувийн хэвшлийн түншлэл хэлбэрээр цахим орчин дахь хууль бус контентийн эсрэг ажиллах нь үр дүнтэй юм. Жишээ нь “мэдэгдэх болон таслах” /notice and takedown/ механизмыг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлэх боломжтой. Энэхүү салбарын болон хамтын зохицуулалтыг сошиал сүлжээний хүрээнд мөн ухаалаг гар утас ашиглах хүрээнд үүсдэг зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэхэд хэрэгжүүлэх боломжтой. Цаашлаад холбогдох хууль сахиулах байгууллагын чадавхийг сайжруулах мөн цахим орчин дахь хүүхдийн эсрэг хууль бус агуулга, үйлдэлтэй тэмцэх бүтцийг бий болгох шаардлагатай. Улмаар олон нийтийн дунд хэрхэн энэ асуудлыг мэдэгдэх хамтран хууль сахиулах талаар ойлголттой болгох нь чухал юм.

Олон улсын хамтын ажиллагаа: Олон улсын түвшинд цахим орчинд хүүхдийг хамгаалах асуудлын хүрээнд харилцан сайн туршлага солилцох болон хууль бус контентийн эсрэг олон улсын хэмжээнд хамтран хууль сахиулах хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж

байгаа бөгөөд манай улс ч энэ хүрээнд дэх үйл ажиллагаанаас туршлага судлах, хууль сахиулах үйлст хамтран зүтгэх нь нэн чухал. Ингээд эцэст нь ийнхүү олон оролцогчдыг хамруулан олон түвшинд авч хэрэгжүүлэх төрөл бүрийн арга хэмжээг нэгдсэн, харилцан уялдаатай цогц бодлогын дагуу хэрэгжүүлэх нь чухал бөгөөд нэгэнт л энэхүү асуудал нь

манай улсын тухайд төдийгүй олон улсын түвшинд шинэлэг асуудал учраас бодлогын үр дүнтэй байдал, харилцан уялдаатай байдлыг хянах, үр нөлөөнд үнэлгээ хийх, дахин дүгнэх, дахин сайжруулах “эргэх механизм” бүхий тогтолцоог цахим орчинд хүүхдийг хамгаалах бодлогын хүрээнд бий болгох нь чухал юм.⁴⁰

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

⁴⁰ ЭХХАХБ-ын “Цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах нь” судалгааны хүрээнд тусгагдсан эдгээр бодлогын зөвлөмж болон олон улсын хамтын ажиллагааны үр дүнд бий болсон олон зөвлөмж, сайн туршлагыг эрх зүйн зохицуулалт болон энэ хүрээнд дэх бодлогыг тодорхойлохдоо ашиглах нь зүйтэй юм.

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2010 оны 5 дугаар сараас Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА, Монголын Улсын Дээд шүүх, Монголын Өмгөөлөгчдийн холбоо хамтран Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү төслийн зорилго нь орон даяар эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлж, ингэснээр иргэний болон гэр бүлийн хэрэг маргаан төдийгүй бусад төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэх бас нэгэн арга замыг бий болгох явдал юм. Төслийн эхний шат буюу 2010 оны 5 дугаар сараас 2012 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд Баянзүрх дүүргийн шүүх болон Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхийг түшиц шүүхээр сонгон, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг туршилтын журмаар явуулан тодорхой үр дүнд хүрлээ. Тухайлбал, Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүх 2012 оны 1-р сараас 12 дугаар сарын хугацаанд нийт 255 хэрэг хүлээн авснаас 134 хэрэг (52,5%) нь амжилттай шийдвэрлэгдсэн гэсэн судалгаа гараад байна.

Түүнчлэн төслийн үйл ажиллагааны хүрээнд, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны удирдамж, дагаж мөрдөх дүрэм, стандартыг боловсруулах, эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалт явуулах, эвлэрүүлэн зуучлалыг иргэдэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулж, түшиц шүүхүүдэд хэрэгжиж буй ажиллагааны явцад тулгарч буй бэрхшээлийг судлах гэх зэргээр эвлэрүүлэн зуучлах тогтолцоог орон даяар нэвтрүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажлыг шат дараатайгаар зохион байгуулж ирлээ. Мөн Япон болон бусад орны эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж, түшиц шүүхүүдэд хэрэгжиж ирсэн бодит туршлага дээр тулгуурлаж Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль боловсруулагдсан ба энэ хууль

нь төслийн нэгдүгээр шатанд буюу 2012 оны 5 дугаар сард батлагдаж, холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон явдал нь төслийн ажлын нэгэн том ахиц боллоо.

Төслийн хоёрдугаар шат нь 2013 оны 4 дүгээр сараас 2015 оны 12 дугаар сар хүртэл үргэлжлэх ба Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн дагуу энэ оны 2 дугаар сараас орон даяар эвлэрүүлэн зуучлал хэрэгжиж эхэлсэн билээ. Үүнтэй уялдуулан эвлэрүүлэн зуучлах өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмжийг бүх анхан шатны шүүх дээр байрлуулах, шүүх байгууллага болон Өмгөөлөгчдийн холбоо бусад холбогдох албаны хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх, давтан сургах, сургагч багш бэлтгэх, гарын авлага боловсруулах, иргэдэд сурталчлан таниулах, хэрэгжилтийн явцад мониторинг судалгаа явуулах зэрэг ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал, 2013 оны 4 дүгээр сарын 15-аас 7 дугаар сарын 5 хүртэл нийт орон нутгийн шүүхүүд дээр “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны” тухай сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг шүүгч, шүүхийн ажилтан, иргэд болон алслагдсан аймгуудад эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх гэсэн гурван чиглэлээр явуулсан. Мөн энэ үеэр эвлэрүүлэн зуучлалын өрөө танхимын зохион байгуулалттай танилцаж, иргэний болон гэр бүлийн, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан зэрэг хэргийн төрөл тус бүрийн ачааллыг судалж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нэвтрүүлэхэд цаашид үүсч болзошгүй асуудлын талаар судалсан.

**Төслийн түшиц шүүхүүд дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан байдал
(2012 оны мэдээгээр)**

Баянзүрх дүүргийн шүүхийн эвлэрүүлэн зуучлах хэсэг

Иргэний хэрэг

№	Хэргийн төрөл	Нийт хүлээн авсан хэрэг	Амжилттай	Амжилтгүй	Ажиллагаанд
1	Зээл	31	19	6	6
2	Түрээс	10	7	3	-
3	Худалдах худалдан авах гэрээ	61	32	28	1
4	Гэм хорын хохирол	18	9	6	3
5	Ажил гүйцэтгэх	2	2	-	-
6	Газар	6	1	4	1
7	Хамтран ажиллах гэрээ	2	1	-	1
8	Бичиг баримт гаргуулах	5	2	2	1
9	Хөдөлмөрийн маргаан	14	7	5	2
10	Нэр төр сэргээлгэх тухай	2	2	-	-
11	Асран тэтгэх	1	-	-	-
12	Бусад	52	24	16	12
Нийт		204	106	70	27

Гэр бүлийн хэрэг

№	Хэргийн төрөл	Нийт хүлээн авсан хэрэг	Амжилттай	Амжилтгүй	Ажиллагаанд
1	Гэр бүл цуцлалт	37	21	13	3
2	Хүүхдийн асрамж	5	2	3	-
3	Хүүхдийн тэтгэлэг	7	4	3	-
4	Дундын эд хөрөнгө хуваах	2	1	1	1
Нийт		51	28	20	4

Нийт 255 хэрэг хүлээн авснаас 134 хэрэг (52.5%) амжилттай, 90 хэрэг (35.3%) амжилтгүй, 31 хэрэг (12.2%) ажиллагаанд байна.

Иргэний хэрэг-80%, гэр бүлийн хэрэг-20%, түүнчлэн нийт хэргийн тоо 2011 оноос 133 хэргээр буюу 2 дахин өсчээ.

Дархан-Уул аймгийн сум дундын шүүхийн эвлэрүүлэн зуучлах хэсэг 2012 он Иргэний хэрэг

№	Хэргийн төрөл	Нийт хүлээн авсан хэрэг	Амжилттай	Амжилтгүй	Ажиллагаанд
1	Зээл	17	8	4	5
2	Түрээс	12	11	1	-
3	Худалдах худалдан авах гэрээ	3	-	-	3
4	СӨХ-ын төлбөр	17	8	-	9
5	Гэм хорын хохирол	1	-	-	1
6	Ажил гүйцэтгэх	-	-	-	-
7	Газар	-	-	-	-
8	Бусад	-	-	-	-
Нийт		50	27	5	18

Гэр бүлийн хэрэг

№	Хэргийн төрөл	Нийт хүлээн авсан хэрэг	Амжилттай	Амжилтгүй	Ажиллагаанд
1	Гэр бүл цуцлалт	4	2	2	-
2	Хүүхдийн тэтгэмж	1	-	1	-
3	Эд хөрөнгө хуваах	-	-	-	-
Нийт		5	2	3	-

Нийт 55 хэрэг хүлээн авснаас 29 хэрэг (52.7%) амжилттай, 8 хэрэг (14.5%) амжилтгүй, 18 хэрэг (32.8%) ажиллагаанд байна.

Иргэний хэрэг- 90.9%, гэр бүлийн хэрэг- 9.1%, түүнчлэн нийт хэргийн тоо 2011 оноос 8 хэрэг(12.6%)-ээр буурсан байна.

Монгол улсын Дээд шүүх, ЖАЙКА болон Монголын өмгөөлчдийн холбооны хамтарсан “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”